



МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ТАМГЫН ГАЗАР



# ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН

2024/ДУГААР 04

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ

ИРГЭДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭН, ЭРҮҮЛ АЖ ТӨРӨХ ХЭВ МАЯГ, ЭРҮҮЛ МЭНДЭЭ ХАМГААЛАХ ЗӨВ ЗАН ҮЙЛИЙГ ТӨЛӨВШҮҮЛЭХ ЗАМААР ӨВЧИН ЭМГЭГ ҮҮСГЭДЭГ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛ, УЧИР ШАЛТГААНЫГ ТАСЛАН ЗОГСООХ ЗЭРЭГ ЧИГЛЭЛЭЭР УЛАМ ЭРЧИМТЭЙ, ИДЭВХ, САНААЧИЛГАТАЙ АЖИЛЛАХ НЬ ЗҮЙТЭЙ ГЭЖ ҮЗДЭГЭЭ ИЛЭРХИЙЛЭВ

МОНГОЛЫН ЭМЧ НАРЫН VII ИХ ХУРАЛ

“НИЙГМИЙН СЭТГЭЛ ЗҮЙН  
ТУЛГАМДСАН АСЧУДЛУУД”

ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨГӨӨН ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД Т.МӨНХСАЙХАН:  
СУРГУУЛЬД СУУРИЛСАН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭРТ ИЛРҮҮЛГИЙГ  
ЗОХИОН БАЙГУУЛАХДАА ХҮҮХДЭД  
ЗӨВХӨН ҮЗЛЭГ ХИЙГЭЭД ОРХИХГҮЙ,  
ЭМЧИЛГЭЭ ХИЙЖ, ХЯНАЛТАД ОРЧУУЛАХ

ЦОГЦ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛЖ БАЙНА

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЭРҮҮЛ  
МЭНД НИЙГМИЙН БОЛЛОГЫН ЗӨВЛӨХ

Б.БАДАМЦЭЦЭГ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛСНЭЭР  
МОНГОЛ ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДЭД  
ТУЛГАМДСАН ОЛОН АСЧУДЛЫГ  
ШИЙДВЭРЛЭХ БОЛОМЖТОЙ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ  
ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ  
ХОЁРДУГААР ТӨВИЙГ БАРИХ АЖИЛД  
ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ АЖЛЫН ХЭСЭГ БАЙГУУЛАГДАВ



**МОНГОЛ ХҮНИЙ ЭРҮҮЛ, ЧАНАРТАЙ ДУНДАЖ НАСЛАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХИЙН ТУЛД ХҮН АМД СУЧУРИЛСАН НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖИЙН ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ**



### **ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН ГЭДЭГ НЬ:**



### **ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ БҮТЭЦ**



### **ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРЧИМ:**

- ✓ Эрүүл чийрэг бие бялдартай
- ✓ Эрүүл саруул оюун ухаантай
- ✓ Эрүүл зан үйл, амьдралын хэвшилтэй
- ✓ Эрүүл орчныг бүтээгч

- ✓ Эрүүл зан үйл
- ✓ Идэвхтэй хөдөлгөөн
- ✓ Эрүүл мэндийн боловсрол
- ✓ Эрүүл хооллолт

- ✓ Судалгаанд суурилсан
- ✓ Олон хувилбарт
- ✓ Салбаруудын уялдааг хангасан
- ✓ Иргэдийн оролцоонд тулгуурласан
- ✓ Инновац, технологийн шинэ шийдлийг ашигласан
- ✓ Хариуцлага, ёс зүйг эрхэмлэсэн
- ✓ Гүйцэтгэл, үр дүнг тооцсон

## НЭГ

### МОНГОЛЫН ЭМЧ НАРЫН VII ИХ ХУРАЛ

- 04** Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх МОНГОЛЫН ЭМЧ НАРЫН VII Их хурлыг нээж үг хэллээ
- 06** Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан Нийгмийн эрүүл мэнд, хүний нөөцийн бүрдүүлэлт, эмийн чанар, салбарын санхүүжилт зэрэг асуудлаар илтгэл хэлэлцүүлээ

## ХОЁР

### ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН

- 09** Монгол Улсын Ерөнхийлөгч Хавдар судлалын үндэсний хоёрдугаар төвийг барих ажилд дэмжлэг үзүүлэх ажлын хэсэг байгуулав
- 11** Монгол Улсын Ерөнхийлөгчийн ахлах зөвлөх Н.Хүрэлбаатарын: Хавдар судлалын үндэсний хоёрдугаар төв нь хавдраас урьдчилан сэргийлэх, эрт үед нь илрүүлж оношлох, эмчлэх, тандалт судалгаа, сургалт зохион байгуулдаг олон улсын стандарт, шаардлагад нийцсэн цогцолбор байх болно
- 14** Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрүүл мэнд, нийгмийн бодлогын зөвлөх Б.Бадамцэцэг: Цэрэг татлагын эрүүл мэндийн үзлэгийг илүү чанартай, өргөн хүрээнд хийж чадвал нийгэмд ажил эрхлэх насны залуусыг төрөл бүрийн өвчлөлөөс урьдчилан сэргийлж чадна

## ГУРАВ

### СУРГУУЛЬД СУУРИЛСАН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТАНДАЛТ

- 20** Монгол улсын хэмжээнд сургуульд суурилсан эрүүл мэндийн тандалтын тогтолцооны суурь тавигдлаа
- 25** Боловсролын сайд П.Наранбаяр: “Эрүүл аюулгүй сургууль” арга хэмжээг ЭМЯ-тай хамтран хэрэгжүүлж байна

## ДӨРӨВ

### ДОНТОХ ЭМГЭГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

- 27** Донтох эмгэгийг илрүүлэх, сэргийлэх, эмчлэх, тусламж үйлчилгээг өргөжүүлэх ажил нийслэлийн дүүргүүд болон аймгуудад эхэллээ
- 34** Монгол улсын ерөнхийлөгчийн зөвлөх, сэтгэц наркологийн эмч АУ-ны доктор Н.Дэмидмаа: “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд архинд донтох эмгэгтэй иргэдийн дунд нөхөн сэргээх эмчилгээний төвийг 21 аймагт болон нийслэлийн есөн дүүрэгт байгуулахаар ажиллаж байна
- 35** Нийгмийн сэтгэл зүйн тулгамдсан асуудлууд” үндэсний зөвлөгөөн төрийн ордонд зохион байгуулагдав



11

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАХИРАМЖААР ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ХОЁРДУГААР ТӨВИЙГ БАРИХАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ

### АЖЛЫН ХЭСЭГ БАЙГУУЛАГДЛАА.

ЕРӨНХИЙЛӨГЧ УХҮРЭЛСҮХ ХАВДРЫН  
ӨВЧЛӨЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,  
НАС БАРАЛТЫГ БУУРУУЛАХ ЗОРИЛГОТОЙ  
ЭНЭ ТӨВИЙГ АЛЬ БОЛОХ БОГИНО  
ХУГАЦААНД БАРЬЖ, АШИГЛАЛТАД  
ОРУУЛАХЫН ТӨЛӨӨ ХИЧЭЭЖ  
АЖИЛЛАХ ҮҮРЭГ ӨГӨВ

## ТАВ

### ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛ

- 38** “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд ЕБС-ийн эрүүл мэндийн багш, арга зүйч бэлтгэж эхлэв
- 42** Жирэмсний бүлгийн хяналтын тогтолцоо хэрэгжиж эхлэв
- 50** Хоол зүйч, доктор, дэд профессор М.Пүрэвжав: Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний жишиг тогтолцоог суурьшуулахаар Увс аймгийг сонгон ажиллаж байна
- 50** Увс аймгийн сургуулийн хоол зүйчдийг чадавхжуулах сургалтад тус аймгийн 19 хоол зүйч хамрагдав.



Эрхлэн гаргагч:  
Ерөнхийлөгчийн Тамгын газар,  
“ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” төсөл,  
хөтөлбөр хариуцсан алба

Ерөнхий эрхлэгч: О.Чимэдсүрэн  
Референт: С.Жаргалсайхан  
Сэтгүүлч: Д.Пэлжид  
Дизайнер: Б.Тамир

Хянасан: Ерөнхийлөгчийн  
Тамгын газар, Баримт  
бичиг, хяналт шинжилгээний  
газрын дарга С.Янжинсүрэн

# МОНГОЛЫН ЭМЧ НАРЫН VII ИХ ХУРАЛ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН

### ИВЭЭЛ ДОР ЗОХИОН БАЙГУУЛАГДАВ



Хурлаар “Эрүүл мэндийн салбарын бодлого, шинэчлэл”-ийн талаар илтгэл сонсож, “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ”, “Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн бодлого, нийгмийн баталгаа, сургалт, инновац” зэрэг сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлж, нэгдсэн дүгнэлт, зөвлөмж гаргав.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх Их хурлыг нээж үг хэллээ. Тэр бээр цар тахлын үед амь биеэ үл хайрлан, цаг наргүй ажиллаж, олон мянган хүний амь насыг аварч, онцгой гавьяа байгуулсан эмч, эмнэлгийн салбарын нийт хамт олон, гэр бүлд нь төр, засаг, ард түмний нэрийн өмнөөс талархал илэрхийлэв.

Сүүлийн жилүүдэд шинэ технологи, инновац, хиймэл оюун ухаанд суурилсан эмнэлгийн тусламж, үйлчилгээ нэвтэрч, ард иргэд эх орондоо дэлхийн жишигт нийцсэн эмчилгээ, оношилгоо хийлгэх боломж нэмэгдэн, зүрх судас, мэдрэл, гэмтэл, хавдар, хүүхдийн нарийн мэргэжлийн оношилгоо, эмчилгээгээр олон улсын түвшинд хүрч байгааг тэмдэглэлээ.

Цаашид энэ салбарын хөгжлийг эрчимжүүлэх, монгол хүний эрүүл мэндийг сахин хамгаалах чиглэлээр анхаарах зүйл байгааг ч хэллээ.

*Эмч нарын VI их  
хурлыг 2019 онд  
Ерөнхий сайдын ивээл  
дор “Эрүүл мэнд-  
хөгжлийн тулгуур”  
уриатай зохион  
байгуулж, салбарын  
тулгамдсан  
асуудлыг дүгнэн  
хэлэлцэж, санал  
бодлоо нэгтгэн,  
зөвлөмж гаргаж  
байсан.*



## ТУХАЙЛБАЛ:

- ✓ Өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх чиглэлд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тогтолцоог улам бэхжүүлэх,
- ✓ Олон улсын жишигт хүрсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэж, гадагшаа чиглэсэн эрүүл мэндийн үйлчилгээний урсгалыг бууруулах,
- ✓ Улс орноо чадварлаг эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнээр бүрэн хангаж, эдийн засгийн зөв хөшүүргээр орон нутаг, сумдад тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл, боломж бүрдүүлэх,
- ✓ Үр дүн, ажлын гүйцэтгэлд суурилсан санхүүжилт болон эрүүл мэндийн даатгалын тогтолцоог улам боловсронгуй болгож, цалин хөлсийг нэмэгдүүлэх, нийгмийн баталгааг хангах,
- ✓ Эмийн үнэ, чанар, аюулгүй байдалд онцгой анхаарах, олон улсын стандарт хангасан эм, эмнэлгийн хэрэгслийг импортлохын зэрэгцээ эх

орондоо үйлдвэрлэдэг болох, иргэдэд эмийн зөв зохистой хэрэглээг хэвшүүлэх,

- ✓ Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэн, эрүүл аж төрөх хэв маяг, эрүүл мэндээ хамгаалах зөв зан үйлийг төлөвшүүлэх замаар өвчин эмгэг үүсгэдэг эрсдэлт хүчин зүйл, учир шалтгааныг таслан зогсоох зэрэг чиглэлээр улам эрчимтэй, идэвх, санаачилгатай ажиллах нь зүйтэй гэж үздэгээ илэрхийлэв.

Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж байгаа “Тэрбум мод”, “Хүнсний хангамж, аюулгүй байдал”, “Эрүүл монгол хүн” гэсэн хоорондоо харилцан уялдаатай үндэсний хөдөлгөөн, ялангуяа “Эрүүл монгол хүн” хөдөлгөөнийг үр дүнд хүргэхэд эмч, эрүүл мэндийн салбарын ажилтан, албан хаагчдын мэдлэг, боловсрол, ур чадвар, хамтын ажиллагаа, манлайлал чухал үүрэгтэйг онцоллоо.

Засгийн газар эрүүл мэндийн салбарын хөгжлийг дэмжих талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоол гаргасан нь VI их хурлын шийдвэр бодит ажил хэрэг болох


эхлэл болсон юм. Өнгөрсөн таван жилд эмнэлгийн тусламж, үйлчилгээнд олон шинэ технологи нэвтрүүлснээр чанар, хүртээмж сайжирч, иргэд эх орондоо оношилгоо, эмчилгээ хийлгэх боломж нэмэгдсэн. Эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэдэг сургалт, эрдэм шинжилгээ, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний цогц тогтолцоо бий болгон, эх орондоо чадварлаг боловсон хүчин бэлтгэх нөхцөл бүрдээд байна.

Нярай хүүхдэд төрөлхийн эмгэг илрүүлэх шинжилгээ хийдэг болж, хүүхэд бүрийг эрт илрүүлэх цогц үзлэгт хамруулан, эрүүл мэндийн салбарт үр дүн, ажлын гүйцэтгэлээр санхүүжилт олгож эхэлжээ. Мөн нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай анхдагч хуулийг УИХ баталж, өвчин эмгэгийг эрт үед нь илрүүлэх, урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлжээ. Улсын хэмжээнд 4,700 гаруй эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаа явуулдаг бөгөөд 15 мянга гаруй их эмч ажиллаж байна.



Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан:

# МОНГОЛ УЛСЫН ХААНА Ч БАЙСАН ЯЛГААГҮЙ 2 ЦАГИЙН ДОТОР ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙГ ИРГЭНДЭЭ ХҮРГЭДЭГ ТОГТОЛЦООНД ШИЛЖИНЭ



Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан Төрийн ордонд болсон Монголын эмч нарын VII их хурлын үеэр нийгмийн эрүүл мэнд, хүний нөөцийн бүрдүүлэлт, эмийн чанар, салбарын санхүүжилт зэрэг асуудлаар танилцуулга хийсэн юм.

Тэрбээр "Эрүүл мэндийг эмнэлгээс хайх биш. Өдөр тутмын амьдралаасаа эрүүл мэндийг хайх хэрэгтэй" хэмээн хэлсэн ДЭМБ-ын Ерөнхий захирлын үгнээс ярианыхаа эхэнд эшлэв.

Сайд Т.Мөнхсайхан танилцуулгадаа, "Сүүлийн жилүүдэд эрт илрүүлгийг нийт иргэдийн дунд зохион байгуулж, 1.5 сая хүнийг хамрууллаа. Илрүүлгийн дүнг харахад, манай иргэдийн дунд өвчлөл өндөр байна. Энэ нь өвчлөмтгий иргэд илүүтэй хамруулсантай холбоотой байж болох юм. Тиймээс бид цаашид бага зардлаар илүү олон өвчлөлийг илрүүлж чадахуйц нийгмийн эрүүл мэндийн цогц бодлогыг хэрэгжүүлж, урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлнэ.

Эрүүл мэндийн салбарт өнөөдөр 66 мянган эмч, эмнэлгийн ажилтан ажиллаж байна. Эмч нарынхаа тоогоор дэлхийд дээгүүрт орж байгаа ч орон нутаг боловсон хүчний дутагдалтай хэвээр байна. Иймд хүний нөөцийн цогц бодлогыг хэрэгжүүлж, орон нутагт ажиллах эмч нарыг тоог нэмнэ. Тухайлбал, ахлах, зөвлөх зэрэг авахын тулд орон нутагт ажилласан байх шаардлагыг тавьж эхэлсэн.

Ирэх жил цалин урамшууллыг

**20%**-иар

нэмэгдүүлж

**2026-2027**

өнөөгийн авч буй цалинг

**100%**

хүртэл нэмэх боломжтой

Эмнэлгийн тусламж үйлчилгээний хүрээнд төвлөрлийг сааруулахад салбарын бодлого чиглэнэ. Тухайн иргэн аль болох ажиллаж амьдарч буй бүс нутгаасаа гаралгүйгээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авдаг болно. Тухайлбал, үндэсний хэмжээнд агаарын болон газрын яаралтай тусламжийг цогцоор нь шийдэж, Монгол Улсын хаана ч байсан ялгаагүй 2 цагийн дотор өвчтөнд яаралтай тусламжийн эмчилгээ үйлчилгээ хүрдэг тогтолцоонд шилжинэ. Багийн түвшинд яаралтай тусламж үзүүлэх чадвартай эмч, эмнэлгийн ажилтнуудыг богино хугацаанд сургаж бэлтгэнэ.

Түүнчлэн орон нутагт хавдрын тусламж үйлчилгээ үзүүлж байгаа бол Улаанбаатар дахь санхүүжилтээс 30-50 хувиар илүү байна гэсэн шийдвэрийг эхнээс нь гаргаж байна. Одоо бид Улаанбаатарт үйл ажиллагаа явуулж байгаа ХСҮТ, Гэмтэл согог судлалын үндэсний төв зэрэг хэдэн эмнэлэг рүүгээ хандаж байна. Үүний оронд шинэ төлөвлөлтийн хүрээнд 14 хот бүрд Нэгдсэн эмнэлгийг бий болгоно. Энэ нь иргэдэд тусламж үйлчилгээ ойртоод зогсохгүй авто замын түгжрэл буурахад нөлөөлнө.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль энэ сараас хэрэгжиж эхэлсэн. Хууль хэрэгжсэнээр нэгдсэн худалдан авалтын тогтолцоонд шилжиж байна. Ирэх сараас эхний ээлжийн эмүүд орж ирнэ. Энэхүү

тогтолцоо нь урт хугацаандаа үр дүнгээ өгнө. Жишээлбэл, Шинэ Зеланд улс 19 жилийн хугацаанд эмийнхээ өртгийг 66 дахин бууруулж чадсан. Тус тогтолцоонд шилжсэнээр Монгол Улсын өнцөг булан бүрд нэг эмийг нэг үнээр адил чанартайгаар борлуулдаг эхлэл тавигдсан гэсэн үг. Цаашдаа бүртгэлийн системээр эм бүрийг хил гаалиар орж ирснээс нь эмийн сангаар борлуулах хүртэлх бүх шатанд хяналт тавьдаг болно. Ингэснээр улсын хэмжээнд эмийн нөөц тасалддаг явдал үгүй болно.

Өнөөдрийн байдлаар, эрүүл мэндийн салбар цахимжсан гэж байгаа боловч үр дүн хангалтгүй байна. Өвчтөн аль ч эмнэлэгт очсон бай, тухайн иргэний мэдээллийг үзэж буй эмч нь цахимаас хардаг болно. Ирэх оноос уг тогтолцоо хэрэгжиж эхэлснээр, эмч өвчтөний хэн хэнд нь цаг хугацаа, мөнгө санхүүгээ хэмнэх бололцоо бүрдэнэ.

Эрүүл мэндийн даатгалын сан алдагдалтай байгаа тул ирэх оны төсөвт тус сангийн мөнгийг 18,6 хувиар өсгөсөн дүнтэйгээр УИХ-д өргөн барьсан. Нэг талдаа сангийн орлогыг нэмэгдүүлэх, нөгөөтэйгүүр зарцуулалтыг оновчтой болгох нь нэн чухал байна. Ирэх жил цалин урамшууллыг 20 хувиар нэмэгдүүлж болохуйц дүр зураг харагдаж байгаа ба 2026-2027 онд өнөөгийн авч буй цалинг 100 хувь хүртэл нэмэх боломжтой" гэлээ.





Монгол Улсын Ерөнхийлөгчийн ахлах зөвлөх, АУ-ны доктор, профессор Н.Хүрэлбаатар Нийгмийн эрүүл мэндийн тухай хууль батлагдаад зургаан сар болж байна. “Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр юу хийх вэ?” “Бодлогын томоохон ямар асуудлуудыг шийдэх гэж байна вэ?” “Улсын хэмжээнд нийгмийн эрүүл мэндийн төв хэзээ байгуулагдах вэ?” “Төвлөрлийг сааруулж ард иргэдэд чанар хүртээмжтэй тусламж үйлчилгээг үзүүлнэ гэж нэлээдгүй ярьж байгаа” “Эмнэлгийн тусламж авахын тулд орон нутгийн иргэд Улаанбаатар хот руу, хотын иргэд гадаад руу явдаг урсгал байсаар байна. Энэ урсгалыг засахын тулд ямар ажил хийгдэж байна вэ?” зэрэг олон нийтээс ирсэн асуултуудыг холбогдох төлөөллүүдээс асууж хариулт авсан юм. Хэлэлцүүлэгт ЭМ-ийн сайдын зөвлөх Л.Төмөрбаатар, ЭМЯ-ны нийгмийн эрүүл мэндийн бодлогын газрын дарга Л.Баттөр, УГТЭ-ийн дарга Ц.Төмөр-Очир, ЭМЯ-ны эмнэлгийн тусламжийн бодлогын газрын дарга Р.Гантуяа нар оролцлоо.

Тэд хэлэхдээ, 2025 ондоо багтаж нийгмийн эрүүл мэндийн төв байгуулах шаардлагатай байна. Бид шинээр зохион байгуулах гэхээсээ илүү олон улсын туршлагыг шууд нэвтрүүлэх нь зүйтэй. Ингэснээр үндэсний хэмжээнд Нийгмийн

## САЛБАР ХУРАЛДААН

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, НИЙГМИЙН БАТАЛГАА, СУРГАЛТ ИННОВАЦ СЭДВЭЭР ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ӨРНҮҮЛЖ НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ ГАРГАЛАА. ТУС ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН АХЛАХ ЗӨВЛӨХ, АУ-НЫ ДОКТОР, ПРОФЕССОР Н.ХҮРЭЛБААТАР УДИРДАВ

эрүүл мэндийн тусламж дүүрэг бүрд байгуулагдана. Өрх, сум бүрд нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн ажиллана. Мөн нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төрөл, чиглэлүүдээр даатгалаас санхүүжилт авах боломж бүрдэж байгаа нь олон жил энэ чиглэлээр цалин хөлсгүй ажиллуулж ирсэн цаг хугацаа ард үлдэх юм гэлээ.

Мөн гол тулгамдсан асуудал бол санхүүжилт байсан гэдгийг онцлоод он гараад хуулийн дагуу даатгалын үндэсний зөвлөлөөс баталсан журмын хүрээнд үйлчилгээ төрөл бүрээрээ санхүүжилт авах боломж бүрдсэн гэдгийг дурдсан юм. Ингэснээр ард иргэд рүүгээ чиглэсэн үр дүнтэй олон ажлууд хийгдэх нөхцөл бүрдэж байгаа юм байна. Түүнчлэн эмнэлгийн тусламж үйлчилгээний төвлөрлийг сааруулах хүрээнд эхний ээлжид хавдрын тусламж үйлчилгээг

байгууллага дотроо сааруулахад гурван сарын дотор 11-27 хувийн үзлэгийн төвлөрөл саарсан байна. Мөн хавдрын тусламж үйлчилгээг байгууллагаасаа гадагш УНТЭ, УХТЭ рүү хувааж сааруулсан байна. Хавдрын тусламж үйлчилгээ үзүүлэх үндэсний төвийг байгуулснаар төвлөрөл саарч байна.

Нийслэлд зүрх судасны өвчлөлийн төвлөрлийг сааруулах ажлын хүрээнд зүрх судасны болон бусад чиглэлээр үндэсний багууд байгуулагдлаа. Үндэсний багууд УНТЭ, УХТЭ, УГТЭ, Цэргийн төв эмнэлэг, Монгол-Японы эмнэлгүүд дээр төвлөрлийг сааруулан ажиллаж байна. Мөн үндэсний хэмжээнд нийт 13 багийг гадаад руу явуулж сургаж эхэлсэн. Гадагшаа явж эмчлүүлж байгаа 26 нэр төрлийн оношийг эх орондоо эмчлэх боломж бүрдэж байгааг хэлэлцүүлэгт оролцогч талууд онцолсон юм.

# МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

## ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ХОЁРДУГААР ТӨВИЙГ БАРИХ АЖЛЫГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛ ӨГӨВ

■ Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2024 оны 12-р сарын 16-ны өдрийн 47-р захирамжаар Хавдрын урьдчилан сэргийлэлт, оношилгоо, эмчилгээ, эрдэм шинжилгээ, сургалтын цогцолбор бүхий “Хавдар судлалын үндэсний хоёрдугаар төв” байгуулахад дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулав.

■ Нийслэлийн засаг даргын 2024 оны 12-р сарын 20-ны өдрийн А/1504 тоот захирамжаар УБ хотын СХД-т ХСҮХТ-ийг байгуулах 12000м<sup>2</sup> газрыг шийдвэрлэв.



### ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ОДООГИЙН БАРИЛГА НЬ

**20,000м<sup>2</sup>** талбайтай

**489** эмч, ажиллагсадтай

**1982** онд буюу

**43** жилийн өмнө баригдсан

- ▼ **228** хэвтүүлэн эмчлэх ортой
- ▼ **12** эмчилгээний тасаг
- ▼ Оношилгооны **12** тасаг,
- ▼ Амбулаторийн үзлэгийн **30** кабинеттай
- ▼ Өдөрт **800-1,000** жилдээ давхардсан тоогоор **240,000** гаруй хүнд хавдрын тусламж үйлчилгээг үзүүлж байна.



### ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ХОЁРДУГААР ТӨВИЙН ШИНЭ ЦОГЦОЛБОР НЬ

▲ **95,308м<sup>2</sup>** талбайтай

▲ **1,500** эмч, ажиллагсадтай

(ажиллагсдыг ирэх сараас АНУ-ын Ютагийн их сургуультай хамтран сургаж эхэлнэ)

▲ **600** ор бүхий хавдрын тусламж үйлчилгээ үзүүлэх эмнэлгийн барилга, ажилчдын орон сууц болон өвчтөн, үйлчлүүлэгчийн байр зэрэг барилга байгууламжаас бүрдэнэ.

МОНГОЛ УЛСЫН  
**1980 ОНЫ** НӨХЦӨЛ БАЙДЛЫГ  
ОДООГИЙН БАЙДАЛТАЙ  
ХАРЬЦУУЛАХАД

ХҮН АМЫН ТОО  
**2.2** ДАХИН

ӨВЧЛӨЛ  
**7** ДАХИН

НАС БАРАЛТ  
**6.3** ДАХИН  
ИХЭССЭН



# Монгол Улсын Ерөнхийлөгч УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ

Хавдрын өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, нас баралтыг бууруулах зорилготой энэ төвийг аль болох богино хугацаанд барьж, ашиглалтад оруулахын төлөө хичээж ажиллах үүрэг өгөв.

Хавдар судлалын үндэсний хоёрдугаар цогцолбор төвд эрхтэн шилжүүлэх, үүдэл эс шилжүүлэн суулгах, тархи мэдрэлийн хавдрын, ховор тохиолдох хавдрын, ясны хавдрын, урологийн хавдрын төв, хүүхдийн хавдрын, нөхөн сэргээх мэс заслын эмчилгээний, хөнгөвчлөх эмчилгээний, протон эмчилгээний, туяа эмчилгээний (ИМРТ), ангиографийн, цөмийн оношилгооны, дурангийн, хими эмчилгээний, урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн, хавдрын нөхөн сэргээх, робот мэс заслын төв, бүрэн автомат эмнэлзүйн болон эмгэг судлалын лаборатори байгуулагдана. Мөн тус цогцолбор төвд судалгаа шинжилгээний төвүүд ажиллах болно. Шинэ цогцолборын тасаг, нэгж бүрийг өндөр технологи, инновац шингэсэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр иж бүрэн тоноглноор Хавдрын эмчилгээ оношилгоогоор өөр улс орон явж эмчлүүлэх шаардлагагүй болох юм.

Хавдрын урьдчилан сэргийлэлт, оношилгоо, эмчилгээ, эрдэм шинжилгээ сургалтын цогцолбор бүхий хоёрдугаар төвийг Сонгинохайрхан дүүргийн 34 дүгээр хороо, Баянголын аманд 2-3 жилийн дотор ашиглалтад оруулна.

## ХАВДРЫН ӨВЧЛӨЛИЙН ӨНӨГИЙН БАЙДАЛ:

Хорт хавдрын шалтгаант нас баралтын тохиолдлоор (100,000 хүн амд 181.5) Монгол улс дэлхийд тэргүүлж байгаа тул хорт хавдраас сэргийлэх, хянах ажлыг эрчимжүүлэх, оновчтой болгох, шинэ техник, технологи, инновац нэвтрүүлэх нь Монгол улсын тулгамдсан асуудлуудын нэг болоод байна. Сүүлийн жилүүдэд хавдрын өвчлөл болон нас баралт Монгол Улсад хурдацтай нэмэгдэж байна.

ХАВДРЫН ШАЛТГААНТ НАС БАРАЛТ  
НИЙТ НАС БАРАЛТТАЙ ХАРЬЦУУЛАХАД  
**ДЭЛХИЙД**  
**17%**

**МАНАЙД**  
**24%**

ХОРТ ХАВДРААР ӨВДСӨН  
ИРГЭДИЙН  
**70%**

хожуу шатандаа оношлогддог

Монгол улсад хорт хавдар нь хүн амын нас баралтын

**29%** -ийг

дангаараа эзэлж байна

**Нас баралтын  
2 дахь шалтгаан болж  
хувь хүн, нийгэм, эдийн засагт  
дарамт болсоор байна**

2023 оны байдлаар хорт хавдрын өвчлөлийн 7,244 шинэ тохиолдол, нас баралтын 4,556 тохиолдол бүртгэгдэж байна. Улмаар хорт хавдраар оношлогдсон хүмүүсийн 62% нь нэг хүрэхгүй жил амьдарч байна.

Хорт хавдраас сэргийлэх, хянах оновчтой бодлого, хөтөлбөрийг цаг алдахгүй авч хэрэгжүүлэхгүй тохиолдолд **2040 онд** манай улсын хорт хавдрын өвчлөл, нас баралт **2 дахин** өсөх тооцооллыг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын дэргэдэх Глобал сан гаргажээ.

Эрүүл мэнд болон Сангийн яамны 2019 онд хийсэн хамтарсан судалгаагаар 21,636 хүн (дунджаар нэг хүн 25,000-30,000 ам.доллар) гадаад улс оронд очиж 600 сая гаран ам долларыг эмчилгээ оношилгоонд зарцуулсан байна. Үүний ихэнх хувь нь хавдрын шалтгаантай бөгөөд иргэд гадаад улс орныг зорьж байгаа нь Монгол Улсад үзүүлж буй хавдрын тусламж үйлчилгээний төрөл хязгаарлагдмал, чанар, хүртээмж хангалтгүй байгаатай холбоотой.

Ерөнхийлөгчийн ахлах зөвлөх Н.Хүрэлбаатар тэргүүтэй Ажлын хэсэгт Сангийн сайд Б.Жавхлан, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, УИХ-ын гишүүн Ж.Чинбүрэн, Н.Алтаншагай, Л.Мөнхбаясгалан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга У.Бямбасүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Цөмийн энергийн комиссын нарийн бичгийн дарга Г.Манлайжав, АШУУИС-ийн захирал Б.Дамдиндорж, Хавдар судлалын үндэсний төвийн ерөнхий захирал Н.Эрдэнэхүү нар багтсан юм. Ажлын хэсэг хоёрдугаар төвийн бүтээн байгуулалтыг мэргэжил, арга зүйгээр хангаж, дэмжлэг үзүүлнэ. Мөн хавдар үүсгэж байгаа шалтгаан, нөхцөлийг таслан зогсоох, салбар дундын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, олон улсын жишигт нийцсэн тусламж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэх чиглэлээр ажиллах юм.



# ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ХОЁРДУГААР ТӨВ НЬ ХАВДРААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРТ ҮЕД НЬ ИЛРҮҮЛЖ ОНОШЛОХ, ЭМЧЛЭХ, ТАНДАЛТ СУДАЛГАА, СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛДАГ ОЛОН УЛСЫН СТАНДАРТ, ШААРДЛАГАД НИЙЦСЭН ЦОГЦОЛБОР БАЙХ БОЛНО



■ Монгол Улсын Ерөнхийлөгчийн ахлах зөвлөх, АУ-ны доктор, профессор Н.Хүрэлбаатар

**Монгол Улсын Ерөнхийлөгч Хавдар судлалын үндэсний хоёрдугаар төв байгуулах томоохон бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэхэд хүч нэмэх боллоо? Үүнээс харахад тус том бүтээн байгуулалтын ажилд улсаараа хөдлөх нь?**

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх ерөнхий сайдаар ажиллаж байх үеэсээ л хавдар үүсгэдэг шалтгаануудыг таслан зогсоох, судалгаа шинжилгээний ажлуудыг эрчимжүүлэх, өдрөөс өдөрт ачаалалтай болж байгаа эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлд онцгой анхааран ажиллаж ирсэн.

Манай улсад хавдрын зарим тусламж үйлчилгээний чанар, хүртээмж хангалттай биш байна. Тиймээс хавдрын оношилгоо, эмчилгээ хийлгэх гэж гадагшаа явах иргэдийн тоо, мөнгөний урсгал нэмэгдсээр байна. Манай иргэд нэг жилд 500 орчим сая доллар гадаадад оношлуулах, эмчлүүлэхэд зарцуулж байгаа судалгаа бий. Энэ нь олон хавдар судлалын эмнэлэг барих төсөв юм.

Түүнчлэн хорт хавдрын өвчлөлийн 7,244 шинэ тохиолдол, нас баралтын 4,556 тохиолдол 2023 оны байдлаар бүртгэгдсэн байна. Хорт хавдраар оношлогдсон хүмүүсийн 62% нь нэг жил хүрэхгүй амьдарч байгаа нь судалгаагаар тогтоогдсон.

Иймээс хавдарт өвчнийг бууруулах, олон улсын түвшинд хүрсэн

оношилгоо, эмчилгээ, эрдэм шинжилгээ, тандалт судалгаа, сургалтын цогцолбор төвийг байгуулах ажил Монгол Улсын Ерөнхийлөгчийн манлайлал дор хэрэгжихээр болсон. Монгол Улсын Ерөнхийлөгчийн захирамжаар хавдар судлалын үндэсний хоёрдугаар төвийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх, богино хугацаанд бодит үр дүнд хүргэхэд дэмжлэг үзүүлэх ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

**-Хавдар судлалын үндэсний төв байгуулагдсанаар хавдрын өвчлөл буурах уу? Тус төв зөвхөн эмчилгээ, тусламж үйлчилгээний чиглэлд үйл ажиллагаа явуулах уу?**

Юуны түрүүнд, хавдрыг үүсгэж байгаа шалтгааныг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, эрт үед нь илрүүлж эмчлэх зорилгоор нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог улам бэхжүүлэх үйл ажиллагаа хийгдэж байгаа. Үүний зэрэгцээ ард иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, амьдралын эрүүл, зөв дадлыг төлөвшүүлэх нь чухал юм. Ингэснээр хүн амын амьдралын чанар сайжирч, дундаж наслалт уртсах юм.

Хавдрын өвчлөл 2040 он гэхэд хоёр дахин нэмэгдэнэ гэсэн тооцооллыг ДЭМБ хийгээд байна. Энэхүү судалгаанаас харахад манай улсад хавдрын өвчлөл өндөр байгаа төдийгүй цаашид улам нэмэгдэх хандлагатай байгаа нь дэвшилтэд технологи бүхий хавдар судлалын шинэ төв байгуулах зайлшгүй

Манай улсад жилд

**7,244 хүн**

хорт хавдраар өвчилж,

**4,556 хүн**

нас бардаг



хэрэгцээ үүсээд байна.

Энэ хавдар судлалын үндэсний хоёрдугаар төв нь хавдраас урьдчилан сэргийлэх, эрт үед нь оношлох, эмчлэх, тандалт судалгаа, сургалт зохион байгуулдаг олон улсын стандарт, шаардлагад нийцсэн цогцолбор байх болно.

Дээр нь гадагшаа оношилгоо, эмчилгээнд явах манай иргэдийн урсгалыг зогсоож, Монгол Улсын эдийн засагт ихээхэн хувь нэмэр оруулах юм.

**- Харин Хавдар судлалын үндэсний хоёрдугаар төвийг байгуулах, дэмжиж ажиллах ажлын хэсгийг та ахалж ажиллаж байгаа. Одоогийн Хавдар судлалын үндэсний төв таны аав Нямдаваагийн нэрэмжит гэж овоглогддог. Таны аав Монгол Улсад хавдар судлалын төвийг байгуулалцаж явсан цөөн хүмүүсийн нэг байхаа?**

Монгол Улсад Хавдар судлалын төв 1982 онд ашиглалтад орж, үйл



ажиллагаагаа эхлүүлсэн түүхтэй. Энэ нь манай улсын эрүүл мэндийн салбарт хийгдсэн том бүтээн байгуулалт байлаа. Аав минь эрүүл мэндийн салбарт 44 жил, ХСҮТ-ийн захирлаар 18 жил ажиллаж байхдаа энэ төвийг байгуулах үйл хэрэгт манлайлан гар бие оролцож байсан. Мөн Монгол Улсад хавдар судлалын албыг хөгжүүлэх, хавдраас урьдчилан сэргийлэх, хавдрын оношилгоо, эмчилгээг чанар, хүртээмжтэй болгох, мэдлэг чадвартай эмч, эмнэлгийн ажилчдыг бэлтгэх, эрдэм шинжилгээ, тандалт судалгаа хийх тогтолцоог бий болгох ажлыг удирдан зохион байгуулж ажилласан хүн юм.

Харин 43 жилийн дараа Хавдар судлалын үндэсний хоёрдугаар төвийг байгуулах төслийн ажлын хэсгийг ахлаад явж байгаа нь миний хувьд том хувь заяа гэж бэлгэшээж байна. Иймээс би энэ үйл хэргийг бүтээхийн төлөө сэтгэл гаргаж, зүтгэж ажиллана.

**–“Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний гол зорилго юунд чиглэж байна вэ?**

“Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний гол зорилго бол Монгол Улсад нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог улам бэхжүүлэх явдал юм. Энэ нь аливаа өвчин эмгэг үүсгэх шалтгааныг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн тогтолцоог хөгжүүлэх, ард иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгож, амьдралын эрүүл, зөв дадал хэвшлийг төлөвшүүлэх асуудал юм.

Түүнчлэн, монголчууд бид аливаа өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх,

эрүүл амьдрах наад захын мэдлэг, чадвар эзэмшиж, эрүүл мэндийн салбараа дэмжин хамтран ажиллаж, эрүүл, чийрэг иргэн байх нь чухал байна.

Нэн ялангуяа төр засгаас зохион байгуулж буй эрт илрүүлэгт ард иргэд өөрсдөө хариуцлагатай, идэвхтэй оролцох шаардлагатай.

Дахин дүгнэн хэлэхэд “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн бол иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх, чанартай дундаж наслалтыг уртасгах үндсэн зорилготой юм.

**–“Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөнийг өргөжүүлэх талаар таны санал юу байна вэ?**

“Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн нь түр зуурын аян биш тогтолцоо болж, он удаан жил үргэлжлэх үйл ажиллагаа юм. Тус хөдөлгөөн гараанаас гарахдаа өмнөө тавьсан зорилго, зорилтын хүрээнд олон төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байгаа. Энэ хөдөлгөөний хүрээнд нэмж олон ажил санаачлахаас илүүтэй төлөвлөгөөний дагуу одоо хийгдэж байгаа ажлуудыг үр дүнд хүргэж, тогтолцоо болгон үлдээх нь туйлын чухал байна.

**–Нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэхэд Эрүүл Монгол хүн үндэсний хөдөлгөөний үүрэг юу вэ?**

Дахин хэлэхэд бид өвчин эмгэг үүссэний дараа хойноос нь хөөгөөд ямар ч үр дүнд хүрэхгүй. Иймээс “Эрүүл Монгол хүн” хөдөлгөөний үндсэн зарчим нь өвчин эмгэг үүсэхээс өмнө урьдчилан

сэргийлж, түүнийг үүсгэж байгаа шалтгаануудыг таслан зогсоох явдал юм.

Хамгийн чухал нь нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог улам бэхжүүлж, ард иргэд аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх тал дээр эмч, эмнэлгийн ажилтан, төр засагтайгаа хамтран ажиллаж, өвчнийг ялан дийлэх асуудал юм. Ингэснээр эрүүл мэндийн салбарын хэт их ачаалал буурах, ард иргэд эрүүл саруул, чанартай амьдрах нөхцөл бүрдэнэ.

Үүнийг хэрэгжүүлэхийн тулд “Эрүүл Монгол хүн” хөдөлгөөн нь 7 үндсэн чиглэлээр тодорхой ажлуудыг хийж, бодит үр дүнд хүрч эхлээд байна.

**–Хэн нэгэн болоод цаг хугацаанаас үл хамаарах тогтолцоо бүрдүүлэх талаар та дурдлаа. Тогтолцоо бүрдүүлж үлдээхэд ямар хүчин зүйлс шаардлагатай вэ?**

Бидний хэрэгжүүлж байгаа “Эрүүл Монгол хүн” хөдөлгөөн нь хэн нэгэн хувь хүн, цаг хугацаанаас хамаарахгүй урт хугацаанд хэрэгжиж, үр дүн гаргадаг байх ёстой. Иймийн тулд тогтолцоог бий болгон хөгжүүлэх нь чухал. Аливаа тогтолцоог бүрдүүлэхэд эрхзүй, хүний нөөц, дэд бүтэц, сургалт сурталчилгаа, санхүүжилтийн механизм зэрэг таван зүйлд анхаарах учиртай.

Тодруулж хэлбэл нэгдүгээрт, эрхзүйн орчныг боловсронгуй болгож шинэчлэх; хоёрдугаарт, мэдлэг чадвартай хүний нөөц бэлтгэх; гуравдугаарт, шаардлагатай дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэх; дөрөвдүгээрт, ард иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, амьдралын зөв дадлыг бий болгох чиглэлээр цогц сургалт, сурталчилгааг зохион байгуулах; тавдугаарт, санхүүжилтийн зөв механизмыг бүрдүүлэх хэрэгтэй. Эдгээрийн аль нэгийг нь орхигдуулбал тогтолцоо болж, он удаан жил хэрэгжих боломжгүй болно.

Аав минь  
эрүүл мэндийн салбарт

**44 жил**  
ажиллахдаа

**18 жилд нь**

**ХСҮТ-ийн захиралаар  
ажиллаж Монгол Улсад  
хавдар судлалын алба,  
хавдрын эмчилгээ  
үйлчилгээг бэхжүүлэх,  
эмч, эмнэлгийн ажилчдыг  
бэлдэх, шинэ байран  
оруулах ажлыг зохион  
байгуулсан хүн юм.**

**-Та АШУҮИС-ийн захирал, Эрүүл мэндийн сайд зэрэг хариуцлагатай албуудыг хашиж явсан хүн. Тогтолцоо болон үлдэж хүнээс үл хамааран хэрэгжиж буй сайн жишгээс та дурдахгүй юу?**

Манай эрүүл мэндийн салбарын тогтолцооны хувьд олон улсад жишиг болохуйц сайн тогтолцоотой. Иймээс бид аливаа цар тахал, нийтийг хамарсан өвчин эмгэгийн үед хурдан шуурхай арга хэмжээ авч, нэгдсэн зохион байгуулалтад орж, аливаа үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлж чаддаг. Н1N1-н халдвар, Ковид цар тахлын үед ч бид эрүүл салбарын энэ тогтолцооны ачаар хохирол багатай даван туулсан.

Гэхдээ энэ тогтолцоог улам бэхжүүлж, олон улсын зарим сайн загвар, тэргүүн туршлагыг нэвтрүүлэх нь зүйтэй.

Таны асуултад хариулт болгож хамгийн сүүлийн жишээг дурдъя. Шинээр төрсөн хүүхэд бүрийг төрөлхийн эмгэгтэй эсэхийг тогтоох, оношлох тогтолцоог Монгол Улсад бий болгосон. Энэ хүрээнд дээр дурдсан тогтолцоог бий болгоход шаардлагатай 5 зүйлийг цогцоор нь шийдсэн. Энэ мэтчилэн олон сайн туршлага манай улсад бий.

**-“Эрүүл Монгол хүн” хөдөлгөөний хүрээнд эрүүл хүнсээр хангах асуудал дээр онцгой анхаарч ажиллаж байна. Хүнсний аюулгүй байдлын тал дээр пестицидийн асуудал хурцаар яригдах болсон.**

**Харин манай улсын гааль дээр пестицидийг шинжлэх талаар ямар түвшинд ажиллаж байна вэ?**

Иргэдийг эрүүл хүнсээр хангах тал дээр онцгой анхаарч ажиллах нь “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний үндсэн зорилтуудын нэг юм. **Хүнс эрүүл бол хүн эрүүл байна.**

Олон улсын эрдэмтэд пестицидийг олон өвчний шалтгаан болж байгааг тогтоосон. Нэн ялангуяа олон төрлийн хавдар үүсгэх үндсэн шалтгаан болж байна.

Иймээс пестицидийн зөв хэрэглээ, стандартыг мөрдөж ажиллах, импортын бүтээгдэхүүний хяналтын тогтолцоог улам бэхжүүлэх, ард иргэдийн энэ талаарх боловсролыг дээшлүүлэхэд анхааран ажиллаж байгаа.

Энэ хүрээнд пестицидийг чанарын болон тоон үзүүлэлтээр тодорхойлж, химийн бодисын хэмжээг зөв тогтоодог болох нь ард иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, пестицидийн хордлогоос урьдчилан сэргийлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх юм.

Иймээс ч Ерөнхий сайдын захирамжаар Шадар сайдаар ахлуулсан пестицидийн хяналтын тогтолцоог бэхжүүлэх, стандартыг мөрдөж ажиллах чиглэлээр ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Пестицидийн талаар жишиг болохуйц тогтолцоо бүрдэж, бодит үр дүнд хүрнэ гэдэгт итгэлтэй байна.


**-Эрүүл Монгол хүн үндэсний хөдөлгөөний дэргэд эрдэмтдийн зөвлөл байгуулагдаж байгаа талаар тодруулах гэсэн юм?**

“Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний дэргэд мэдлэг, чадвар, туршлагатай тэргүүлэх эрдэмтдээс бүрдсэн эрдэмтдийн зөвлөл ажиллах болно. Нотолгоо, шинжлэх ухаанд суурилсан бодлого боловсруулахдаа бид тэргүүлэх эрдэмтдийн үгийг сонсож, хамтран ажиллана. Жишээ нь Монгол Улс төдийгүй дэлхий нийтийн тулгамдсан асуудал болоод байгаа чихрийн шижин, сэтгэцийн эрүүл мэнд гэх мэт чиглэлээр ажилладаг, судалгаа хийдэг эмч, эрдэмтэн доктор, профессорууд тус зөвлөлд ажиллаж байж нийтийн эрүүл мэндийг хамгаалах зөв бодлого гаргаж, тухайн тулгамдсан асуудлаар бодит үр дүнд хүрэхэд дөхөм болно.

**- Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй хөдөлгөөнүүд үндэсний хэмжээнд хэрэгжиж байна. Та Ерөнхийлөгчийн ахлах зөвлөхийн хувиар цаашид үр дүнд хүргэхийн тулд ямар бодлого барих вэ?**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилга, манлайлал дор хэрэгжиж буй зургаан хөдөлгөөн нь байнгын үйл ажиллагаатай, урт хугацаанд хэрэгжих тогтолцоо болон үлдэх ёстой. Үүний тулд ерөнхийлөгчийн зөвлөхүүд, манай баг хамт олон хэрэгжүүлж буй үйл ажиллагаа бүрийг тогтолцоо болгон үлдээх зорилго тавин ажиллаж, зохих үр дүнд хүрээд байна.

*Бидний урилгыг хүлээн авч ярилцлага өгсөнд баярлалаа.*





## ЦЭРЭГ ТАТЛАГЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГИЙГ ИЛҮҮ ЧАНАРТАЙ, ӨРГӨН ХҮРЭЭНД ХИЙЖ ЧАДВАЛ НИЙГЭМД АЖИЛ ЭРХЛЭХ НАСНЫ ЗАЛУУСЫГ ТӨРӨЛ БҮРИЙН ӨВЧЛӨЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЖ ЧАДНА

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Эрүүл мэнд, нийгмийн бодлогын зөвлөх  
**Б.Бадамцэцэг:**

### **-Монгол хүний эрүүл мэндийн хамгийн тулгамдсан асуудал юу байна вэ?**

-Монгол хүний эрүүл мэндэд тулгамдсан асуудал бол эрүүл мэндийн боловсрол юм. Өвчлөлөөс хэрхэн сэргийлэх, эм бэлдмэл, эрдэс минералыг яаж хэрэглэх, дасгал хөдөлгөөн хийх талаар мэдлэг дутмаг байна. Эдгээр мэдлэг дутуу байдал өвчлөлд хүргэх суурь шалтгаан болж байна. Монгол хүний өвчлөл өндөр байгаа шалтгааныг би яагаад эрүүл мэндийн боловсролтой холбож байна вэ гэхээр ЕБС-д эрүүл мэндийн хичээл дутмаг ордог мөн иргэд оновчтой үнэн зөв мэдээллээр хангагдахгүй, ашиг хонжоо харсан чанарын шаардлага хангахгүй эм тариа, бүтээгдэхүүн борлуулагч нар буруу мэдээлэл түгээдэг. Мөн эрүүл мэндийн боловсролд чигэлсэн контент, нэвтрүүлэг маш бага байна.

Өөрөөр хэлбэл эрүүл мэндийн боловсролгүй залуу үе бэлтгэгдэж байна. Хүүхэд залуус эрүүл мэндийн оновчтой зөв мэдээллийг авахуйц платформ алга. Тиймээс сошиал ертөнцөд байгаа эрүүл мэндийн буруу ташаа мэдээлэл иргэдийг төөрөгдөлд оруулж байна. Иргэд худал мэдээлэлд хэрхэн автахгүй байх вэ гэхээр эрүүл мэндийн боловсрол тусална. Мөн эрүүл мэндийн сувгуудаар гарсан мэдээллүүдийг үнэн зөвийг ялгаж шалгадаг болно. Энэ ажлын хүрээнд ЭМЯ болон “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний сайтаас эрүүл мэндийн үнэн зөв мэдээллийг иргэд хүлээн авах боломж бүрдэнэ.

**“Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний дөрвөн бүрэлдэхүүний нэг болох эрүүл мэндийн боловсролын чиглэлд хэрэгжиж буй ажлын явцыг тодруулахгүй юу?**



# ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛСНЭЭР МОНГОЛ ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДЭД ТУЛГАМДСАН ОЛОН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ БОЛОМЖТОЙ



Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй Эрүүл Монгол хүн үндэсний хөдөлгөөний чухал бүрэлдэхүүний нэг нь Эрүүл мэндийн боловсрол юм. Иргэдийн эрүүл мэндийн боловсролд хувь нэмэр оруулах олон ажлыг “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний 2025 оны төлөвлөгөөнд тусгасан. Өнгөрсөн хугацаанд “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд Боловсролын байгууллагад эрүүл мэндийн хичээл заах эрүүл мэндийн багш-арга зүйч бэлтгэх сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэхээр АШУҮИС, МУБИС-с хамтарсан баг ажиллаж байна. БЯ бодлогоор дэмжин тус хөтөлбөрийн индексийг баталж, баг шуурхай ажиллаж тус хөтөлбөрийг Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлөөр магадлан итгэмжлүүлсэн. 2024 оны хичээлийн жилд тус хөтөлбөрт суралцахаар 32 оюутан элсэж хөтөлбөрийн нээлтээ хийсэн.

Мэргэшсэн эрүүл мэндийн багш бэлтгэхийн зэрэгцээ 2024 оны Эрүүл Монгол хүн үндэсний хөдөлгөөний хүрээнд цэцэрлэг, сургуулийн эмч, нийгмийн ажилтан, хоол зүйчийг чадавхжуулах эхний сургалтууд хийгдэж байна. Цаашид бид элсэгчдийн тоог нэмэгдүүлэхийн тулд орон нутгийн оролцоог хангана. Мөн нийслэл, орон нутгийн нийт 800 гаруй ЕБС-ийг эрүүл мэндийн багшаар хангахад олон жил шаардагдах бөгөөд энэ хугацаанд хүүхдүүдийн эрүүл мэндийн боловсролыг орхи г дуулахгүйгээр чанартай боловсрол олгох тал дээр одоо ажиллаж буй эрүүл мэндийн багийг чадавхжуулах ажлыг улам эрчимжүүлэх нь чухал юм.

**-ЕБС-ийн сурагчдын 80 гаруй хувь нь шүдний эрүүл мэндийн асуудалтай гэсэн судалгаа гарчээ. Үүний шалтгаан нь юу байна вэ?**

Үүний суурь шалтгааныг эрүүл мэндийн боловсролтой холбоотой гэж бодож байна. 2014 онд “Хорхой цоорол” хэмээх хүүхдийн анимэйшн бүхий дуу гарч маш өндөр үзэлт авч байсан. Үүнээс хойш хүүхдэд зориулсан үзэж сонсдог дуугаар нь дамжуулж эрүүл мэндийн боловсрол олгодог бүтээлүүд маш дутмаг байна. “Хорхой цоорол” шүдний дууг одоо хүртэл цэцэрлэгүүд хүүхдүүдэд үзүүлдэг. Тэгэхээр бид хүүхдүүдэдээ нас насанд нь тохирсон видео, дуу, анимэйшн зэрэг контентуудаар дамжуулж эрүүл мэндийн боловсрол, амьдралын зөв дадлыг суулгах боломж байгаа юм. Эрүүл мэндийн боловсрол руу чиглэсэн олон нөлөөллийн ажлууд хийгдэнэ. Энэ нь эрүүл байх үндэс суурь болж өгнө. Шүд эрүүл бол бие эрүүл гэж хүн бүр мэддэг хэр нь өдөр тутмын дадал зуршил байдаггүйгээс шүдний эрүүл мэнд алдагддаг. Шүдээ угаа гэхээр хүүхдэд хэцүү ажил мэт ойлгогддог. Бага байхаас нь шүдний сойз, ооны ач тус хэрэглээг хүүхдэд зөв ойлгуулчихвал тэдэнд илүү амар юм. Хүүхэд бол эцэг эхийн толь. Аав ээжүүд хүүхдэдээ шүдээ угаа гэхийн оронд хүүхдийнхээ дэргэд шүдээ угаачихад л хүүхэд даган дуурайна. Энэ нь хараагаар дамжуулж шүд угаах боловсрол, дадал суулгах нэг хэлбэр юм. Шүдний эрүүл мэнд чухал гэдгийг хүмүүс мэддэг ч дийлэнх нь шүдний цооролтой байдаг. Ивате Анагаах Ухааны Их Сургуулийн Шүдний Төвийн Шүдний

## “ ШҮД ЭРҮҮЛ БОЛ БИЕ ЭРҮҮЛ ГЭЖ ХҮН БҮР МЭДДЭГ ХЭР НЬ ӨДӨР ТУТМЫН ДАДАЛ ЗУРШИЛ БАЙДАГГҮЙГЭЭС ШҮДНИЙ ЭРҮҮЛ МЭНД АЛДАГДАГ ”

Эмнэлэгт шүдтэй (5 эрэгтэй, 8 эмэгтэй, 81.8±1.24 нас) болон шүдгүй (4 эрэгтэй, 7 эмэгтэй, 77.1±4.25 нас) дээр хийсэн WM-ийн бүтцийн зургийн шинжилгээ нь шүдтэй болон шүдгүй хүмүүсийн хооронд морфологийн ялгаа олдсонгүй. Гэсэн хэдий ч шүдгүй хүмүүст гипокамп, каудатын цөм, баруун тархины түр зуурын туйлд GM-ийн мэдэгдэхүйц хатингиршил ажиглагдсан. Энэхүү судалгааны үр дүнгээс харахад ой санамж, суралцах, танин мэдэхүйтэй холбоотой тархины хэсгүүдийн эзлэхүүнийг багасгах шалтгаан нь шүд уналтаас үүдэлтэй болохыг харуулж байна. Гэтэл өнөөдөр манай Монгол Улсад хүүхдүүд сүүн болоод байнгын шүдээ их авхуулж байна. Монгол хүний шүдний өвчлөл үндэсний аюулгүй байдлын хэмжээнд яригдах түвшинд очсон гэж би хардаг.

### **-Хүн амын шүдний эрүүл мэндийг дээшлүүлэх хүрээнд ямар ажил төлөвлөж байна вэ?**

Шүдний үндэсний төв байгуулах томоохон ажил судалгааны түвшинд явж байна. Ард иргэд шүдний эмчилгээ үйлчилгээ үнэтэй байгаагаас үйлчилгээ авч чадахгүй байгаа асуудал үндэсний хэмжээнд шүдний төв байгуулагдсанаар шийдэгдэнэ. ЭМЯ болон түүний харьяа газрууд нэгэнт өвчилсөн иргэдээ бодлогын дор эмчилж эрүүлжүүлээд явж байна. Эрүүл мэндийн салбарынхан бүх цаг үед өндөр ачаалалтай ажиллаж ирсэн. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн нь хүн амынхаа эрүүл сегмент рүү чиглэж ажиллана.

### **-Эрсдэлгүй Монгол өрх хөтөлбөрийн хүрээнд “Эрүүл эрчүүд” гэж тусад нь авч үзэж байгаа шалтгаан юу вэ? Манай улсын эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүү 10 жилээр хэмжигдэж байгаатай холбоотой юу?**

-Монгол эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүү 9.5 байгаа. Энэ нь олон шалтгаантай. Эрэгтэйчүүдийн нас баралтад хамгийн их нөлөөлж байгаа хүчин зүйл нь архи, согтууруулах ундааны хэтрүүлсэн хэрэглээ, тамхидалтын сөрөг нөлөө байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 43 дугаар зарлигийн хүрээнд хэрэгжиж буй архи дан согтууруулахтай тэмцэх ажил илүү



өргөн хүрээнд хийгдэж байна. Тус ажлын хүрээнд “Сэтгэц нийгмийн сэргээн засах” төв байгуулагдаж донтох эмгэгтэй иргэдэд эмчилгээ үйлчилгээг хүргээд эхэлсэн. Тус ажлыг нийслэлийн 9 дүүрэг, 21 аймагт өргөжүүлэхээр ажиллаж байна. Мөн цэргийн насны залуус эмэгтэйчүүд болон мөрдөстэй алба хаагчдын эрүүл мэндэд анхаарч ажиллана. Таван жилийн дунджаар 200 мянгаад иргэд цэрэг татлагад хамрагдсан байна. Цэрэг татлагын үеийн эрүүл мэндийн үзлэг бол өргөн бүрэлдэхүүнээр хамрагддаг эрт илрүүлэг юм. Цэрэг татлагын эрүүл мэндийн үзлэгийг илүү чанартай, өргөн хүрээнд хийж чадвал нийгэмд ажил эрхлэх насны залуу үе эрүүлжүүлээд авах боломж юм. Мөн манай цэрэг, цагдаагийнхан маш хүнд нөхцөлд урт цагаар ажилладаг. Тиймээс тэдний эрүүл мэнд, ажиллах орчин нөхцөлд анхаарч ажиллах болно.

### **Хүн амын сэтгэл зүй, нийгмийн хандлагыг та юу гэж харж байна. Энэ чиглэлд ямар ажил хийх вэ?**

-Нийгмийн сэтгэцийн эрүүл мэндийн асуудал дээр голчлон анхаарч ажиллана. Иргэд сэтгэл гутрал болоод стрессээ тайлах орчин нөхцөл байхгүй учраас манай нийгмийн сэтгэл зүйн байдал өнөөдрийн нөхцөлд ирсэн. Сэтгэл бол эрхтэн юм гэдгийг ойлгож хүлээн зөвшөөрөх хэрэгтэй юм. Үүнийг шинжлэх ухаанаар тайлбарлах аргагүй зүйл хэдий ч бидний эрүүл мэндэд маш чухал. Сэтгэл болон сэтгэц нь өөр өөр асуудал. Сэтгэлгүй иргэнийг бид бэлдэж болохгүй юм. Энэ тал дээр ЕБС-ийн багш нар анхаарах хэрэгтэй. Ахмад үеэ хүндлэх, үг сонсох тал дээр маш өөр залуу үе гарч ирж байна. Гэхдээ энэ нь тэдний буруу биш. Цэцэрлэгт байхаас нь хүн байх боловсрол заагдахгүй байна. Тэдэнд зөв үлгэр дуурайлал дутмаг байна. Монгол иргэн, Монгол хүн байх боловсролыг хүүхэд наснаас нь цогт хөтөлбөрөөр олгож байж Эрүүл Монгол хүн болж төлөвшинэ.



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ЗӨВЛӨХ

### Б.ДАВААДАЛАЙ

Эрхэм хүндэт ард иргэд, уншигч олон Та бүхний амар амгаланг айлтган мэндчилье.

Монгол хүний эрүүл мэнд, амьдрах эрүүл аюулгүй орчин, суурь хүнсний хангамж, чанарыг сайжруулах, улмаар Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг бататган бэхжүүлэх зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгч өөр хоорондоо харилцан уялдаа, шүтэлцээ бүхий “Тэрбум мод”, “Хүнсний хангамж, аюулгүй байдал” болон “Эрүүл Монгол хүн” гэсэн үндэсний хөдөлгөөнүүдийг санаачлан улс орон даяар хэрэгжүүлж байна.

Ялангуяа, монгол хүний эрүүл мэндийг хамгаалах, монгол хүнийг өвдсөнөөс хойш бус харин өвдөхөөс нь урьдчилан сэргийлэх хэлбэр рүү шилжүүлэх үүднээс эрүүл мэндийн тогтолцооны өөрчлөлт хийх зорилгоор “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлж эхэлсэн.

Энэ хүрээнд эн тэргүүнд ард иргэдийн дунд тамхи, согтууруулах ундааны хэрэглээг бууруулах, үүнээс шалтгаалсан өвчлөлийг сааруулах зорилгоор томоохон бодлогын алхмуудыг шат дараатай авч хэрэгжүүлээд байна.

Тухайлбал, архи, согтууруулах ундааны зохисгүй хэрэглээнээс үүдэлтэй хүн амын эрүүл мэнд, нийгмийн аюулгүй байдал, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах зорилгоор Монгол Улсын

Ерөнхийлөгчийн 2022 онд 43 дугаар зарлиг гаргасан.

Уг зарлигийн нэг онцлох заалт нь архи, согтууруулах ундааны хатуулгыг жилд 2 хувиар бууруулан 2032 он гэхэд 28 болгож бууруулах, онцгой албан татварыг нэмэгдүүлэх тухай асуудал юм.

Өөрөөр хэлбэл, 2022 оны байдлаар хүн амын дундах архи, согтууруулах ундааны хэрэглээ дийлэнхдээ 38 градус байсан бол одоогоор хатуулгын хэмжээ 36 болж буураад байна.

Үр дүнд нь архи, согтууруулах ундаа хэрэглэж буй иргэд гүн согтох, түүнээсээ хамааралтайгаар биеэ хянах чадвараа алдах, гэмт хэрэг, зөрчилд холбогдох, гэмтэж бэртэх сөрөг үр дагавар сүүлийн 2 жилд тодорхой хэмжээнд буураад байна.

Түүнчлэн хүн амын дундах тамхины хэрэглээг бууруулахад мөн “Эрүүл Монгол хүн” хөдөлгөөн онцгой анхаарч, шат дараатай арга хэмжээ авч байна.

ДЭМБ-аас хийсэн судалгаагаар Монгол Улсад өсвөр насны хүүхдийн тархины хөгжилд электрон тамхи /vape/-ны хэрэглээ нь урт хугацаанд сөргөөр нөлөөлж, эрүүл мэнд, амь насанд нь аюул, эрсдэл учруулж байгааг анхааруулсан.

Тодруулбал, электрон тамхи буюу электрон никотин дамжуулах систем нь сэтгэл түгших эмгэг, оюуны хомсдол, донтолт, уушги цоорох

эмгэг зэргийг үүсгэдэг байна.

Тиймээс “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд өсвөр насны хүүхдийн электрон тамхины хэрэглээг бууруулах, эрүүл өсөж бойжих, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах үүднээс 18 нас хүрээгүй хүүхдэд электрон тамхи, түүний дагалдах хэрэгслийг худалдан борлуулахыг хориглох захирамжийг Нийслэлийн Засаг дарга өнгөрсөн оны сүүлд гаргаад байна.

Дээрх дурдсан тодорхой, шийдэмгий бодлого, арга хэмжээг “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний авч хэрэгжүүлж байгаа бөгөөд ирэх жилүүдэд зохисгүй хооллолт, архи тамхины хортой хэрэглээ, хөдөлгөөний хомсдол, илүүдэл жин, таргалалт зэрэг хүн амын дунд тулгамдсан олон асуудлаар нарийвчилсан бодлого, үйл ажиллагаа авч хэрэгжүүлэхээр байна.

Энэ дашрамд Монгол хүний эрүүл мэндийг хамгаалах, “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөнийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд ард иргэд, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа хамгийн чухал болохыг эцэст нь эрхэм уншигч Та бүхэнд уриалан хэлэхийг хүсэж байна.

Монгол хүн эрүүл байвал Монгол Үндэстэн хүчирхэг байна.

Эрүүл Монгол хүний төлөө монгол хүн бүрийн үүрэг оролцоо чухал юм.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН БОДЛОГЫН ЗӨВЛӨХ

## Ч.ЛОДОЙРАВСАЛ

Эрхэм хүндэт ард иргэд, уншигч олон Та бүхний амар амгаланг айлтган мэндчилье.

Монгол Улсын хамгийн том баялаг бол Монгол хүн юм. Монгол төрийн бодлогын цөмд хүний хөгжил, ялангуяа эрүүл мэнд, эрүүл аюулгүй орчин, эрүүл хүнс гэсэн тулгуур гурван асуудлыг чухалчлан авч үзэх учиртай.

Нийт ард иргэдийн эрүүл мэндийн боловсролыг сайжруулах, соён гэгээрүүлэх, эрүүл амьдрах орчныг бүрдүүлэх, эрүүл хүнсээр хангах, эрүүл аж төрөх ёс, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх зорилгоор “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөнийг Монгол Улсын Ерөнхийлөгч санаачлан хэрэгжүүлж байгаа.

Монголчууд бид “Хүн болох багаасаа, хүлэг болох унаганаасаа”, “Багадаа сурахгүй бол насны явдал хоцорно” хэмээн сургаж ирсэн.

Тиймээс Монгол хүн бүрийг бага балчраас нь бие бялдар, зүрх сэтгэл, оюун ухааны өв тэгш хүмүүжил олгож, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлж, амьдрал ахуйд нь мөрдлөг болгон хэвшүүлэх нь чухал юм.

Боловсролын эрх зүйн шинэчлэлээр хүүхэд, залуучуудад эрүүл амьдралын хэв маяг, ур чадвар,

хандлагыг төлөвшүүлэх агуулгыг боловсролын бүх түвшний сургалтад тусгах зохицуулалт хийгдэж эхэлсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Эрүүл монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/146 дугаар тушаалын хавсралтаар “Багш, Эрүүл мэндийн боловсрол, арга зүй” /6-011439/ мэргэжлийн хөтөлбөрийн нэрийг шинэчлэн баталж, тус хөтөлбөрийг МУБИС, АШУУИС хамтран хэрэгжүүлж эхлээд байна.

Эрүүл мэндийн хичээл 2018-2019 оны хичээлийн жилээс ерөнхий боловсролын сургуулийн 4-12 дугаар ангид бие даасан хичээл болж, сургалтын төлөвлөгөөнд заавал судлах агуулгаар хэрэгжиж байна.

“Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Эрүүл зүрх” загвар төсөл хэрэгжүүлж сургуульд суурилсан эрүүл мэндийн тандалтын тогтолцооны эрх зүйн орчныг бүрдүүлсэн нь чухал ажил болсон.

Эрүүл мэндийн эрсдэлийг эрт илрүүлж, эмгэгт хүргэдэг шалтгааныг бууруулж, зохих арга хэмжээ авч чадвал насанд хүрэгчдийн дундах өвчлөл буурах ач холбогдолтой. Сургуульд суурилсан эрт илрүүлгийн хүрээнд суралцагчдыг 6, 9, 12, 15

насанд нь эрүүл мэндийн илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулснаар иргэдийн эрүүл мэндийг бага наснаас нь хамгаалах боломж бүрдэж байна.

Мөн орчин үед техник технологи эрчтэй хөгжиж, хүний амьдралд гүн гүнзгий нэвтрэхийн хэрээр хүүхэд багачууд эх байгалиас алсран холдож, амьд харилцаа, идэвхтэй хөдөлгөөнөөр дутагдах боллоо.

Тиймээс хүүхдийн идэвхтэй хөдөлгөөнийг дэмжиж, эх байгальд ойрхон байхыг чухалчлахын зэрэгцээ монгол хүүхдийн бие бялдарын хөгжлийн онцлогийг тусгасан шалгуур үзүүлэлтэд тулгуурласан сургалт, хөгжлийн үйл ажиллагааг зохион байгуулах, сурагч бүрийн бие бялдарын хөгжлийг үнэлэн дүгнэж, зөвлөн чиглүүлж, хамтран ажилладаг тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай.

Эх орны ирээдүй болсон хүүхэд багачууддаа “Эрүүл биед саруул ухаан” хэмээх ухаант ардын мэргэн үгийг санаж, эрдэм номдоо шамдан суралцахын зэрэгцээ эрүүл мэндээ хамгаалж, идэвхтэй хөдөлж, өөдрөг дэврүүн байхыг хүсье.

Монгол хүн бүр эрүүл саруул, сэтгэл тэнүүн, аз жар галтай байх болтугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,  
БАТЛАН ХАМГААЛАХ БОДЛОГЫН ЗӨВЛӨХ

## Д.БААСАНДАМБА



Төр, улсын аюулгүй байдлын цөм нь хүн гэдгийг бид бүхэн сайн ойлгодог хэдий ч бүтээлч, хөдөлмөрч, чадварлаг иргэн хүн гэж хэнийг хэлэх вэ гэдэг асуудалд бүрэн дүүрэн хариулт өгөх шаардлага тулгарч ирсэн. НҮБ-аас боловсролтой хүнд байх хамгийн чухал чанар нь “эрүүл байх” явдал гэдгийг нэгэнтээ бататган тодорхойлсонтой дүйцүүлэн авч үзвэл хүн эрүүл байгаа нөхцөлд бүтээлч, хөдөлмөрч, чадварлаг иргэн байж чадна.

Энэ үзэл санааны үндсэн дээр Монгол Улсын Ерөнхийлөгч “аливаа аюул, эрсдэлийг даван туулах” чадвартай, хөдөлмөрлөх, сурч боловсрох бүтээлч дадал, хэвшилтэй, эх оронч үзэл төлөвшилтэй “Эрүүл Монгол иргэн”-тэй байх зорилтыг дэвшүүлэн тавьсан нь яах аргагүй цаг үеэ олсон асуудал болж байна.

Амар тайван, аюулгүй нийгмийг бүтээхэд эрүүл иргэн, эрүүл нийгэм,

эрүүл ирээдүй нэн чухал учраас Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан санаачилсан “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхэд төр, засгийн болон орон нутгийн түвшинд, байгууллага, хамт олноос эхлэн өрх гэр, иргэн бүрийн ухамсар, идэвх санаачилгад тулгуурласан хамтын хүчин чармайлт нэн ач холбогдолтой гэж бодож байна.


Ялангуяа үндэсний аюулгүй байдлыг бататган бэхжүүлж, аливаа гамшиг, эрсдэлтэй тэмцэх, даван туулах, эх орноо батлан хамгаалах үүргийг эрүүл чийрэг Монгол эр хүн хүлээж, эх орны үйлдвэрлэл, эдийн засгийн хөгжил дэвшлийг урагшлуулах хөдөлмөр, бүтээлийн гол ачааг эрүүл бие бялдар, сэтгэл зүй, ёс суртахуунтай иргэн хүн л үүрдгийг умартах учиргүй.

Өнөөдөр төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагад алба хааж, төр, нийгэм, иргэдийнхээ төлөө

өндөр ачаалал, бэрхшээл, сорилтыг даван туулах чадвартай залуучуудын эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэхэд тулгамдаж буй гол асуудал нь цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн байдал болоод байна.

Энэ асуудлыг урт, дунд хугацаанд шийдвэрлэх хамгийн чухал арга зам нь үндэсний хөдөлгөөний “Эрүүл ирээдүй” зорилтын хүрээнд хэрэгжүүлж байгаа сургуульд суурилсан эрүүл мэндийн хяналт, тандалт бүртгэл, эрт илрүүлэг цогц арга хэмжээнүүд болж чадна.

Нөгөө талаас цэргийн албаар дамжуулан залуучуудад эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлд сургах, донтох эмгэгээс урьдчилан сэргийлэх чадвар эзэмшүүлэх бүрэн боломжтой. Үүний үр дүнд өрх гэр бүлд сайн аав, эх оронд эрүүл чийрэг зөв монгол иргэн бэлтгэгдэж, эрүүл нийгмийг бүтээхэд үнэтэй хувь нэмэр оруулж чадна.



МОНГОЛ УЛСЫН ХЭМЖЭЭНД  
СУРГУУЛЬД СУУРИЛСАН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ТАНДАЛТЫН  
ТОГТОЛЦООНЫ  
СУУРЬ ТАВИГДЛАА

ЭРТ ИЛРҮҮЛЭГТ ХАМРАГДСАН ЕБС-ИЙН  
НЭГДҮГЭЭР АНГИЙН СУРАГЧДЫН

▶ 83%

ШҮДНИЙ  
ӨВЧЛӨЛТЭЙ

▶ 23%

ХАРААНЫ  
ӨӨРЧЛӨЛТТЭЙ

Судалгаагаар өсвөр үеийнхний дунд эрүүл мэндийн дараах асуудлууд тулгарч байгааг Нийгмийн эрүүл мэндийн Үндэсний төвөөс мэдээлсэн. Тодруулбал нийт судалгаанд оролцсон хүүхдүүдийн:



41,8%

өдөр бүр хийжүүлсэн  
ундаа хэрэглэдэг



39,7%

гар угаах дадалд  
суралцаагүй



38,5%

өглөөний цай тогтмол  
уж хэвшээгүй



26%

шүдээ угаадаггүй буюу  
заримдаа л угаадаг



ЭРТ ИЛРҮҮЛЭГТ  
ХАМРАГДСАН  
ХҮҮХДҮҮДИЙН

77,8%

ШҮДНИЙ ЦООРОЛТОЙ  
БАЙГАА НЬ

МАНАЙ УЛС  
ХҮҮХДИЙНХЭЭ  
ЭРҮҮЛ МЭНДЭД  
ЯАРАЛТАЙ  
АНХААРАЛ  
ХАНДУУЛЖ,  
тэднийг мэдлэгжүүлж,  
ЭРҮҮЛ МЭНДИЙН  
БОЛОВСРОЛЫГ НЬ  
ДЭЭШЛҮҮЛЭХ  
● ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГА  
БАЙГААГ ХАРУУЛСАН

Эрүүл ирээдүйг төлөвшүүлэхийн тулд цэцэрлэг, сургуулийн наснаас нь эрүүл мэндийн мэдлэг, боловсрол олгох, тэдний эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, эмгэгийг эрт илрүүлж шаардлагатай тусламжид хамруулах нь нэн чухал юм. Энэ хүрээнд 2022 оноос “Эрүүл зүрх” загвар төслийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд үүнийг улсын хэмжээнд өргөжүүлж ЭМЯ, Боловсролын яамны хамтарсан баг ажиллаж “Эрүүл аюулгүй сургууль” арга хэмжээ эхэллээ. Тус арга хэмжээний эхлэл болгож ЕБС-д сургуульд суралцаж буй нэгдүгээр ангийн 70 гаруй мянган сурагчийг зүрх, нүд, шүдний үзлэгт хамруулахаар хоёр яамнаас бэлтгэл ажлаа хангасан. Үзлэгийг Улаанбаатар хотын ЕБС бүрд 2024 оны 10-11 дүгээр сард, хөдөө орон нутагт 2025 оны нэгдүгээр улиралд багтаан хийх бөгөөд нийт хүүхдүүдийн 10 хувь нь зүрхний эмгэгтэй, 23 хувь нь харааны өөрчлөлттэй, 80 гаруй хувь шүдний цооролттой байх магадлалтай гэж тооцоолсон. Улмаар уг тооцоололд

үндэслэн дараа дараагийн арга хэмжээг төлөвлөж хоёр яамны хамтарсан ажлын хэсэг ажиллаж байна.

Зүрхний үзлэгт 2067 сурагч хамрагдсанаас 0.34 хувь нь өөрчлөлттэй, нүдний үзлэгт 5061 сурагч хамрагдсанаас 22.5 хувь нь өөрчлөлттэй, шүдний үзлэгт 815 сурагч хамрагдсанаас 83 хувь нь өвчлөлттэй гараад байна. Тухайлбал, нүдний үзлэгээр нийт оношлогдсон хүүхдүүдийн дийлэнх нь буюу 88 хувь нь харааны өөрчлөлттэй байснаа мэдээгүй байжээ. Тэдгээр хүүхдийн 67 хувь нь холын хараа, 39 хувь нь ойрын хараа, 47 хувь нь стерео харааны өөрчлөлттэй байсан нь эрт илрүүлгийн үзлэгээр тогтоогдсон байна.

Энэ жилийн хувьд эрт илрүүлэгт зөвхөн нийслэлийн ЕБС-ийн нэгдүгээр ангийн 39 мянган сурагч хамрагдах бол хөдөө орон нутгийн сурагчдыг ирэх жилийн 4 дүгээр сараас хамруулахаар бэлтгэл ажлаа хангаад байна.

## СУРГУУЛЬД СУУРИЛСАН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТАНДАЛТЫН ТОГТОЛЦОО БА ЭРХ ЗҮЙН ӨӨРЧЛӨЛТ:

- ✓ 2022 оноос “Эрүүл зүрх” жишиг төслийг Япон улсын туршлагад тулгуурлан хэрэгжүүлж эхэлсэн
- ✓ Орон нутгаас Архангай, Увс, аймаг, нийслэлийн Хан-Уул дүүргийн ЕБС-ын нэгдүгээр ангийн сурагчдад зүрхний эмгэгийн илрүүлэг хийгдсэн

Орон нутаг


# 564

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ

Улаанбаатар хот

# 306

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ



Жишиг төсөлд тулгуурлан сурагчдын эрүүл мэндийн тандалтын тогтолцоо бүрдүүлэхээр 2023 онд сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд өөрчлөлт орсон.

**28.10.** Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн эрүүл мэндийн хяналт, тандалтын цахим бүртгэлийн сан бүрдүүлэх, холбогдох хуульд заасан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд суралцагчийг тодорхой насны давтамжтай хамруулах үйл ажиллагааг эрх бүхий этгээдийн баталсан журмын дагуу харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулна.

## СУРГУУЛЬД СУУРИЛСАН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХЯНАЛТ, ТАНДАЛТЫН БҮРТГЭЛ МЭДЭЭЛЛИЙН ТОГТОЛЦОО ХЭРЭГЖИЖ ЭХЛЭВ

**6**  
**НАС** Зүрх судасны тогтолцоо

**9**  
**НАС** Амьсгалын эрхтэн тогтолцоо

**12**  
**НАС** Хоол боловсруулах тогтолцоо

**15**  
**НАС** Шээс бэлгийн замын тогтолцоо

### ЗУРГААН НАСТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГ



**2024**

Улаанбаатар  
**35200**  
Хүүхэд



**2025**

21 аймаг  
**37800**  
Хүүхэд

#### ҮЗЛЭГИЙН БҮРДЭЛ

- Амны хөндийн эрүүл мэнд
- Хараа зүйн үзлэг
- Зүрх судас (зүрхний цахилгаан бичлэг)

#### ЗҮРХНИЙ ҮЗЛЭГТ

сурагч

**2067**

өөрчлөлттэй

**0.34%**

#### НҮДНИЙ ҮЗЛЭГТ

сурагч

**5061**

өөрчлөлттэй

**22.5%**

#### ШҮДНИЙ ҮЗЛЭГТ

сурагч

**815**

өвчлөлттэй

**83%**



Тухайлбал, нүдний үзлэгээр нийт оношлогдсон хүүхдүүдийн дийлэнх нь буюу **88** хувь нь харааны өөрчлөлттэй байснаа огт мэдээгүй байжээ.

Тэдгээр хүүхдийн **67** хувь нь холын хараа, **39** хувь нь ойрын хараа, **47** хувь нь стерео харааны өөрчлөлттэй байсан нь эрт илрүүлгийн үзлэгээр тогтоогдсон байна.

Энэ жилийн хувьд эрт илрүүлэгт зөвхөн нийслэлийн ЕБС-ийн нэгдүгээр ангийн **39** мянган сурагч хамрагдах бол хөдөө орон нутгийн сурагчдыг ирэх жилийн **4** дүгээр сараас хамруулахаар бэлтгэл ажлаа хангаад байна.

## ЭРҮҮЛ ЗҮРХ ТӨСӨЛ 2022-2024

### УВС АЙМАГ

**1309**  
Хүүхэд

**17.2%**  
Зүрхний эмгэг өөрчлөлттэй

**14%**  
Илүүдэл жин

### АРХАНГАЙ АЙМАГ

**2999**  
Хүүхэд

**14%**  
Зүрхний эмгэг өөрчлөлттэй

**5.2%**  
Илүүдэл жин

### ОРХОН АЙМАГ

**2293**  
Хүүхэд

**5.9%**  
Зүрхний эмгэг өөрчлөлттэй

### ХАН-УУЛ ДҮҮРЭГ

**8083**  
Хүүхэд

**12.4%**  
Зүрхний эмгэг өөрчлөлттэй

**15.4%**  
Илүүдэл жин

■ УИХ-ын гишүүн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан



## “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн бол Монгол Улсын Ерөнхийлөгчийн манлайлал, санаачилгаар анх удаа хэрэгжиж буй нийтийн эрүүл мэндийн цогц арга хэмжээ юм

**Та Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрүүл мэнд, нийгмийн бодлогын зөвлөхөөр ажиллаж “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөнийг чиглүүлэн хэрэгжүүлж байсан. Одоо та Эрүүл мэндийн сайдын хувьд уг хөдөлгөөнийг хэрхэн үргэлжлүүлж байна вэ?**

Монгол улс чамгүй олон эмч, эмнэлэгтэй төдийгүй эрүүл мэндийн тусламжийн дийлэнх хувийг эмнэлгийн тусламж эзэлдэг. Бид эмнэлэгт суурилсан, эмнэлгийн тусламж давамгайлсан өнөөгийн тогтолцоог өөрчлөхгүйгээр хүн амын эрүүл мэндийг сайжруулах, эрүүл-чанартай дундаж наслалтыг ярих боломжгүй юм. Өвчин, эмгэгт хүргэдэг эрсдэлийн дийлэнх нь тухайн хүний амьдралын хэв маяг, зуршил, зан үйл тухайлбал хооллолт, архи тамхины хэрэглээ, идэвхтэй хөдөлгөөн, сэтгэц зэргээс шалтгаалдаг. Иймээс өвчилсний дараа биш харин өвчин эмгэгт өртөхөд нөлөөлдөг хүчин зүйлсийг судлах, эрсдэлийг багасгах, угтуулан сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих зэрэг нийтийн эрүүл

мэндийн тусламжийг нэн тэргүүнд нэмэгдүүлэх нь чухал учраас Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөнийг 2021 оноос хэрэгжүүлж эхэлсэн. “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн бол Монгол Улсын Ерөнхийлөгчийн манлайлал, санаачилгаар анх удаа хэрэгжиж буй нийтийн эрүүл мэндийн цогц арга хэмжээ юм. Өөрөөр хэлбэл нийтийн эрүүл мэндийн асуудлыг төрийн тэргүүн анхаарч ялангуяа согтууруулах ундаанаас үүдэлтэй эрүүл мэнд, эдийн засаг, нийгмийн хор хөнөөлийг бууруулах зорилго бүхий 43 тоот зарлиг гаргаж эрх зүйн томоохон шинэчлэл хийгдлээ. Уг хөдөлгөөнийг эрчимжүүлэх, салбаруудын уялдааг хангах үүднээс Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны мөрийн хөтөлбөрт “Эрүүл Монгол хүн” арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусган энэ хүрээнд олон талт, цогц арга хэмжээг салбаруудын оролцоонд тулгуурлан хэрэгжүүлнэ.

Бид эрүүл ирээдүйг бий болгохын тулд боловсролын салбарыг

түшиглэн эрүүл мэндийг дэмжигч цэцэрлэг, сургууль, их ба дээд сургуулийг бий болгох зорилгоор эхний ээлжид Ерөнхий боловсролын сургуулийн эрүүл ахуй, аюулгүй байдлын үнэлгээ хийн эрх зүйн шинэчлэл хийх, 2024-2028 онд хэрэгжүүлэх “Эрүүл, аюулгүй сургууль” арга хэмжээний төлөвлөгөө боловсруулаад байна.

**Сургуульд суурилсан эрүүл мэндийн тандалтын тогтолцоо, түүний хэрэгцээ, үр дүнгийн талаар та товч мэдээлэл өгнө үү?**

Манай хүн амын өвчлөл, эндэгдлийн гол шалтгаан нь зүрх, судасны эмгэг болсоор даруй 30-д жил болж байгаа байна. Үүнийг бууруулахын тул бид хүүхэд үеэс уг эмгэгийг илрүүлэх, эмчлэх, сэргийлэх нь нэн чухал юм. Япон улс 1954 оноос хүүхдийг сургуульд анх элсэхэд нь хамгийн энгийн аргаар зүрхний эмгэгийг илрүүлж, хянаж, шаардлагатайг эмчилгээнд хамруулан энэ ажлыг тогтолцоо болгон хөгжүүлж, тогтворжуулж зүрхний эмгэгийн дорвитой бууруулсан туршлагатай. Бид энэ туршлагаар 2021 оноос



эхлэн Увс, Архангай аймаг, Нийслэлийн Хан-Уул дүүрэгт загвар төсөл хэрэгжүүлэн 15 мянган хүүхдийг хамруулсан. Энэ төслийн үр дүнд эдгээр хүүхдийн 5-7 хувьд нь эмгэг илэрч, тэдгээрийг мэргэжлийн эмчийн хяналтад оруулж, зайлшгүй эмчилгээнд хамруулах хүүхдийг төрөлжсөн төвтэй холбон мэс заслын эмчилгээнд хамруулсан нь асар үр дүнтэй байсан. Энэ жишиг төслийн үр дүнд тулгуурлан 2023 онд Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн тухай хуульд анх удаа сургуульд суурилсан эрүүл мэндийн тандалтын тогтолцоог бий болгохоор хуульчилж өгсөн. Сургуульд суурилсан эрүүл мэндийн тандалт нь суралцагчийн

эрүүл мэндийг тодорхойлж, эмгэгийг эрт илрүүлэх, шаардлагатай тусламжийг үзүүлэх, эмчлэх зэрэг эрүүл мэндийн мэдээний сан бүхий тогтолцоо юм.

2024 онд Эрүүл мэндийн сайд, Боловсролын сайдын хамтарсан тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангийн суралцагчдад нүд, шүд, зүрхний эмгэгийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгийг зохион байгуулах удирдамж”-ийг батлан, нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиудад зохион байгуулж байна. Сургуульд суурилсан эрүүл мэндийн эрт илрүүлгийг зохион байгуулахдаа хүүхдэд зөвхөн үзлэг

хийгээд орхихгүй, эмчилгээ хийж, хяналтад оруулах байдлаар цогц тусламж, үйлчилгээг үзүүлэхээр ажиллаж байна. Цаашид бусад насны бүлэгт тохирсон эрхтэн тогтолцооны эмгэгийг илрүүлэх, тандах ажлууд хийгдэх юм. Бид үүний зэрэгцээ сургуулийн эрүүл мэндийн багш арга зүйчийг бэлтгэх, эмч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, хоол зүйчийг чадавхжуулах зэрэг суралцагчдад эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлд цогц ажил хэрэгжүүлж байна. Эдгээр ажлын үр дүнд Эрүүл ирээдүй бий болж улмаар Монгол хүний чанартай, эрүүл дундаж наслалт нэмэгдэх юм.

Эрүүл мэнд хичээлийн хөтөлбөр нь I Хувийн эрүүл ахуй ба орчны эрүүл мэнд, II Хооллолт ба хөдөлгөөн, III Сэтгэцийн эрүүл мэнд, IV Хорт зуршлаас сэргийлэх, V Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, VI Аюулгүй байдал, анхны тусламж гэсэн агуулгын хүрээнд анги тус бүрд өргөтгөн тодорхойлсон суралцахуйн зорилтуудтай байна.

## "ЭРҮҮЛ АЮУЛГҮЙ СУРГУУЛЬ" АРГА ХЭМЖЭЭГ ЭМЯ-ТАЙ ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА

2024.11.18  
өдрийн байдлаар

НИЙСЛЭЛИЙН ЕБС-ийн  
нэгдүгээр ангийн

11,102

СУРАЛЦАГЧ

80.8%  
ШҮД ЦООРОХ ӨВЧТЭЙ

### ■ Боловсролын сайд П.Наранбаяр

**Та боловсролын салбарт ялангуяа суралцагчийн эрүүл мэнд, эрүүл мэндийн боловсролтой холбоотой ямар ажлууд хийхээр та төлөвлөж байна вэ?**

Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулиудад суралцагчдын эрүүл, аюулгүй, жендерийн тэгш байдал, стандартын шаардлага хангасан орчин, нөхцөлд суралцах, бүх түвшний боловсролын сургалтын хөтөлбөрт эрүүл мэндийн боловсролын агуулгыг заавал тусгаж, боловсролын сургалтын байгууллага өмчийн хэлбэр харгалзахгүй хэрэгжүүлэх, боловсролын байгууллагын албан хаагч, суралцагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах, эцэг,

эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхдийнхээ хөгжил, төлөвшил, эрүүл мэнд, аюулгүй байдалд анхаарал тавих, эрүүл мэндийн хяналт, тандалтын цахим бүртгэлийг бүрдүүлэхтэй холбоотой заалтууд тусгагдсан.

Сургуулийн өмнөх боловсролд БСШУ-ны сайдын 2019 оны А/494 дүгээр тушаалаар, Ерөнхий боловсролын сургуульд мөн оны А/492 дугаар тушаалаар тус тус шинэчлэн сайжруулж баталсан сургалтын хөтөлбөр хэрэгжиж байна.

Дээрх хөтөлбөрүүдийн дагуу сургуулийн өмнөх боловсролын түвшинд Хөдөлгөөн, эрүүл мэнд сургалтын чиглэлийн хүрээнд, бага боловсролын I-III ангид хүн ба орчин, биеийн тамирын хичээлийн агуулгад

туссан холбогдох суралцахуйн зорилтуудаар дамжуулан эрүүл мэндийн мэдлэг, ойлголт, чадвар, хандлага төлөвшүүлэх, IV-XII ангид Эрүүл мэнд хичээлээр сурагч нь биеийн өсөлт, хөгжилтийн үед гарах өөрчлөлтийг мэдэж, эрүүл ахуйн зөв дэглэм баримтлан, өөрийгөө болон бусдыг хүндэлж, аюулгүй амьдрах арга ухаан, эрүүл зан үйлд суралцах зорилгыг тус тус хэрэгжүүлж байна.

**Тодруулбал, одоо хэрэгжиж буй эрүүл мэнд хичээлийн хөтөлбөрт ямар агуулга хамаарах вэ?**

Эрүүл мэнд хичээлийн хөтөлбөр нь I Хувийн эрүүл ахуй ба орчны эрүүл мэнд, II Хооллолт ба хөдөлгөөн, III Сэтгэцийн эрүүл мэнд, IV Хорт зуршлаас сэргийлэх, V Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд,



VI Аюулгүй байдал, анхны тусламж гэсэн агуулгын хүрээнд анги тус бүрд өргөтгөн тодорхойлсон суралцахуйн зорилтуудтай байна.

**Эрүүл мэндийн боловсролын хөтөлбөрийн гол онцлогийг тодотгож асуумаар байна?**

Сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд бид суралцагчдад эрүүл мэндийн боловсрол олгох агуулгыг хуульд заасны дагуу бусад хичээл, судлагдахууны агуулгатай интеграци байдлаар боловсруулан хэрэгжүүлнэ. Хүүхэд эрүүл зөв хооллодог, дасгал хөдөлгөөн хийдэг, биеийн өсөлт хөгжил, өөрчлөлтөө ажиглаж, ойлгодог, биеийн болон сэтгэл зүйн эрүүл мэндийн анхан шатны мэдлэг, эрүүл амьдралын дадал хэвшилтэй болоход эрүүл мэндийн боловсролын хөтөлбөрийг чиглүүлнэ.

Шинэчлэн боловсруулж буй эрүүл мэндийн хөтөлбөрийн онцлог нь суралцагч эрүүл, аюулгүй амьдрахад шаардлагатай мэдлэг, ойлголттой болох төдийгүй өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлэх энгийн дэглэм, дадал хэвшлийг хүүхдэд төлөвшүүлэхэд чиглэнэ. Жишээлбэл хооллолт дээр өдөрт авах илчлэгийн хэмжээ, зохистой хооллох орц, цагийн талаар мэдэж, түүнийгээ өдөр тутамдаа хэрэгжүүлж, зөв

хооллодог, үе тэнгийнхэн болон гэр бүлийнхэндээ зөвлөдөг байх, идэвхтэй хөдөлгөөн, дасгал хийх хэрэгцээ, ач холбогдлыг шинжлэх ухаанчаар ойлгохын зэрэгцээ өөрийн өсөлт хөгжлийн онцлог, хэрэгцээгээ үнэлж, ойлгож, бие бялдраа хөгжүүлэх өглөөний дасгал хийдэг, яс булчингийн хөгжлөө зөв хөгжүүлэх хөдөлгөөний зөв эвсэлтэй байх, зөв суух, цахим хэрэглээгээ хянадаг, болзошгүй эрсдэл, осол гэмтлээс өөрийгөө хамгаалдаг, шаардлагатай үед анхан шатны эрүүл ахуйн тусламжийг өөртөө болон бусдад үзүүлдэг гэх мэтчилэн суурь чадваруудыг эзэмшүүлэхэд чиглэнэ гэсэн үг юм.

**“Эрүүл аюулгүй сургууль” арга хэмжээг хэрэгжүүлэхээр Эрүүл мэндийн яамтай хамтран ажиллаж буй ажлын явц, хүлээгдэж буй үр дүнг та хэрхэн төсөөлж байна вэ?**

Эрүүл мэндийн яам, Боловсролын яам хамтран ДЭМБ, ЮНЕСКО-оос хамтран гаргасан “Сургууль бүр эрүүл мэндийг дэмжих сургууль болох” санаачилга, ЮНЕСКО-ийн “Эрүүл мэнд, сайн сайхан байдлын боловсролын стратеги”-ийн дагуу эрүүл мэндийг дэмжигч сургуулийг “Эрүүл, аюулгүй сургууль” нэртэйгээр, цогц байдлаар хэрэгжүүлэхээр хамтарсан ажлын хэсэг байгуулан арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

“Эрүүл мэндийг дэмжигч сургууль”-ийг эрүүл мэндийн болон боловсролын салбарын хууль, журам, хөтөлбөр, арга хэмжээ, стандарт зэрэгт тусгагдсаны дагуу хүүхдийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах чиглэлээр тодорхой ажлуудыг авч хэрэгжүүлж байгаа ч уялдаа холбоог хангаж, цогц байдлаар хэрэгжүүлэх нь чухал болохыг олон судалгааны үр дүн харуулж байна.

Энэ арга хэмжээний нэг томоохон ажил нь сургуульд суурилсан эрт илрүүлэг бөгөөд Эрүүл мэндийн сайд, Боловсролын сайдын 2024 оны А/413, А/151 дүгээр хамтарсан тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангийн суралцагчдад нүд, шүд, зүрхний эмгэгийн урьдчилан сэргийлэх, эрт эрт илрүүлгийн үзлэгийг зохион байгуулах удирдамж”-ийг батлан, нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиудад зохион байгуулж байна. 2024 оны 12 дугаар сарын байдлаар нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангийн 29,000 суралцагч шүдний урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан бөгөөд тэдний 23,556 нь шүд цоорох өвчтэй байгааг илрүүлсэн байна.

# ДОНТОХ ЭМГЭГИЙГ ИЛРҮҮЛЭХ, СЭРГИЙЛЭХ, ЭМЧЛЭХ, ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ ӨРГӨЖҮҮЛЭХ АЖИЛ НИЙСЛЭЛИЙН ДҮҮРГҮҮД БОЛОН АЙМГУУДАД ЭХЛЭВ



СОНГИНО ХАЙРХАН  
ДҮҮРЭГ



СҮХБААТАР  
ДҮҮРЭГ



ЧИНГЭЛТЭЙ  
ДҮҮРЭГ



ХАН-УУЛ  
ДҮҮРЭГ



НАЛАЙХ  
ДҮҮРЭГ

## НИЙСЛЭЛ



БАЯНХОНГОР  
АЙМАГ



ӨМНӨГОВЬ  
АЙМАГ



ХӨВСГӨЛ  
АЙМАГ



ДОРНОД  
АЙМАГ



АРХАНГАЙ  
АЙМАГ

## ОРОН НУТАГ

Өмнөговь аймаг “Итгэл дүүрэн амьдрал” Сэтгэц нийгмийн сэргээн засах төв ажиллаж байна



Донтох эмгэгийн үед үзүүлэх тусламжийг өргөжүүлэх Монгол Улсын Ерөнхийлөгчийн 43 тоот зарлигийн гол зорилгын нэг нь архи, согтууруулах ундааны зохисгүй хэрэглээнээс үүдсэн донтох эмгэгийг илрүүлэх, оношлох, хяналт тандалт хийх цогц үйлчилгээг өргөжүүлэх юм. Өмнөговь аймгийн ЗДТГ-ын дэмжлэгээр тус аймагт “Итгэл дүүрэн амьдрал” төв байгуулан архинд донтох эмгэгийг илрүүлэх, эмчилгээ хийх, сэтгэлзүйн тусламж үзүүлэх зэрэг үйлчилгээг үзүүлж байна. Энэ төвийн үйл ажиллагаа, тулгамдаж буй асуудлын талаар ЕТГ-ын ЭМХТХХ албаны дарга О.Чимэдсүрэн, ЭМГ ын НЭМ-ийн газрын дарга Н.Амгалан болон тус төвийн аддиктологич эмч, багийн гишүүдтэй санал солилцов

# "АРХИ, СОГТУУРУУЛАХ УНДААНЫ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУЛАХ ЧИГЛЭЛД...."

## АРХИНЫ ЭСРЭГ АЛХАМ АЛХМААР...

**2021**

Согтууруулах ундааны эрүүл мэнд, эдийн засагт үзүүлэх нөлөөний бодлогын цогц судалгаа хийв

**2022.04.05**

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх 43 тоот зарлиг гаргав



**2022.07 сар**

Засгийн Газрын тусгай сангийн тухай хуульд шинээр Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих санг нэмж хуульд өөрчлөлт оров

**2022.07 сар**

УИХ-аас Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай, Онцгой албан татварын тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд тус тус өөрчлөлт оруулав

**2022.11 сар**

Цагдаагийн ерөнхий газартай хамтран "Намайг алгас" нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулав



**2023.02 сар**

"Архигүй Цагаан сар" арга хэмжээг зохион байгуулав

**2023.09.18**

Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр "Та татгалз" арга хэмжээг эхлүүлэв



**2023.10.09**

"Архи, согтууруулах ундааны зохисгүй хэрэглээг бууруулах нь" салбар дундын удирдах ажилтны зөвлөгөөнийг Ерөнхийлөгчийн Тамгын газраас зохион байгуулав



### 2024.12 сар

Дүүргүүдийн ЗДТГ, ЭМГ, Цагдаагийн хэлтэс, ӨЭМТ-ийн багийн 800 гаруй төлөөлөлд Донтох эмгэгийн тусламжийг өргөжүүлэх сургалт, зөвлөгөө хийв



### 2024.10 сар

Дүүргүүдийн ЭМТ-ийн сэтгэц, донтолын тусламжийн багийг чадавхжуулах сургалт зохион байгуулав



### 2024.09 сар

Сэтгэц нийгмийн сэргээн засах төв байгуулагдав



### 2024.03-06 сар

Донтох эмгэгийг илрүүлэх, сэргийлэх, эмчлэх, тусламж үйлчилгээг өргөжүүлэх зорилгоор Хан-Уул дүүргийн 21-р хороо болон ӨЭМТ-ийг түшиглэн цуврал уулзалтууд зохион байгуулагдав



### 2024.01 сар

ХУД-ийн ЭМТ-ийг түшиглэн Сэтгэц нийгмийн сэргээн засах төв байгуулагдав



### 2024.03 сар

Хан-Уул дүүрэгт согтууруулах ундаанд донтох эмгэгийн тархалт, илрүүлгийн судалгааг өрхөд суурилан зохион байгуулав



### 2023.12 сар

"Архигүй шинэ жил-Та татгалз" нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулав



### 2023.10.24

Хан-Уул дүүргийн удирдлагын багтай уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулав



# ДОНТОХ ЭМГЭГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ




**100.000**  
НАС БАРАЛТ  
ТУТМЫН



АРХИНЫ ШАЛТГААНААР  
ХОРВООГ ОРХИДОГ

ХҮН АМЫН



АРХИНД ДОНТСОН

Сүүлийн **5** жилд  
согтууруулах ундааны  
хэрэглээ, үйлдвэрлэл  
тасралтгүй нэмэгдсэн

**2022** оны  
статистикаас  
харахад  
**1** ХҮНД  
НОГДОХ



АРХИ, ДАРС

**8.9** литр

**37.1** литр


БОЛЖ ӨССӨН БАЙНА

• СОГТУУРУУЛАХ УНДААНЫ НӨЛӨӨЛЛИЙН УЛМААС НЭГ ЖИЛД •



**4000-4500**

орчим хүн энддэг



ГАРЧ БУЙ  
ГЭМТ  
ХЭРГИЙН

**60-70%**



**10-12%**

НИЙТ  
ГЭМТЛИЙН

АРХИ СОГТУУРУУЛАХ  
УНДАА ХЭРЭГЛЭСЭНТЭЙ  
ХОЛБООТОЙ БАЙДАГ

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

# СЭТГЭЦ-НИЙГМИЙН СЭРГЭЭН ЗАСАХ

## ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ




**ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН**

АРХИНЫ ХЭРЭГЛЭЭНИЙ АСУУДЛААР  
ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ХЭРЭГТЭЙ  
БОЛ МАНАЙ НИЙГЭМ СЭТГЭЛ ЗҮЙН  
ТӨВД ХАНДАНА УУ.

Хаяг: Хан-Уул дүүрэг, 19-р хороо,  
Туул гол гудамж 47-1 тоот  
Харилцах: 70173985, 80080651


1. Угтах үйлчилгээ



2. Бүртгэл мэдээлэл



3. Үзлэг, илрүүлэг, оношилгоо



4. Ганцаарчилсан зөвлөгөө,  
Сэдэлжүүлэх засал



5. Бүлгийн сэтгэл засал



6. Урлаг засал



Донтох эмгэгээс сэргийлэх, эмчлэх, нийгэм сэтгэл зүйн тусламж үзүүлэх нэгжийг суурьшлын онцлогийг харгалзан бий болгох:



Архины хамааралтай болон архинд донтох эмгэгтэй иргэн, тэдний гэр бүлд эрүүл мэнд, сэтгэцийн тусламж үйлчилгээг үзүүлэх, эмчлэх



Хүн ам, зорилтот бүлгүүдэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлыг өргөн хүрээнд зохион байгуулах



## ДОНТОХ ЭМГЭГИЙН ИЛРҮҮЛЭХ, ЭМЧЛЭХ, ХЯНАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА:



Согтууруулах ундааны хэтрүүлсэн хэрэглээ, донтох эмгэгийн тархалтыг өрхөд суурилан илрүүлэх, тархалтыг тогтоох



Үйлчлүүлэгчдийг АА төв болон хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамруулах



## СЭТГЭЦ НИЙГМИЙН СЭРГЭЭН ЗАСАХ ТӨВИЙН ДОНТОХ ЭМГЭГИЙН ЭМЧИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР:

‘1

Донтох эмгэг, эмчилгээний ерөнхий зарчим, эмийн эмчилгээ

- Илрүүлэг: AUDIT, GAGE, Мичиган оношилгооны сорил
- Оношлох: Лабораторийн шинжилгээ, богино хугацааны ярилцлагаар оношлох
- Эмчилгээ: Эмийн эмчилгээ, сэтгэл зүйн оюун санааны эмчилгээ, сэргээн засах тусламж
  - Анхан шатанд – илрүүлнэ, хордлого тайлах, ярилцлага хийх
  - Лавлагаа шатлалд- үндсэн мэргэжлийн тусламж
  - Үгүйлэх хам шинжийг зогсоох, хордлого тайлах эмчилгээ

‘2


Сэтгэл засал-12 алхамт хөтөлбөр, танин мэдэхүйн зан үйлийн эмчилгээ, сэдлийг дэмжих эмчилгээ, ганцаарчилсан сэтгэл засал, гэр бүлийн сэтгэл засал, Хандлагаар анагаахуй засал

‘3

Нийгмийн ажлын үйлчилгээ

‘4

Нийгэм хамт олонд түшиглэсэн сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээ, урлагийн сэтгэл засал, байгаль эмчилгээ, спортын сэтгэл засал, хөдөлмөр эмчилгээ гэх мэт.





## ДОНТОХ ЭМГЭГИЙН ЭМЧИЛГЭЭНИЙ ДАРААХ ХӨТӨЛБӨР



Донтох эмгэгийн эмчилгээ хийлгэж дууссанаар өвчтөнийг эрүүл болсон гэж тодорхойлох боломжгүй. Зан үйлийг засах, эрүүл аж төрөх амьдралын хэв маягт суралцах үйл явц нь урт удаан хугацаанд зогсолтгүй үргэлжлэх ажиллагаа юм.



Өвчтөнд насан туршдаа өөрийгөө өөрчлөх аянд гарсан гэдгийг ойлгуулах хэрэгтэй. Гам алдвал өвчин сэдэрэх буюу дахих магадлалтай бөгөөд энэ нь хэдэн ч сар, жилийн дараа тохиолдож болох талтай.



Оюун санаа, зан байдлаа хэрхэн засаж байгаагаас шууд хамаарах асуудал. Өвчтөн цаашид эрүүл байдлаа хадгалахад өөртөө туслах бүлгийн үйл ажиллагаа ихээхэн дэмжлэг болж өгдөг.



Архины хамааралтай хүн АА-гийн хөтөлбөр, мансууруулах бодисын хамааралтай өвчтөн NA хөтөлбөр, мөрийтэй тоглоомын хамааралтай хүн GA хөтөлбөр, хоол хүнсний хамааралтай хүн OA хөтөлбөр гэх мэт дэмжин туслах бүлгийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцсоноор насан туршдаа эрүүл амьдрах боломжтой.



Тиймдээ ч донтох эмгэгийн мэргэжилтнүүд эмчилгээ дууссан өвчтөнд өөртөө туслах бүлгийн арга хэмжээнд үргэлжлүүлэн оролцож эрүүл саруул байдлаа хадгалж амьдрахыг хичээнгүйлэн зөвлөдөг.





## “ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД АРХИНД ДОНТОХ ЭМГЭГТЭЙ ИРГЭДИЙН ДУНД НӨХӨН СЭРГЭЭХ ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙГ 21 АЙМАГТ БОЛОН НИЙСЛЭЛИЙН ЕСӨН ДҮҮРЭГТ БАЙГУУЛАХААР АЖИЛЛАЖ БАЙНА

■ Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх, Сэтгэц наркологийн эмч АУ-ны доктор Н.Дэмидмаа:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт архидалт, донтолт зэрэг нийгмийн сөрөг үзэгдлээс урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар тусгагдсан байдаг. Энэ асуудлын хүрээнд ажиллаж буй зөвлөхийн хувьд танаас асуумаар байна. Төрийн тэргүүн архи согтууруулах ундааны хэрэглээнд онцгой анхаарал хандуулах болсон шалтгаан юу байв?

-Үндэсний статистикийн хорооны мэдээнээс харахад сүүлийн таван жилд согтууруулах ундааны хэрэглээ, үйлдвэрлэл тасралтгүй нэмэгдсэн. Зөвхөн 2022 оны статистикаас харахад нэг хүнд ногдох архи, дарс 8.9 литр, шар айраг 37.1 литр болж өссөн байна. Хэдхэн тоо баримт хэлье. 100 мянган нас баралт тутмын 15.5 нь архины шалтгаанаар хорвоог орхиж байна. Хүн амын 6.2 хувь нь архинд донтсон гэх судалгаа ч бий. Согтууруулах ундааны нөлөөллийн улмаас жилд 4000-4500 орчим хүн энддэг бөгөөд гарч буй нийт гэмт хэргийн 60-70 хувь нь, нийт гэмтлийн 10-12 хувь нь архи согтууруулах ундаа хэрэглэсэнтэй холбоотой байдаг аж. Иймд Ерөнхийлөгч У.Хүрэлсүх 2022 оны дөрөвдүгээр сарын 5-ны өдөр “Засгийн газарт чиглэл өгөх тухай” зарлиг гаргаж, чиглэл өгч байв. Уг зарлигт хэд хэдэн тодорхой санааг тусгасны нэг нь онцгой албан татварын ангилал, шатлалд өөрчлөлт оруулах замаар 38 хувийн хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааны хатуулгийг 10 жилийн хугацаанд жил бүр хоёр хувиар бууруулах тухай байсан. Дэлхийн

олон оронд өндөр хатуулагтай архи, согтууруулах ундааны хатуулгийг үе шаттай бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Тиймээс бид архины хатуулгийг үе шаттай бууруулах бодлого хэрэгжүүлж, архины хэрэглээг бууруулах чиглэл долон үе шаттай ажлуудыг хийж хэрэгжүүлж байна.

**Ерөнхийлөгчийн 43 дугаар зарлигийн хэрэгжилтийн хүрээнд хийгдсэн ажлуудыг тодотгож асуумаар байна?**

-Онцгой албан татварын тухай хуулийн б.1"-д заасны дагуу ногдуулж хураасан татварын орлогын гүйцэтгэлээс татвар ногдсон согтууруулах ундааны литр тутамд хамаарах 300 төгрөгийн орлогыг “Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих сан”-д төвлөрүүлж эхэлсэн. Мөн донтох эмгэгийн тусламж үйлчилгээг хүртээмжтэй болгох зорилгоор Хан-Уул дүүргийн оршин суугчдын согтууруулах ундааны хэрэглээг өрхөд суурилан тогтоох замаар зорилтот бүлгүүд (хэтрүүлэн хэрэглэгч, донтсон, гэр бүл)-д чиглэсэн нийгэм, сэтгэлзүйн цогц тусламж үзүүлэх жишиг тогтолцоог бүрдүүлэхээр дүүргийн ЭМТ-ийг түшиглэн тасаг байгуулж байсан бол өнөөдөр биеэ даасан үйл ажиллагаатай Сэтгэц нийгмийн сэргээн засах төвийг байгуулан ажиллаж эхэллээ. Үүнтэй уялдуулан нийгэм рүү чиглэсэн олон нөлөөллийн ажил хийж архи, согтууруулах ундаа хэрэглэгч хүмүүсийг “архичин” гэж нэрлэх нийгмийн хандлагыг өөрчлөх ажлууд

хийгдэж байна. Бид үр дүн ярих эрт байгаа ч зорьсон ажлуудаа эхэлсэн.

**Сэтгэц нийгмийн сэргээн засах төвд ямар төрлийн эмчилгээ үйлчилгээ үзүүлж байна вэ?**

-Архинд донтох эмгэгийн эмчилгээний цөм нь сэтгэл заслын эмчилгээ юм. Архинд донтох нь архаг өвчин юм. Дахилт өгөх магадлал маш өндөр учраас гамаа хэрхэн барих, яаж үгүй гэж хэлж сурах, уйтгар гуниг, баяр ёслол гээд хүн архи уух сэдээлт өгдөг сэтгэл хөдлөлүүдийг хэрхэн архигүйгээр даван туулах вэ гэдэг гурван том чиглэлийг бүрдүүлж байдаг сэтгэл заслын хөтөлбөрийн дагуу бид эмчилгээ үйлчилгээ үзүүлж байна.

**Энэ салбарын хүний нөөц хэр хүртээмжтэй байна вэ?**

Архины эмчилгээний эмч, сувилагчийн тал дээр хүний нөөц дутагдалтай байна. Эмч нарын ур чадвар олон улсын түвшнээс сул байгаа тул мэргэшүүлэх сургалтыг бид зохион байгуулсан. Тус хөтөлбөрийг нийт сэтгэц аддиктологийн эмч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтнуудад зааж сургаж байна. Архинд донтох өвчтэй хүний судалгааг 2006 онд хийхэд зургаа хүрэхгүй хувьтай байсан бол 2024 оны байдлаар 13% болж өссөн байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд архинд донтох эмгэгтэй иргэдийн дунд нөхөн сэргээх эмчилгээний төвийг 21 аймагт болон нийслэлийн есөн дүүрэгт байгуулахаар ажиллаж байна.

# НИЙГМИЙН СЭТГЭЛ ЗҮЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨГӨӨН

2024.12.17

Улаанбаатар хот

## НИЙГМИЙН СЭТГЭЛ ЗҮЙН ТУЛГАМДСАН АСУУДЛУУД" ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨГӨӨН ТӨРИЙН ОРДОНД ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

“Нийгмийн сэтгэл зүйн тулгамдсан асуудал” үндэсний зөвлөгөөн нь “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд нийгмийн сэтгэл зүйн нөхцөл байдал, сэтгэцийн эрүүл мэндийн салбарын бодлого, хүний нөөц, тусламжийн уялдаа, зохион байгуулалт, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөх зорилготой зохион байгуулагдсан юм. Тус зөвлөгөөнийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн ахлах зөвлөх Н.Хүрэлбаатар нээж үг хэлэв. Зөвлөгөөнд Улсын Их Хурлын гишүүн, Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Л.Энхнасан, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын Монгол

дахь суурин төлөөлөгч Сокорро Эскаленте, Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүн амын сангийн Тэргүүн Халид Шарифи, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Эрүүл мэнд, нийгмийн бодлогын зөвлөх Б.Бадамцэцэг нар оролцлоо. Мөн сэтгэлзүйчид, сэтгэцийн эмч, сэтгэцийн сувилагч, нийгмийн ажилтан, сургуулийн нийгмийн ажилтнууд, ШШЕГ, ЦЕГ-ын албан хаагчид, их сургуулийн багш нар, хувийн сэтгэцийн эмнэлгүүдийн төлөөлөл болон 21 аймгийн ЭМГ-ын мэргэжилтэн, сэтгэцийн эмч нар зөвлөгөөнд хамрагдсан юм.

Зөвлөгөөнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Эрүүл мэнд, нийгмийн бодлогын зөвлөх Б.Бадамцэцэг “Нийгмийн сэтгэл зүйн

тулгамдаж буй асуудал”, ЕТГ, ЭМХТХХ албаны дарга О.Чимэдсүрэн “Монгол Улсын Ерөнхийлөгчийн 43 дугаар зарлиг, түүний хэрэгжилт”, Үндэсний статистикийн хорооны Нийгмийн статистикийн газрын Нийгмийн салбарын статистикийн хэлтсийн дарга Д. Даваажаргал “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны үр дүнг танилцуулах”, Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүн амын сангийн Шадар суурин төлөөлөгч Л.Оюунаа “Монголын 15-34 насны залуучуудын өнөөгийн нөхцөл байдлын судалгааны тайлан”, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал Г.Анхболд “Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төвлөрлийг сааруулах бодлого, цаашид хэрэгжүүлэх ажлууд” зэрэг сэдвээр илтгэл тавьсан юм.





**Монгол Улсын Ерөнхийлөгчийн ахлах зөвлөх, АУ-ны доктор, профессор Н.Хүрэлбаатар:**

ДЭМБ-ын судалгаагаар дэлхийн 8 хүн тутмын нэг нь 970 сая орчим хүн сэтгэцийн ямар нэг тулгамдсан асуудалтай байгаа нь тогтоогдсон байна. Нийт сэтгэцийн эмгэгийн 31 хувь нь сэтгэл түгших, 28,9 хувь нь сэтгэл гутрах эмгэг эзэлж байна. Ард иргэдийн эрүүл мэндийг хамгаалах нэн ялангуяа сэтгэцийн эрүүл мэнд, хүний хөгжлийн асуудалд төрийн бодлогыг чиглүүлэхийн зэрэгцээ нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж иргэдийн идэвх, ухамсар санаачилга, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Манай улсын 880 ЕБС-ийн ердөө 150 нь сэтгэл зүйчтэй ажиллаж байна. Сургууль бүрд сэтгэлзүйч ажиллуулж хүүхэд залуусын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах нь тулгамдсан асуудал юм.



**Монгол Улсын Ерөнхийлөгчийн Эрүүл мэнд, нийгмийн бодлогын зөвлөх Б.Бадамцэцэг:**

1990 оны Монгол улс амиа хорлолтоор азийн бүсэд 5 дугаар байрт явж байсан бол 2005 оноос энэ үзүүлэлтээр хоёрдугаар байрт эрэмбэлэгдэж байна. Насны бүлгээр нь харахад дэлхийд ахимаг насныхан амиа хорлодог бол манай улсад 25-34 насны ид хөгжиж сурах, хөдөлмөр эрхлэх насан дээрээ амиа хорлож байгаа хувь хэмжээ 33,50 байна. Үүнээс харахад сэтгэл зүйч болон сэтгэцийн эмч та бүхний үүрэг хэрэгцээ нийгэмд өндөр байгааг харуулж байна. Салбар хоорондоо уялдаа хамаарал сайтай ажиллаж байж бид үр дүнд хүрнэ. Нийгмийн сэтгэлзүйн сайн сайхан байдлыг сайжруулахад засаглалын бүх түвшинд тэргүүлэх чиглэл болгон ажиллах шаардлагатай байна. Хүн бүрийн хоёр дахь гэр болсон ажлын байр, сургуулийн орчны соёлыг түгээн дэлгэрүүлэх нэн шаардлагатай байна.



**Эрүүл мэндийн сайд “Т.Мөнхсайхан:**

Хувь хүний сэтгэл зүйгээс өрх гэр, албан байгууллага болон нийгмийн сэтгэл зүй хамаарна. Иймээс бид сэтгэл зүйн боловсрол болон сэтгэл зүйн цогц тусламж үйлчилгээг зүүлэх эрүүл мэнд, нийгэм хамгаалал боловсролын цогц тогтолцоог бүрдүүлэх чиглэлд хэрхэн ажиллах талаар та бид өнөөдөр тал бүрээс хэлэлцэх нь нэн чухал юм. Эрүүл мэндийн сайдын хувьд сэтгэцийн эрүүл мэндийн тусламжийн төвлөрлийг сааруулах чиглэлд хэд хэдэн ажлыг төлөвлөж байна. Тухайлбал өсвөр үеийнхэн, ахмад, боловсрол, хөдөлмөр, шүүх, тархи судлал зэрэг чиглэлээр нийгмийн сэтгэл зүйчдийн төрөлжсөн мэргэжилтнийг холбогдох талуудтай хамтран бэлтгэх юм. Сэтгэл зүйн үйлчилгээг өргөжүүлэхэд салбарын уялдаа, чиг үүргийн оновчтой байдлаас үр дүн хамаарах тул та бүхэн тал бүрээс хэлэлцэн хэрэгжихүйц шийдэл зөвлөмж гарна гэдэгт итгэлтэй байна. Зөвлөгөөнөөс гарах санал санаачилгыг бүх талаар дэмжин та хамтран ажиллах болно гэв.



**НҮБ-ын хүн амын сангийн тэргүүн, доктор Халид Шарифи:**

Нийгмийн сэтгэцийн эрүүл мэндийн тал дээр нэгдүгээрт сургуулийн орчны эрүүл мэнд туйлын чухал юм. Хоёрдугаарт, сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг улам бүр нэмэгдүүлэх хэрэгтэй. Гуравдугаарт, амиа хорлолтоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг идэвхжүүлэх юм. Дөрөвдүгээрт, бүх төрлийн хүчирхийлээс урьдчилан сэргийлэх арга замыг улам бүр эрчимжүүлэх хэрэгтэй байна. Тавдугаарт, залуучуудыг хүчирхэг болгох мэдээлжүүлэх шаардлагатай байна. Монголын нийт хүн амын 34.9 хувийг бүрдүүлж буй залуучууд нь улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд нэн чухал үүрэгтэй. Тэдний сэтгэлзүйн эрүүл мэндийн асуудалд анхаарах нь улс орны ирээдүйн төлөө хийж буй чухал ач холбогдолтой хөрөнгө оруулалт болно” хэмээн онцолсон юм.



**Улсын Их Хурлын гишүүн, Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Л.Энхнасан:**

Зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн тархалтын 2013 онд хийгдсэн судалгааны үр дүнг 1984-1992 оны судалгаатай харьцуулбал стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг 10 дахин нэмэгдэж, сэтгэцийн эмгэгийн тархалтын хувьд сэтгэл түгшилт 18 хувь, архаг ядаргаа 16 хувь, нойргүйдэл 17 хувийг эзэлж байна. Иймд бид 2013 онд хийгдсэн дээрх судалгааг олон улсын жишгийн дагуу дахин хийх шаардлагатай байна. Улсын Их Хурлын зүгээс хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлд Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах, “Мэдрэл сэтгэцийн эмгэгийг оношлох асуумж” судалгааг тодорхой давтамжтай хийж сэтгэцийн эрүүл мэндийн талаарх цаашдын бодлогыг тодорхойлоход анхаарна гэлээ.

# САЛБАР ХУРАЛДААН

Тус зөвлөгөөнд ЕТГ-ын Эрүүл Монгол хүн төсөл, хөтөлбөр хариуцсан албаны дарга О.Чимэдсүрэн “Монгол Улсын Ерөнхийлөгчийн 43 дугаар зарлиг, түүний хэрэгжилт” илтгэлийг хэлэлцүүлэв. Тэрээр согтууруулах ундаанаас үүдэлтэй эрүүл мэнд, эдийн засгийн хор хөнөөлийг бууруулах чиглэлд хэрэгжүүлж буй ажлууд, түүний үр дүн, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааг танилцуулав. Зарлигийн хэрэгжилтийг хангах хүрээнд 2022 онд “Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидаг согтуурахтай тэмцэх тухай”, “Засгийн Газрын тусгай сангийн тухай”, “Онцгой албан татварын тухай” зэрэг хуулиудад өөрчлөлт орсон бөгөөд хүн амд чиглэсэн нөлөөллийн ажил хэрэгжүүлээ.



Нийгмийн сэтгэл зүйн тулгамдсан асуудал зөвлөгөөн нь “Сэтгэцийн эрүүл мэнд ба хүний нөөц, салбарын мэргэжилтнүүдийн тулгамдсан асуудал” “Нийгмийн сэтгэл судлалын тулгамдсан асуудлууд болон судалгааны үр дүн”, “Сэтгэцийн эрүүл мэнд ба бусад салбарын уялдаа” зэрэг сэдвийн хүрээнд салбар хуралдаан үргэлжилсэн юм.

Тус зөвлөгөөнөөр Нийгмийн сэтгэцийн эрүүл мэндийн одоогийн тулгамдсан байдлыг тогтоож шийдвэрлэх арга замыг тодорхойлох, архи, тамхины хэрэглээг бууруулахад бодлого боловсруулахад салбар дундын нийт мэргэжилтнүүдийн хамтын оролцоог нэмэгдүүлэх, хамтран ажиллах санал зөвлөмж гаргах, нийгмийн эрүүл мэндийн тусламжийн цар хүрээг нэмэгдүүлэх, хүний нөөцийн хүртээмжийг хангах, тусламж үйлчилгээний хүртээмж нэмэгдүүлэх, салбар дундын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чиглэсэн зөвлөмжүүд гаргалаа.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗАР

“НИЙГМИЙН СЭТГЭЛ ЗҮЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ”  
Үндэсний зөвлөгөөн



Л.БАТТӨР  
ЭМЯ-ны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газрын дарга, АУ-ны доктор



С.БОЛОРМАА  
ДЭМБ-ын Суурин төлөөлөгчийн газрын Халдварт бус өвчний сөрхийлтэл, ялалт хариуцсан мэргэжилтэн



Т.ЦЭНДСҮРЭН  
МУБИС БОС-ийн Нийгмийн ажил арга зүйн тэнхимийн эрхлэгч, доктор дэд профессор



Г.ГАЛСАНЖАМЦ  
МУБИС-ийн Сэтгэл судлал арга зүйн тэнхимийн эрхлэгч, сэтгэл судлалын ухааны доктор

Салбар хуралдаан № 1:  
Сэтгэцийн эрүүл мэнд ба хүний нөөц, салбарын мэргэжилтнүүдийн тулгамдсан асуудал  
Модератор : Монгол Улсын Ерөнхийлөгчийн ахлах зөвлөх Н.ХҮРЭЛБААТАР  
Танхим : / Их монгол танхим /

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗАР

“НИЙГМИЙН СЭТГЭЛ ЗҮЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ”  
Үндэсний зөвлөгөөн



Ө.ЭРДЭНЧИМЭГ  
Когнос Интерэйшнэл ХХК-н захирал, судлаач



Д.ОЮУРСҮРЭН  
АШУУИС, Анагаах ухааны сургуулийн Сэтгэцийн эрүүл мэндийн тэнхимийн дэд профессор, АУ-ны доктор



С.ГАНЖУЯ,  
Геронтологийн үндэсний төвийн мэргэжилтэн, АУ-ны магистр



Ш.БАТСҮХ  
Шяанхэй ухааны доктор, профессор, Монгол улсын гавьяат багш, Монголын сэтгэл зүйчдийн нийгэмлэгийн тэргүүн

Салбар хуралдаан № 2:  
Нийгмийн сэтгэл судлалын тулгамдсан асуудлууд болон судалгааны үр дүн  
Модератор: Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Л.ЭНХНАСАН  
Танхим : / Жанжин Д.Сүхбаатар /

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗАР

“НИЙГМИЙН СЭТГЭЛ ЗҮЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ”  
Үндэсний зөвлөгөөн



У.ХҮРЛӨӨ  
ЭХЖШ-ын Суртал хиймүүл, сэтгэл зүйн заналтын салбарын дарга, докторант, хурандаа



Б.ЖАВЗАН  
Сэтгэл зүй, Сэтгэл Хэмжээл зүйн Үндэсний Хураалтын гишүүн, Удирдах зөвлөлийн дарга, MSc, Oxford



Д.ГАНБАТ  
Нийслэлийн Аудитологийн төвийн дарга, АУ-ны магистр, Клиникийн профессор



Ж.ГАНБУЛГА  
Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Сэтгэл зүйн ухааны албаны мэргэжилтэн, сэтгэцийн эмч

Салбар хуралдаан № 3:  
Сэтгэцийн эрүүл мэнд ба бусад салбарын уялдаа  
Модератор: Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал, АУ-ны магистр Г.АНХБОЛД  
Танхим : / Үндсэн хууль танхим /

# ЕТГ-ЫН “ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД ЕБС-ИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАГШ, АРГА ЗҮЙЧ БЭЛТГЭХ ЧИГЛЭЛД...

Ерөнхийлөгчийн тамгын газраас анх санаачлан 2023 оны 2 дугаар сарын 13-нд **БШУЯ, Боловсролын Ерөнхий газар, Боловсролын Судалгааны үндэсний хүрээлэн, Нийслэлийн Боловсролын Ерөнхий газар, Нийслэлийн Боловсролын үнэлгээний газартай** хамтарсан хэлэлцүүлэг хийж Бүх шатны боловсролын хөтөлбөр дэх эрүүл мэнд, Бие бялдрын хөгжил, сэтгэц, зөв хооллолтын чиглэлийн сургалт, Хүүхдийн эрүүл мэндийн хяналт, тандалтын цахим тогтолцооны талаар хэлэлцүүлэг зохион байгуулсан билээ. Энэхүү хэлэлцүүлгийн үр дүнд ЕБС-ийн эрүүл мэндийн багийг чадавхжуулах шаардлагатай гэж үзэн энэ чиглэлээр шинэ мэргэжилтэн бэлтгэх ажлыг эхлүүлсэн.

Ерөнхийлөгчийн Тамгын газраас БШУЯ-ны харьяа байгууллагуудтай хэд хэдэн удаагийн уулзалт хэлэлцүүлэг хийсэн бөгөөд 2023 оны 11 дүгээр сарын 17-нд БШУЯ-ны дээд боловсролын газар, МУБИС-тай хийсэн уулзалтын үр дүнд МУБИС-ийн **“ЭРҮҮЛ МЭНДИЙН БАГШ БЭЛТГЭХ ХӨТӨЛБӨР”**-ийг шинэчлэн сайжруулахаар дараах ажлуудыг хэрэгжүүлээд байна.



## Монгол улсын БСШУ-ны сайдын

2024 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн А/146 тоот тушаалаар **“БАГШ, ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛ, АРГА ЗҮЙ”**

нэртэй, **6-011439** индексстэй хөтөлбөр батлагдав.

## Хөтөлбөрийг хэрэгжүүлэх МУБИС болон АШУУИС-ийн хамтарсан ажлын хэсэг МУБИС-ийн Ректорын

2024 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн А/176 тоот тушаалаар батлагдав.



## МУБИС болон АШУУИС-ийн захирлын хамтын ажиллагааны гэрээ

2024 оны 5 дугаар сарын 20-нд байгуулагдав.





Сургалтын төлөвлөгөөний нийт 130 багц цагийн мэргэжлийн 80 багц цагийг МУБИС, АШУУИС-ийн багш нар хамтран заана.

2024-2025 оны хичээлийн жилээс “Багш, эрүүл мэнд, арга зүй” мэргэжлийн хөтөлбөрт элсэлт авч эхлэв.

2024 онд үндсэн мэргэжлийн хөтөлбөрөөр 27, хөрвөх хөтөлбөрөөр 2, нийт 29 оюутан элсэн суралцаж эхлэв.



“Багш, эрүүл мэнд, арга зүй” мэргэжлийг сурталчлах ажлын хүрээнд тус мэргэжлийн үнэ цэнийн талаар видео шторк бүхий теле мэдээллийг мэргэжлийн багтай хамтран хийж олон нийтийн сувгаар мэдээлэв.

2024 оны 12 дугаар сарын 05-нд “Эрүүл мэндийн багш, арга зүйч” мэргэжлийн хөтөлбөрийн албан ёсны нээлтийн үйл ажиллагааг Улаанбаатар зочид буудалд хийв.

## “БАГШ, ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛ, АРГА ЗҮЙ” МЭРГЭЖЛИЙН ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖИЖ ЭХЛЭВ



Шинэ мэргэжлээр элсэн суралцагчдын идэвх оролцоог нэмэгдүүлэх, олон нийтэд сурталчлах, мэргэжлийн эрэлт хэрэгцээ, элсэлтийг нэмэгдүүлэх зорилгоор Боловсролын сайд болон Эрүүл мэндийн сайд, удирдах ажилтан, багш, оюутан суралцагчид болон бусад оролцогч талын хамтарсан уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулав.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/146 дугаар тушаалын хавсралтаар “Багш, Эрүүл мэндийн боловсрол, арга зүй” /6-011439/ мэргэжлийн хөтөлбөрийн нэрийг шинэчлэн баталсан. Тус хөтөлбөрийг МУБИС, АШУҮИС хамтран хэрэгжүүлж байна.

Эрүүл мэндийн хичээл 2018-2019 оны хичээлийн жилээс ерөнхий боловсролын сургуулийн 4-12 дугаар ангид бие даасан хичээл болж, сургалтын төлөвлөгөөнд заавал судлах агуулгаар хэрэгжиж байна.



**2518** БАГШ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ХИЧЭЭЛИЙН

НИЙТ



ҮҮНЭЭС  
**49%**

БИОЛОГИ, ЭРҮҮЛ  
МЭНДИЙН БАГШ



## ЭРҮҮЛ ЭХ НЯЛХАС ЖИРЭМСНИЙ БҮЛГИЙН ХЯНАЛТ:



**НИЙТ: 1.7 САЯ ЭМЭГТЭЙ**

Жирэмсний бүлгийн хяналт нь эхчүүдэд жирэмсний хяналтын хугацаанд өөрийгөө болон хүүхдээ асрах, эрүүл бойжуулах, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх цогц сургалтыг практикт тулгуурлан явуулах замаар эх, хүүхдийн эрүүл мэндийг сайжруулах

суурь сэргийлэлтийн арга хэмжээ юм.

Монгол улсад жилдээ 60 гаруй мянган эх жирэмсний хяналтанд шинээр хамрагддаг байна. Эрүүл Монгол хүн үндэсний хөдөлгөөний хүрээнд жирэмсэн эхчүүдэд эрүүл мэндийн боловсрол олгох, жирэмсний бүлгийн хяналт хэмээх ДЭМБ санаачилгыг хэрэгжүүлэх загвар төслийг ЭМЯ, ЭХЭМҮТ, ЭНЭҮТ-2 хамтран хэрэгжүүлж байна.

Манай улсын хувьд жирэмсний хяналтын хамралтын хувь өндөр хэдий ч төрөхийн өмнөх, төрөх үеийн болон дараах хүндрэл түгээмэл тохиолдсоор байна. Жирэмсний бүлгийн хяналт нь эхчүүдэд жирэмсний хяналтын хугацаанд өөрийгөө болон хүүхдээ асрах, эрүүл бойжуулах, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх цогц сургалтыг практикт тулгуурлан явуулах замаар эх хүүхдийн эрүүл мэндийг сайжруулах суурь сэргийлэлтийн арга юм.

"Жирэмсний бүлгийн хяналт"-ын сургагч багш бэлтгэх сургалтыг ЭМЯ болон холбогдох төвүүд хамтран 2024 оны 11 сарын 22-24 өдрүүдэд төслийн баг зохион байгуулсан бөгөөд эх барих эмэгтэйчүүдийн их эмч, өрхийн их эмч, эх баригч болон сувилагч нар хамрагдлаа. Сургагч багшийн удирдлагаар ЭНЭҮТ-2 болон Хан-уул дүүргийн ЭМТ дээр жирэмсний бүлгийн хяналтыг хэрэгжүүлэх ажил эхэллээ.

МОНГОЛ УЛС ДАХЬ ТӨРӨХ  
НАСНЫ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ТОО

**750 000**

1 ЖИЛД ТӨРӨЛТИЙН  
ДУНДАЖ ТОО

**75 000**


**ЖИРЭМСНИЙ  
БҮЛГИЙН ХЯНАЛТ НЬ  
ДАРААХ ХҮНДРЭЛИЙГ  
БУУРУУЛАХАД АЧ  
ХОЛБОГДОЛТОЙ**

**40%**

Жирэмсэн болон  
төрсний дараах хүндрэл



**48%**



Жирэмсэн  
үеийн хүндрэл

**41.4%**



Төрөх үеийн  
хүндрэл

**2.3%**



Төрсний дараах  
үеийн хүндрэл

### ЖИРЭМСНИЙ БҮЛГИЙН ХЯНАЛТ



### ЖИРЭМСНИЙ ХЯНАЛТ:

- 1 эх - 8 удаа
- Нийт 560 000 удаагийн үзлэг
- Эх барих эмэгтэйчүүдийн эмч -923

## ЭРҮҮЛ ЭХ-НЯЛХАС

**1** Жирэмсний хяналтын өнөөгийн байдлын үнэлгээ

**3** Үнэлгээнд тулгуурлан жирэмсний хяналтыг сайжруулах эрх зүйн өөрчлөлт хийх

**2** Жирэмсний бүлгийн хяналтын (ЖБХ) аргыг нэвтрүүлэх

- ЖБХ-ын хөтөлбөр боловсруулах
- Орчин бүрдүүлэх
- Багийг сургах
- ЖБХ-ыг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх





## “ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД ЦЭРЭГ ТАТЛАГЫН ҮЙЛ ЯВЦ, ЦЭРГИЙН НАСНЫ ЗАЛУУЧУУДЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГИЙН ЧАНАР, ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХИЙН ТУЛД ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТЭД ОНЦГОЙ АНХААРНА

“Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд Монгол Улсын батлан хамгаалах салбарын алба хаагчид тэр дундаа цэргийн насны залуучуудыг эрүүлжүүлэх, түгээмэл тохиолдож буй өвчлөлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн Батлан хамгаалах, цэргийн бодлогын зөвлөх бригадын генерал Д.Баасандамба, Эрүүл мэнд, нийгмийн бодлогын зөвлөх Б.Бадамцэцэг, Батлан хамгаалахын сайдын зөвлөх Д.Эрдэнэбат нар Цэргийн төв эмнэлэгт ажиллалаа. “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөнийг цаашид улам эрчимжүүлж, хэрэгжилтийг хангах хүрээнд Цэргийн төв эмнэлэг, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагын эрүүл мэндийн төвүүдийн үүрэг, оролцоог тодорхойлж, цаашлаад хугацаат цэрэг татлагын үйл явц, цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн үзүүлэлтэд онцгой анхаарч эрүүл мэндийн үзлэгийн чанар, үр нөлөөг дээшлүүлэх талаар эмнэлгийн удирдлага, эмч мэргэжилтнүүдтэй санал солилцсон юм.




Цэргийн насны залуусын дунд хугацаат цэргийн албанаас эрүүл мэндийн шалтгаанаар тэнцэхгүй, чөлөөлөгдөх байдал жилээс жилд нэмэгдэж байна.

Цэргийн насны залуусын өвчлөл их байх нь Монгол Улсын аюулгүй байдалтай шууд холбоотой юм. Иймээс цэргийн насны залуусын өвчлөлийг судлах зайлшгүй шаардлагатай байна.


Үндэсний аюулгүй байдлын дэд систем болох хүн ам, удмын сангийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байна.

Зэвсэгт хүчний байнгын бие бүрэлдэхүүний нөхөн хангалт нь цэргийн насны залуусын эрүүл мэндийн байдал, өвчлөлөөс шууд хамааралтай байдаг.





Эрүүл мэндийн шалтгаанаар чөлөөлөгдсөн нийслэлийн цэргийн насны залуусын эрүүл мэндийн байдал, хувиар




Эрүүл мэндийн шалтгаанаар чөлөөлөгдсөн хөдөө орон нутгийн цэргийн насны залуусын эрүүл мэндийн байдал, хувиар




2023 оны цэрэг татлагаар эрүүл мэндийн шалтгаанаар тэнцээгүй иргэдийн тоог сүүлийн 5 жилийн дундажтай харьцуулсан байдал




Монгол Улсын цэргийн насны залуусын эрүүл мэндийн байдал, өвчлөл, өвчлөлийн бүтэц (сүүлийн 6 жилийн үзүүдэлт)



Дотрын өвчин эмгэг (хувь)



Цэргийн насны залуучуудын зарим өвчний судалгаа



Цэргийн төв эмнэлгийн дарга-ерөнхий эмч, хурандаа Б.Энх-Од:

# УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЖ БОЛОХ ӨВЧИН ЦЭРГИЙН НАСНЫ ЗАЛУУСЫН ДУНД ТҮГЭЭМЭЛ БАЙНА



## -Цэргийн төв эмнэлэг цэрэг татлагын үйл явцад ямар үүрэгтэй оролцдог вэ?

Нийслэл, дүүрэг болон аймгийн цэргийн штаб, цэргийн товчооны эрүүл мэндийн үзлэгээр тэнцээд ирсэн залуучуудад бид эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж ажилладаг. Хугацаат цэргийн алба хаагч нь бие болон сэтгэцийн хувьд эрүүл байх ёстой учраас бид хяналтын шатны үзлэгийг ЗГ-ын 2024 оны 140 дүгээр тогтоолын дагуу явуулдаг. Алба хаагчид цэргийн алба хааж байгаа хугацаанд эрүүл мэндийн асуудлыг Цэргийн төв эмнэлэг лавлагаа шатны тусламж үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй оролцдог.

## -Анхан шатны үзлэгтээ тэнцсэн ч Цэргийн төв эмнэлгийн хяналтын үзлэгт тэнцээгүй цэргийн насны иргэдийн эрүүл мэндийн асуудлыг хэрхэн шийдвэрлэж байна вэ?

Цэргийн төв эмнэлгийн хяналтын үзлэгт тэнцээгүй буцсан иргэд тухайн аймаг нийслэл, дүүргийн цэргийн штабт мэдэгдэн, харьяа эрүүл мэндийн байгууллагаараа үзүүлж эмнэлгийн хяналтад

орж дараагийн цэрэг татлагаар эрүүлжсэн байх үндсэн зураглалтай. Гэвч энэ цаг үед хувь хүний эрүүл мэндийн боловсрол, хариуцлагагүй байдлаас эрүүлжих болон хяналтад орох арга хэмжээг авч хэрэгжүүлэхгүй байна. Тиймээс цэргийн штаб болон цэргийн товчоодын эмч нарын эрүүл мэндийн үзлэгийг чанаржуулах, аль аль талдаа хариуцлагын тогтолцоог бий болгох, эрүүл мэндийн боловсролыг олгох шаталсан сургалтыг ерөнхий боловсролын сургалтад хамруулах, цэргийн насны залуусын өвчлөлийн бүтцийн тухай мэдээллийг эрүүл мэндийн төвүүдээс авч нэгдсэн мэдээллийн нэг дата сан байгуулж, түүнд тулгуурласан эрүүлжүүлэх төлөвлөгөө боловсруулах шаардлага гарч байна. Аймаг, нийслэл, дүүргийн цэргийн товчоонууд дээр цэргийн насны залуучуудын бүрэн судалгаа хэрэгтэй байна. Тус судалгаа цэргийн албаа хаагаад ирсэн, цэрэгт ирээд эрүүл мэндийн шалтгаанаар буцаагдсан, цэргийн албанд очихгүй байгаа цэргийн насны залуус гэсэн ангиллаар хийгддэг байх жишээтэй. Цэргийн албанд эрүүл мэндээрээ тэнцээгүй иргэдийг эмчилж эрүүлжүүлдэг, өөрсдөө эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлдэг болсон цагт цэрэгт эрүүл мэндээрээ тэнцдэг залуусын тоо нэмэгдэх боломж байгаа юм.

**-Цэрэг татлагын үеийн эрүүл мэндийн үзлэг бол нэг төрлийн эрт илрүүлэг юм. Өвчлөлийг илрүүлсэн бол эмчлэх учиртай. Гэтэл та цэрэгт**

## тэнцсэнгүй гээд явуулчхаад байна?

Аймаг, нийслэл, дүүргийн цэргийн товчоодод ажиллаж байгаа эмч нар болон цэргийн штабууд нэгдсэн ойлголттой нэгдсэн тогтолцоотой байх нь маш чухал. Түүнийг бид нэгдсэн зөвлөгөөн, хэлэлцүүлэг хийж нэг замын зураглал гаргана. Бид энэ дагуу асуудал хариуцсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөхүүдтэй хамтран ажиллаж 2025 оны 2 дугаар улиралд багтаан улсын зөвлөгөөнийг хийхээр төлөвлөн ажиллаж байна. Ингэснээр иргэн бүр хариуцлагатай байж

I эрүүл мэндийн боловсролыг сайжруулах

II нийтийн биеийн тамир спортоор хичээллэх

III эрүүл зөв хооллолтын хөтөлбөрүүдийг үр дүнтэйгээр нийтэд сурталчлан ойлгуулснаар Эрүүл Монгол хүн бий болно. Эрүүл Монгол хүн улсаа хамгаалж, хөгжүүлж чадна.

## -Сүүлийн үед цэрэгт эрүүл мэндээрээ тэнцэхгүй залуусын тоо нэмэгдсэн. Үүний суурь шалтгааныг та хэрхэн харж байна вэ?

Цэргийн насны иргэдийн өвчлөлийн эхний 3 байранд бүрэн эдгэрч болох өвчин эмгэг байгаа нь энэ насны залуусын эрүүлжүүлэх, эрүүл ахуйн байдлыг сайжруулахад дорвитой арга хэмжээ авах шаардлагатай байгааг илтгэж байна. 2024 оны хувьд бид эрүүл мэндийн үзлэгийн уламжлалт аргаасаа өөрөөр цэргийн төв эмнэлгийн дамжин



үзлэг орохгүйгээр эхний үзлэг буюу аймаг, нийслэл, дүүрэг дээр эрүүл мэндийн үзлэг хийгдсэний дараа цэргийн албанд татсан цэргүүдийг сургалт бэлтгэлдээ оролцож байх хугацаанд нь манай эмнэлгээс хоёр баг гарч явуулын үзлэг шинжилгээ, оношилгоо хийсэн. Ингэхэд цэрэгт тэнцээд татагдсан иргэдийн 15.8 хувь нь эрүүл мэндийн шалтгаанаар хасагдаж байна. Бага наснаас нь эрүүл мэндийн боловсролыг чанартайгаар олгомоор байна. Эрүүл мэндийн боловсрол дээр тусдаа хөтөлбөр гаргаад багаас нь зааж сургах шаардлага тулгарчээ. Иргэн хүний үүргийн хувьд харьяа эрүүл мэндийн байгууллагаараа үйлчлүүлж жилдээ 1-2 удаа эрүүл мэндийн үзлэгт хамрагддаг байх хэрэгтэйг эрүүл мэндийн хичээлээр зааж ойлгуулмаар байна. Манай дээр хийгдсэн зарим судалгаанаас харахад цэргийн насны залуучуудад амьдралын хэв маягаас шалтгаалсан гурван төрлийн өвчин эмгэг түлгээмэл байна. Өөрөөр хэлбэл урьдчилан сэргийлж болох өвчлөл цэргийн насны залуусын дунд их байгаа юм. Цэргийн насны залуус биеийн хөдөлгөөн дутмаг, интернэт, гар утас, компьютерын хэрэглээ хэтэрсэн байгаагаас тэдний эрүүл мэндэд сөрөг нөлөө үүсэж байна. Дараагийн том асуудал бол буруу хоол хүнсний хэрэглээ байна. Цэргийн төв эмнэлэг дээр хяналтын үзлэгт ороод хасагдаж

байгаа иргэдийн 36 хувь нь хоол боловсруулах эрхтэн тогтолцооны эмгэгтэй байгаа нь буруу хооллолт, эрүүл мэндийн боловсролтой шууд холбоотой юм. Тэдний дийлэнх нь өглөөний цай уухгүй байна, хэт өлсөх, хэтрүүлж идэх гэх мэт буруу дадал зуршлууд эрүүл мэндэд нь муугаар нөлөөлөөд зогсохгүй сэтгэцийн эрүүл мэндэд ч сөрөг нөлөөллийг дагуулж байна.

**-Нийт цэрэг татлагад хамрагдаж байгаа залуусын тодорхой хувь нь сэтгэцийн тулгамдсан асуудалтай байгааг судалгаа харуулжээ. Энэ талаар тодруулахгүй юу?**

Өнөөдөр эрүүл гэх тодотгол нь эрүүл бие бялдраас гадна сэтгэцийн хувьд эрүүл байхыг хэлж байгаа юм. Хувь хүний муу зуршлууд яваандаа сэтгэцийн тулгамдсан асуудлын суурь шалтгаан болж байна. Сэтгэцийн тулгамдсан асуудал дээр бүх хүнийг сэтгэцийн өөрчлөлтэй гэж хэлж болохгүй ч гэсэн анхаарал төвлөрөл байхгүй, стресстэйгээр зургаан сараас дээш амьдрахад сэтгэцийн тулгамдсан асуудалтайд тооцогдоно. Сүүлийн үед архи, тамхи, мансууруулах бодисын хэрэглээтэй хүмүүсийг хүртэл сэтгэцийн тулгамдсан асуудалтайд тооцож байгаа нь бид энэ талаар сайн ажиллах хэрэгтэйг харуулж байна. Манай залуу үе нийтийн биеийн тамир, спортод идэвхтэй хамтрагддаг болох нь сэтгэцийн

эрүүл мэндийг хамгаалах гол арга зам юм. Энэ бүхэн нийгэмшилд өндөр үүрэгтэй юм. Хүн бүр өөрийн насанд тохирсон хөдөлгөөн хийж нийтийн биеийн тамираар хичээллэдэг болох хэрэгтэй байна. Залуусын эрүүл мэнд хувь хүний эрүүл мэндийн байдалд төдийгүй үндэсний аюулгүй байдалд хүртэл нөлөөлөхүйц түвшинд хүрч байгааг сүүлийн үеийн судалгаанууд харуулж байна.

**-Цэргийн насны залуусын эрүүл мэндийг сайжруулахад ямар шийдэл байна вэ? Энэ жил эрүүл мэндээрээ тэнцээгүй ч дараа жил эрүүл болоод цэрэг татлагадаа хамрагддаг тогтолцоог хэрхэн бүрдүүлэх үү?**

2024 оны 10 дугаар сард эрүүл мэндээрээ тэнцээгүй иргэн 2025 оны 10 дугаар сард тус оношоороо цэрэг татлагад хамрагдах нь эдийн засаг, цаг хугацааны хувьд их хохиролтой юм. Тус асуудал дээр хувь иргэн болон тухайн харьяаллын цэргийн товчоо аль аль талаасаа хариуцлагатай хандах нь их чухал. Дараа жил та цэрэг татлагад хамрагдахад эрүүл мэндийн асуудалгүй боллоо гээд явуулдаг байх хэрэгтэй юм. Энэ бодлого ажиллуулахын тул цэргийн насны залуусын нэгдсэн дата сан аймаг, нийслэл, дүүрэг дээр үүсэх хэрэгтэй. Тус санг цэргийн төв эмнэлэгт холбоод өгөх юм бол манай эмнэлэг тодорхой төслүүд дээр гүйцэтгэл хийгээд явж болно.

Тиймээс бидэнд нэгдсэн ойлголт, олон талт хариуцлага, ажлын чанар гэдэг зүйлүүд чухал байна. Аймаг, нийслэл, дүүргийн цэргийн штабууд дээр гол хяналт, эмчилгээг хийх юм. Анхан шатны цэргийн үзлэгт эрүүл мэндээр тэнцээгүй иргэнийг араас нь хөөцөлдөж эмчилж эрүүл болгох нь одоогийн шийдэл байх ч энэ нь 5 жилийн дараа илүү боловсронгуй болох нь гарцаагүй. Цэргийн штабаас хуулийн хүрээнд иргэн эрүүл мэндийн асуудлаа шийдвэрлүүлж эрүүл болсныгоо илтгэж мэдэгддэг болох шаардлага байна. Ийм ухамсрын тогтолцоог мөн суулгаж өгөх хэрэгтэй байна.

## ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН - ЗӨВ ЗОХИСТОЙ ХООЛЛОЛТ БҮЛГИЙН ЗОРИЛГО

Хүн амын хооллолт, шим тэжээлийн асуудлыг төрийн бодлогын анхааралд оруулж, хүүхдийн бие бялдрын болон оюуны өсөлт, хөгжлийг ханган, Эрүүл Монгол хүнийг бий болгож хүн амын эрүүл мэндийг сайжруулж эрүүл хүнсний хэрэглээ ба зөв хооллолтын мэдлэг хандлагыг дээшлүүлэхэд чиглэнэ



СУРГУУЛИЙН ҮДИЙН ХООЛ  
ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛДЭГ

НИЙТ ОРНЫ  
**93%**

ТӨРИЙН САНГААС САНХҮҮЖҮҮЛДЭГ

### СУРГУУЛИЙН ҮДИЙН ХООЛ

*School lunch program*

1899 оноос Европт эхэлсэн  
1946 онд АНУ анхны хууль баталсан

### ӨНДӨР ОРЛОГОТой УЛС

100% хоолны үйлчилгээнд төлбөрийн  
ялгаатай системээр хамрагддаг

### ДУНД ОРЛОГОТой УЛС

50% орчим нь сургууль дээрээ үнэгүй  
хооллодог

### БАГА ОРЛОГОТой УЛС

18% орчим хамрагддаг


### 2020 оны

*байдлаар дэлхий дээр*

161 орны

418 сая

*буюу нийт сурагчийн*



2 хүүхэд тутмын 1 нь

*халуун хоол сургууль  
дээрээ иддэг*



### ДЭЛХИЙ ДАЯАР

*сургуулийн хоолыг  
хөгжүүлсний төлөө*

2000 оны

*Нобелийн шагналыг*

**НҮБ-ын дэлхийн**

**хүнсний хөтөлбөр**

*хүртлээ*

Сургуулийн үдийн хоол хөтөлбөр нь дэлхийн 85 оронд  
хэрэгжиж 4 сая орчим ажлын байр бий болгодог.




## МОНГОЛ УЛСАД ХҮҮХДИЙН ХООЛЫГ ЗАЙЛШГҮЙ АНХААРАХ ШААРДЛАГАТАЙ


Бага насны хүүхдийн  
Таргалалтын үзүүлэлт 2013  
оноос эхлэн дэлхийн болон  
бүсийн дунджаас давсан.

Хүүхдийн таргалалтыг  
бууруулахад ямар нэгэн  
зоригтой арга хэмжээ  
аваагүй байна.


АЗИ НОМХОН ДАЛАЙН БҮС НУТАГТ МАНАЙ УЛС БАГА НАСНЫ  
ХҮҮХДИЙН ТАРГАЛАЛТЫН ЖАГСААЛТЫН СҮҮЛД ОРЖ БАЙНА




## ХООЛ ТЭЖЭЭЛИЙН БАЙДАЛ




Тураалтай (дунд ба хүнд)




Тураалтай (хүнд)




Өсөлт хоцролттой (хүнд)




Өсөлт хоцролттой (хүнд)




Туранхай (дунд ба хүнд)



Туранхай (хүнд)




Илүүдэл жинтэй  
(дунд ба хүнд)




Илүүдэл жинтэй (хүнд)

## ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ДӨРВӨН БҮРЭЛДЭХҮҮНИЙ НЭГ БОЛОХ ЗӨВ ЗОХИСТОЙ ХООЛЛОЛТЫН ЧИГЛЭЛД БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДЭСЛЭЛ



### ХҮРЭХ ҮР ДҮН:



# СУРГУУЛИЙН ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖИШИГ ТОГТОЛЦООГ СУУРЬШУУЛАХААР УВС АЙМГИЙГ СОНГОН АЖИЛЛАЖ БАЙНА

■ Хоол зүйч, доктор, дэд профессор М.Пүрэвжав:

**Нийгмийн эрүүл мэндийг сайжруулах үндсэн хүчин зүйл бол хүн амын хоол, хүнс болон хооллолт гэж та дурдсан байсан? Тус сэдвээс яриагаа эхэлье?**

Нийгмийн эрүүл мэндийг сайжруулах нь олон хүчин зүйлээс шалтгаалах хэдий ч үндсэн хүчин зүйл бол хүн амын хооллолт юм. Хооллолт гэдэг нь өдөр тутмын хоолоор авч буй шим тэжээлийн эрүүл зөв харьцаа бүхий хэмжээгээр илэрхийлэгдэх бөгөөд үр тариа, хүнсний ногоо, жимс, мах, сүү, сүүн бүтээгдэхүүн өдөр бүр хэрэглэх тухай асуудал юм. Манай улс харьцангуйгаар бэлчээрийн малын мах, сүү, атар газрын гурил будаатай гэж үзэж болох бөгөөд манай улсын хувьд хүн ам нь эрүүл хүнсээр хангагдах бүрэн боломж бий. Өөрөөр хэлбэл хүнсний хангамж, хүртээмж нь гол асуудал бөгөөд дотоодын чанартай, хямд найдвартай хүнсний хангамжийн тогтолцоо бүрдэх нь нийгмийн эрүүл мэндийг сайжруулах том суурь гэж хардаг.

**“Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээг сайжруулах чиглэлд ямар ажлууд хийгдэж байна вэ?**

“Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний дөрвөн бүрэлдэхүүний нэг болох эрүүл зөв хооллолтын хүрээнд ЕБС-ийн хоолны үйлчилгээг хуулийн хэрэгжилтийг хангаж, сайжруулах зорилготой ажиллаж байна. Аливаа хүнийг бага наснаас нь зөв хооллох, эрүүл хооллож сургах, хоол шим тэжээлийн мэдлэгтэй болгох нь Эрүүл монгол хүн бий болохын суурь юм. Бага наснаас зөв хооллож, иргэнээ эрүүл байлгах нь өвчилсний дараа эмчлэхээс илүүтэй нийгэм, хүний хөгжил, эдийн засгийн ач тустай болохыг Дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрсөн тул сургуулийн хоолны системийг хөгжүүлж байгаа билээ. Эрүүл хүүхэд амжилттай сурч хөгжин ирээдүйн эрүүл иргэн хөдөлмөрийн талбарт гарах юм. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний систем бүрдэж байж амжилттай



ХООЛ ЗҮЙЧДИЙГ  
ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТАД  
Увс аймгийн  
СУРГУУЛИЙН

19  
ХООЛ ЗҮЙЧИД  
хамрагдав



хэрэгждэг тул жишиг тогтолцоог хөгжүүлэхээр Увс аймгийг сонгон ажиллаж байна. Увс аймаг аймгийн боловсролын газарт хамгийн түрүүнд мэргэжлийн хоол зүйч ажиллуулсан, нийт сургуулийнхаа 70%-ийг мэргэжлийн боловсон хүчнээр хангаж чадсан аймаг юм. “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний 2025 оны төлөвлөгөөнд эрүүл зөв хооллолтын чиглэлээр олон ажил тусгагдсан. Сургуулийн хүүхдийн хоол үйлдвэрлэлийн тогтолцоог хөгжүүлж жишиг аймгийг бий болгох ажил эхэлсэн. Увс аймгийн сургуулийн хоол зүйчдийг чадавхжуулах сургалтад тус аймгийн 19 хоол зүйч хамрагдлаа.

**Судлаачид хоолны хэт хэрэглээ өвчлөлд хүргэх хүчин зүйл болж байгааг хэлэх болсон. Энэ талаар таны байр суурь юу вэ?**

Өнөөдрийн байдлаар нийгмээрээ хоол, шим тэжээлийн зөв мэдлэггүй, буруу зөрүү хяналтгүй мэдээллээс хамаарч, идэж ууж байгаа зүйлээ хоол хүнс биш болгочоод байна. Хооллолт стрессийн нэг хүчин болоод удаж байх шиг байна. Энэ бас л өвчний эхлэл. Согтууруулах ундааны

хэрэглээ үлэмж хэтэрчихсэн байна. Мөн хоосон илчлэгтэй чихэрлэг ундаа, чипс зэргийн хэрэглээ хүүхэд багачуудын дунд эрс ихэссэн. Насанд хүрэгчдийн хоол хүнсний буруу хэрэглээ хүүхэд багачуудыг буруу дадалд хөтөлж байна. Хоол хүнсний хэрэглээнээс үүдэж зүрх судас, чихрийн шижин, яс сийрэгжих зэрэг халдварт бус өвчлөл газар аваад байгаа юм. Ихсээд байгаа хорт хавдрын шалтгаан ч хооллолттой шууд холбоотой. Шалтгааныг арилгаагүй цагт өвчлөл ихэссээр байх болно. Шалтгааныг бууруулах, арилгах нь манай үйл ажиллагааны зорилго юм.

**Эрүүл зөв хооллож эхлэхэд юуг анхаарах вэ?**

Хооллолт уг нь маш энгийн, хүн бүрийн өдөр тутмын зүйл. Өглөөний цай ууж хэвш, оройн хоолыг оройтуулмааргүй байна. Ингэж хэлэхээр ажил их, түгжрэл гээд олон шалтгааныг хүмүүс хариулдаг. Энэ хотынхны шалтгаан байж, тэгвэл хөдөө орон нутагт амьдарч байгаа хүмүүс ялгаагүй байгаа нь судалгаагаар харагддаг. Өвлийн улиралд махаа идлээ гэхэд зун цагт

багасгаад сүү цагаан идээгээ түлхүү хэрэглэх нь монгол хүний хувьд эрүүл хооллолтын анхны алхам гэсэн үг. Эмнэлгийн байгууллагаар батлагдаж, оношлогдоогүй бол цагаан гурилыг хэмжээг нь тааруулаад ид. Бүх хоол, хүнсний хэмжээг тааруулж хэрэглэх нь эрүүл байхын үндэс юм. Хэт их хязгаарлалттай олон янзын хоолны дэглэм барих нь сөрөг нөлөө өндөр байхыг үгүйсгэхгүй. Мэргэжлийн бус хооллолтын зөвлөмжийг дагаж, өөртөө стресс үүсгэмээргүй байна. Эрүүл зөв хооллолтын үр өгөөж улс орны эдийн засагт чухал нөлөө үзүүлдэг. Аз жаргал болон хүний хөгжлийн индексийг дээшлүүлэх маш том хүчин зүйл учраас хооллолт бол маш чухал ойлголт юм. “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний дөрвөн бүрэлдэхүүний нэг болох эрүүл зөв хооллолтын хүрээнд Монголчуудын, ялангуяа хүүхдийн хоол, шим тэжээлийн байдлыг дэмжсэнээр ирээдүйд нийгмийн эрүүл мэндийг сайжруулах, дундаж наслалтыг нэмэгдүүлэх, хүйс хоорондын зөрүүг ойртуулахад чиглэсэн бодлогын ажлууд өрнөж байна.

## ЯПОНЫ ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛҮҮД ЭРҮҮЛ МЭНДИЙН МЭДЭЭЛЛИЙГ ШИНЖЛЭХ УХААНД СУУРИЛСАН, ХАРИУЦЛАГАТАЙ, ИРГЭДЭД ОЙЛГОМЖТОЙ БАЙДЛААР ТҮГЭЭДЭГ ОНЦЛОГТОЙ



ХИС-ийн Сэтгүүл зүй, медиатехнологийн тэнхимийн эрхлэгч, доктор, профессор Д.Дагиймаа

**Гадаадын эрүүл мэндийн сэтгүүл зүйн хөтөлбөртэй сургуулиудыг судалж, харьцуулж, эрүүл мэндийн сэтгүүл зүйн хөтөлбөрөө боловсруулсан гэсэн. Манайд хэрэгжих хөтөлбөрийн онцлог юу вэ?**

Хүн амын дунд өвчлөл өндөр байгаа, ХМХ-үүд эрүүл мэндийн чанартай, мэдээлэлд зай талбайгаа бага өгдөг, мөн эрүүл мэндтэй холбоотой сэдвээр ташаа мэдээлэл их гарч байгаа зэрэг олон асуудал байгаа нь иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх шаардлагатай гэдгийг харуулж байна. Гэтэл Монголын сэтгүүл зүйн сургуулиуд "Сэтгүүлчийн ур чадвар", "Сэтгүүлчийн ёс зүй", "Практик сэтгүүл зүй" зэрэг сэтгүүл зүйн хичээл болон мэргэжлийн дадлагын агуулгад эрүүл мэндийн тогтолцоог ойлгох, энэ сэдвийг сурвалжлах, бичих, ёс зүйн анхаарах үндсэн зарчмыг багтаан зааж байна. Ийнхүү цөөн цагт энэ ойлголт, мэдлэгийг өгч байгаа учир энэ чиглэлээр мэргэшсэн сэтгүүлч цөөн.

Харин өнөөдөр дэлхийн олон нийтийн мэдээлэл харилцааны сургуулиуд хөтөлбөртөө эрүүл мэндийн асуудлыг хэрхэн сурвалжилж олон нийтэд хүргэх тухай агуулгыг ямар нэгэн хэмжээгээр оруулжээ. "Эрүүл мэндийн сэтгүүл зүй", "Эрүүл мэндийн асуудлыг мэдээлэх нь"

зэрэг бие даасан хичээлийг заадаг бол зарим сургууль эрүүл мэндийн сэтгүүл зүйн чиглэлээр мэргэшиж төгсөх хөтөлбөртэй байна. Мөн эрүүл мэндийн сэтгүүл зүйгээр магистрын хөтөлбөрийг бас санал болгодог байна.

Дэлхийн их сургуулиудын зэрэглэлийг тогтоодог "QS World University Rankings" байгууллагаас 2024 онд Харилцаа, хэвлэл мэдээллийн салбарын эхний XV багтсан сургуулиудад орсон байна. Тухайлбал, III эрэмбэлэгдсэн Өмнөд Калифорнийн Их Сургууль, XIII эрэмбэлэгдсэн Мичиганы их сургууль, XV эрэмбэлэгдсэн Колумбийн их сургууль нь Эрүүл мэндийн сэтгүүл зүйн хөтөлбөртэй байна. Энэ мэтчилэн дэлхийн шилдэг сургуулиудын хөтөлбөрийг судалсны үндсэн дээр ХИС, СУИС, МУБИС-ийн сэтгүүл зүйн багш нар хамтран Эрүүл мэндийн сэтгүүл зүйн хөтөлбөрийг боловсруулаа. Хөтөлбөр маань Эрүүл мэндийн тухай үндсэн ойлголт, Эрүүл мэндийн сэтгүүл зүйн үндсэн ойлголт, Эрүүл мэндийн сэдвээр мэдээ, нийтлэл бичих арга зүй, Эрүүл мэндийн тодорхой сэдвүүдээр мэдээлэх гэсэн дөрвөн модуль хэсгээс бүрдэж байгаа.

Энэ хөтөлбөр батлагдсанаас хойш 5 их сургууль хөтөлбөртөө багтаасан учир ирэх жилээс Эрүүл мэндийн сэтгүүл зүй хичээлийг орж эхэлнэ.

**Оюутнууд эрүүл мэндийн сэтгүүлзүйн хөтөлбөрөөс ямар ур чадвар, мэдлэг эзэмших вэ?**

Эрүүл мэндийн мэдээллийг түгээхэд хэвлэл мэдээллийн хэрэгсэл чухал үүрэг гүйцэтгэдэг. Хүн өөрийгөө өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдтэй харилцах, мэдээлэл, нотолгоонд суурилсан эрүүл мэндийн шийдвэр гаргахад эрүүл мэндийн суурь боловсролтой байх нь хамгийн чухал. Эрүүл мэндийн суурь боловсрол багатай хүмүүс яаралтай тусламжийн тэргээр өвчнөө хүндэрсэн хойно эмнэлэгт ирдэг, улмаар хэвтэн эмчлүүлэх хугацааг улам уртасгадаг, өгөгдсөн эмчилгээг дагадаггүй ба нас барах эрсдэл илүү өндөр байдаг.


Эрүүл мэндийн асуудал нь хүн төрөлхтний хөгжлийн түүхэнд нийгмийн чухал зорилтуудын нэг байсаар ирсэн. Эрүүл мэнд гэдэг нь хүн ажил хөдөлмөр эрхлэх, сэтгэл санаа амар амгалан, сайн сайхан байх чухал хэрэгцээ юм. Хүний эрүүл мэндийн асуудлын 75 хувь нь гадаад орчин, амьдралын хэв маяг, эсвэл бидний ухамсар, мэдлэгээс шалтгаалдаг байна. Тиймээс эрүүл мэндийн боловсрол зайлшгүй шаардлагатай. Өнгөрсөн 2023 онд гэхэд хавдрын 7244 шинэ тохиолдол бүртгэгдэж, 4556 хүн хавдрын оношоор нас барж, Монгол Улс дэлхийд хорт хавдрын нас баралт,

элэгний хорт хавдрын өвчлөлөөр тэргүүлж байна. Монгол улсын хэмжээнд 2023 оны жилийн эцсийн байдлаар бэлгийн замаар дамжих халдварт өвчний 10245 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 25 хувийг эзэлж байна. Монгол эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалт 9.4 жилийн зөрүүтэй байна. Тодруулбал 2022 оны байдлаар эрэгтэйчүүд дунджаар 67.3 нас, эмэгтэйчүүд дунджаар 76.7 насалж байна. Монгол эрчүүд эрүүл мэнддээ төдийлөн анхаардаггүй, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагддаггүй, үүнээс гадна хөдөлгөөний дутагдал, буруу хооллолт зэрэг олон шалтгаан бий. Архи, согтууруулах ундааны зохисгүй хэрэглээ эрэгтэйчүүд, орон нутгийн иргэдийн дунд илүү байна. Насанд хүрэгчдийн 21.0% нь таргалалттай, 35.7% нь жингийн илүүдэлтэй байна. Эдгээр тоо баримт нь иргэд эрүүл мэндийн мэдлэг боловсрол дутмаг байгааг харуулж байна.

Ийм учраас бид “Эрүүл мэндийн сэтгүүл зүй” хөтөлбөрөөрөө сэтгүүлч мэргэжлээр суралцаж буй оюутнуудад эрүүл мэндийн өргөн мэдлэг олгож, иргэдийн эрүүл мэндийг хамгаалах мэдээллийг олон нийтэд хариуцлагатай, үр дүнтэй, ёс зүйтэй бэлтгэх, хүргэх арга зүйд сургаж, бүх нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, тэднийг нотолгоонд суурилсан шийдвэр гаргахад нь хувь нэмэр оруулах сэтгүүлчдийг бэлтгэхэд чиглэж байгаа юм. Өөрөөр хэлбэл, эрүүл мэндийн сэтгүүл зүй нь дүн шинжилгээ хийх замаар олон нийтийн санаа бодол эсвэл бодлогын түвшинд эрх баригчдын шийдвэрт нөлөөлөхийг эрмэлздэг учир нийгэмд эерэг өөрчлөлт авчирна гэж харж байна.

### **Эрүүл мэндийн сэтгүүл зүйн чиглэлээр та бүхэн Япон улсаас туршлага судлаад ирсэн. Энэ чиглэлд Япон улсын туршлагаас хуваалцахгүй юу?**

Бид энэ намар Япон улсад энэ чиглэлээр туршлага судлаад ирсэн. Япон улс бол иргэнийнхээ эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр хамгийн сайн тогтолцоог бүрдүүлсэн улс учир сурах, мэдэх зүйл их байлаа. Сэтгүүл зүй, олон нийтийн мэдээлэл харилцааны их сургуулиуд нь эрүүл мэндийн сэтгүүл зүйн хөтөлбөртэй,



зарим сургууль нь мэргэшсэн хөтөлбөртэй байна. Бид Япон улсын цэцэрлэгээс эхлээд дунд сургууль, их сургууль гээд бүгдийг үзлээ. Иргэдээ эрүүл байлгахын тулд цэцэрлэгээс нь анхаарч, дунд сургуульд суурь бүрэн ойлголтыг өгч эрүүл хооллолт, идэвхтэй хөдөлгөөн, урьдчилан сэргийлэх үзлэг, стрессийн удирдлага, чанартай эрүүл мэндийн үйлчилгээ зэрэг цогц бодлогоор анхаарал хандуулдаг. Энэ нь тэдний урт наслах, эрүүл амьдрах гол үндэс болдог байна.

Эрүүл мэндийн сэтгүүл зүйгээр Япон улсаас судалж болох олон сайн туршлага бий. Японы хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн эрүүл мэндийн мэдээллийг түгээх арга барил нь шинжлэх ухаанд суурилсан, хариуцлагатай, иргэдэд ойлгомжтой байдгаараа онцлог юм.

Японы сэтгүүлчид эрүүл мэндийн талаар мэдээлэхдээ зөвхөн албан ёсны, баталгаатай эх сурвалжийг ашигладаг. Тэд эмнэлзүйн судалгаа, эрүүл мэндийн байгууллагын гаргасан тайлан, мэргэжилтнүүдийн дүгнэлтийг иш татдаг. Хэт шуугиан тарих эсвэл баталгаагүй мэдээллийг цацахыг хориглодог сэтгүүлчийн ёс зүйн өндөр стандарттай.

Эрүүл мэндийн мэдээ, нийтлэлүүдийн дийлэнх нь урьдчилан сэргийлэхэд чиглэдэг. Жишээлбэл, амьдралын хэв маягийг сайжруулах зөвлөгөө, өвчнөөс хэрхэн сэргийлэх талаар дэлгэрэнгүй зөвлөмжүүдийг тогтмол хүргэдэг. Япончууд эрүүл мэндийн сэдэвт нэвтрүүлэг, нийтлэлдээ иргэдийн оролцоог хангахыг чухалчилдаг. Иргэдийн санал асуулга, амьдралын бодит жишээг мэдээлэлд оруулдаг юм байна. Эрүүл мэндийн сэтгүүл зүй нь иргэдэд зөвхөн мэдээлэл хүргэхээс гадна тэднийг сургамжилж, эрүүл амьдралын хэв маягийг дадал болгоход чиглэгддэг.

Жишээ нь, хооллолтын зохистой дадал, хөдөлгөөний ач холбогдол, стрессийн менежмент гэх мэт сэдвээр цуврал нэвтрүүлэг, нийтлэл нийтэлдэг. Монгол Улс эдгээр туршлагыг нутагшуулж чадвал иргэдийн эрүүл мэндийн боловсролд томоохон дэвшил гарах боломжтой юм.

# НЭГ: ЗУНЫ ЗУГААТАЙ АЯЛАЛ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж байгаа “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран “Зуны зугаатай аялал” нөлөөллийн арга хэмжээг зам тээврийн осол, хэргийн улмаас иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө хохирохоос хамгаалах, урьдчилан замын сэргийлэх, хөдөлгөөнд оролцогчдын буруу дадал, хандлагыг өөрчлөх, зөв үйлдэлд уриалах, олон улс, улсын чанартай болон сум суурин, аялал жуулчлалын бүс нутгийг холбосон авто замд хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, ослыг бууруулах, иргэдийн аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх, хөдөлгөөний аюулгүй хангуулах зорилгоор явуулж байгаа “Шугаман эргүүл-Хар хэсэг” арга хэмжээтэй уялдуулан энэ оны 07 дугаар сарын 05-ны өдрөөс 08 дугаар сарын 28-ны өдрийг хүртэлх хугацаанд улсын хэмжээнд зохион байгуулагдав.

## АЯНЫ ХҮРЭЭНД:

1. Зуны амралтаараа аюулгүй зорчиж аялах агуулга бүхий аудио шторк 2 ширхэг хийгдсэн



- 2.

“Зуны зугаатай аялал” нөлөөллийн арга хэмжээний хүрээнд **“Зуны зугаатай аялал”**

**AR** технологид суурилсан **аудио КОМИК НОМ**  
**30.000** ширхэг хэвлэгдэн гарав.


Тус номыг хэвлэмэл байдлаар уншихаас гадна AR технологи ашиглан гар утасныхаа тусламжтайгаар сонсож дүр, үйл явдлыг нь харах боломжтой юм.



# ЗУНЫ ЗУГААТАЙ АЯЛАЛ НӨЛӨӨЛЛИЙН АЯН СЭДЭВ:

Эрүүл хоол хүнс хэрэглэж хордлогоос сэргийлье

3. Аяны гол дүр болох **МОНГОЛООГИЙН ГЭР БҮЛ** аюулгүй байдлаа хангаж аялцгаахыг уриалсан агуулга бүхий **2D анимейшин** видео контент хийгдсэн



Үер, усны аюулаас сэргийлье



Аюулгүй зорчиж гэр бүл, хайртай хүмүүсийнхээ эрүүл мэнд, амь насыг хамгаалаарай

4. АВТОМАШИНЫ АРД НААХ (посфор бүхий) **3500** стикер наалт ширхгийг хэвлүүлж түгээв



Байгаль эх дэлхийгээ хайрлаж зөв аялаж амрацгаая



## ЗУНЫ ЗУГААТАЙ АЯЛАЛ АЯНЫ ТҮГЭЭЛТ:

- ✓ Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж байгууллагуудын 97 лед дэлгэцээр зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах сэрэмжлүүлэг контентыг түгээв
- ✓ Нийслэл хотоос гарах, орох чиглэлийн зам дагуух 10 байршилд анонс бүхий хулдаасан самбар, автобусны зогсоолын дагуух 80 мэдээллийн самбарт аяны 4 төрлийн зөвлөмж сурталчилгааны зурагт хуудсыг 1 сарын хугацаанд байршуулав
- ✓ “Зуны зугаатай аялал” нөлөөллийн аяны хүрээнд бүтээгдсэн богино хэмжээний видео бичлэгийг нийслэлд үйл ажиллагаа явуулдаг 20,000 мянган хэрэглэгчтэй САНСАР КАБЕЛИЙН телевизийн promo сувагт байршуулан иргэд олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулав.
- ✓ Зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэд, олон нийтэд хүргэх уриалгыг олны танил 291 эрхмээр хэлүүлж, өөрсдийнх нь цахим болон албаны хуудсанд нь байршууллаа.
- ✓ Дээрх уриалга нөлөөллийн ажлыг давхардсан тоогоор 196.677 хүн хариу үйлдэл үзүүлж, 15.398 хүн бусадтай хуваалцаж, 9.327 хүн сэтгэгдэл үлдээж, 21.189.566 хүнд, 11 сайтын 2.864.300 хүнд, хамтран ажилласан 11 байгууллагын 2.885.000 хүнд тус тус хүрсэн үзүүлэлттэй байна
- ✓ Улсын хэмжээнд бүртгэгдсэн зам тээврийн осол, хэргийн товч мэдээлэл, шалтгаан, нөхцөл, хор уршгийг таниулах, иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор мэдээ, сэрэмжлүүлэг зэргийг бэлтгэн давхацсан тоогоор өргөн нэвтрүүлгийн 13 телевизэд 3 төрлийн мэдээлэл, 27 сайтад 3 төрлийн мэдээлэл, сонинд 1 төрлийн мэдээллийг тус тус хамтран бэлтгэж ажилласан
- ✓ “Зуны зугаатай аялал”-ын бичлэгийг 15 автобусны 75 дэлгэц дээр байршуулж, орон нутгийн авто тээврийн төвүүд, томоохон зах худалдааны төвүүд дээр аудио 2 шторкийг өгч чанга яригчаар иргэд, олон нийтэд хүргэсэн
- ✓ Орон нутагт хамгаалах бүсийг зөв хэрэглэх талаар 9 төрлийн 9615 ширхэг зурагт хуудас бүхий санамж, сэрэмжлүүлэг тарааж, QR код бүхий сэрэмжлүүлгийг 1600 ширхгийг түгээж, 900 ширхэг уншуулж ажилласан. Арга хэмжээг томоохон худалдаа, үйлчилгээний төвүүдийн 78 лед дэлгэц болон анхааруулах 80 ширхэг анонс бүхий хулдаасан самбарыг байршуулсан байна
- ✓ Өргөн нэвтрүүлгийн “Юнивишн”, “Скаймедиа”, “ДДЭШ” телевизийн нийт хэрэглэгч айл, өрх болон “Төрийн банк”, “Хаан банк”-ны АТМ, Киоск машин, интернэт банкны аппликейшн, Төрийн үйлчилгээний ТҮЦ машин, Ebarimt аппликейшнд сурталчилгааны баннерыг байршуулж, “Мобиком”, “Юнител”, “Скайтел”, “Жи Мобайл”-ын үүрэн холбооны давхардсан тоогоор 2.124.112 хэрэглэгчид зорилтот мессежийг хүргүүлсэн

## НӨЛӨӨЛЛИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮН:

Энэ оны эхний

**7 сарын байдлаар**

олон улс, улсын болон орон нутгийн чанартай авто замд осол, хэргийн улмаас

**256** хүний амь хохирч

**663**

хүн гэмтсэнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал ХҮНИЙ АМЬ ХОХИРСОН ТОХИОЛДОЛ

**25** БУЮУ **11.5%** -иар нэгжээр

ГЭМТСЭН ХҮН

**60** БУЮУ **9.9%** -иар нэгжээр

өссөн үзүүлэлттэй байна.

Харин “Шугаман эргүүл Хар хэсэг”, “Зуны зугаатай аялал” нөлөөллийн ажлыг эхлүүлснээс хойших **97** хоногийн хугацаанд олон улс, улсын болон орон нутгийн чанартай авто замд хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг **325** гэмт хэрэг бүртгэгдэж, **137** хүний амь хохирч, **353** хүн гэмтсэнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад гэмт хэрэг **42** нэгжээр буюу **11,4** хувиар, хүний амь хохирсон тохиолдол **17** нэгжээр буюу **11,0** хувиар, хүн

гэмтсэн тохиолдол **63** нэгжээр буюу **15,1** хувиар тус тус буурсан. Арга хэмжээний хүрээнд **856,936** тээврийн хэрэгсэлд хийсэн хяналт шалгалтаар **599,855** жолооч, **685,548** урд суудлын зорчигч, **3,084,970** арын суудлын зорчигч хамгаалах бүс зүүж хэрэглээгүй гэсэн суурь судалгаа гаргаж, нас баралтын шалтгаанд бүс хэрэглээгүй нь нөлөөлж байгаа тул хэрэглээг нэмж нас баралтыг бууруулах зорилт тавьж байна.

**ХОЁР:**

# АМСАХГҮЙ БОЛ ХАРАМСАХГҮЙ НӨЛӨӨЛЛИЙН АЯН ОРОН ДАЯАР ХЭРЭГЖИЖ ЭХЭЛЛЭЭ



ДЭМБ-аас нэг хүнд ногдох согтууруулах ундааны жилийн хэрэглээг 7 литр гэж заасан байдаг. Манай улсад энэ үзүүлэлт даруй 7 дахин их байна. Үүнээс үүдэн жилд 4500 хүн архины шууд болон шууд бус хамаарлаас нас бардаг. Тиймээс согтууруулах ундааны хортой хэрэглээнээс үүдсэн эрүүл мэнд, эдийн засгийн хор хөнөөлийг бууруулах зорилгоор “Амсахгүй бол Харамсахгүй” аян орон даяар хэрэгжиж эхэллээ. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Эрүүл монгол хүн” хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих уг аян иргэд, олон нийт, залууст зориулан эрүүл зан үйл төлөвшүүлэх, эерэг хандлага бий болгохоор зорьж буй. Компани ажлын хүрээнд “Архинд донтох нь өвчин” гэдгийг ойлгуулах мэргэжлийн эмч нарын ярилцлагууд, инфографик мэдээллүүд, залуусыг зөв дадалд уриалсан эерэг нөлөөллийн контентуудыг бэлтгэн түгээв.



ДАРААХ ЭНГИЙН 4 АСУУЛТАД ХАРИУЛААД ӨӨРИЙГӨӨ  
АРХИНЫ ХАМААРАЛД ӨРТСӨН ЭСЭХЭЭ ШАЛГААРАЙ.

**ӨӨРИЙГӨӨ  
ШАЛГАХ  
АСУУЛТУУД**

АМСАХ ТУСАМ ӨВЧИН БОЛНО  
АМСАХ ТУСАМ ӨВЧИН БОЛНО  
АМСАХ ТУСАМ ӨВЧИН БОЛНО

ОЙР ДОТНООС ХҮМҮҮС ЧИНЬ  
“ЧИ АРХИ ИХ УУЛАА” ГЭЖ  
УУРЛАЖ БАЙНА УУ?

ТИЙМ  ҮГҮЙ

ӨӨРӨӨ “МИНИЙ АРХИНЫ  
ХЭРЭГЛЭЭ АРАЙ Л ИХДЭЭД БАЙНА  
ШҮҮ” ГЭЖ БОДОЖ БАЙСАН УУ?

ТИЙМ  ҮГҮЙ

АРХИ УУСНЫ МАРГААШ АРХИ  
СОГТУУРУУЛАХ УНДААГААР  
ШАРАА ТАЙЛДАГ УУ?

ТИЙМ  ҮГҮЙ

АЖИЛ, ГЭР БҮЛИЙН АСУУДАЛ ГЭХ  
МЭТ АМЬДРАЛЫН ЧУХАЛ  
ТӨЛӨВЛӨСӨН АЖЛУУДАА АРХИ  
ХЭРЭГЛЭСНЭЭС БОЛЖ ГАНЦ ХОЁР  
УДАА ХОЙШ ТАВЬЖ БАЙСАН УУ?

ТИЙМ  ҮГҮЙ

ХЭРЭВ ТА 3-4 АСУУЛТАД  
**ТИЙМ**  
ГЭЖ ХАРИУЛСАН БОЛ

↓  
МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГАД  
ХАНДАХ ХЭРЭГТЭЙ БОЛЖЭЭ.

АМСАХ ТУСАМ ӨВЧИН БОЛНО  
АМСАХ ТУСАМ ӨВЧИН БОЛНО  
АМСАХ ТУСАМ ӨВЧИН БОЛНО

**ХОР  
ХООЛ  
ХҮНС** **БИШ**

Х И М И Й Н  
Б О Д И С

АМСАХ ТУСАМ ӨВЧИН БОЛНО

АМСАХ ТУСАМ ӨВЧИН БОЛНО  
АМСАХ ТУСАМ ӨВЧИН БОЛНО

ЭРЧҮҮДИЙН  
**70% нь** найз нөхдийн  
нөлөөллөөс болж  
АРХИНД ДОНТДОГ

АМСАХ ТУСАМ ӨВЧИН БОЛНО  
АМСАХ ТУСАМ ӨВЧИН БОЛНО  
АМСАХ ТУСАМ ӨВЧИН БОЛНО

НЭГ ЖИЛД, НЭГ ХҮНД НОГДОХ  
СОГТУУРУУЛАХ УНДАА

9 л 54 л

АЮУЛ УМЬРСАН  
ГЭЖ ҮЭДЭГ

МОНГОЛД

АМСАХ ТУСАМ ӨВЧИН БОЛНО  
АМСАХ ТУСАМ ӨВЧИН БОЛНО  
АМСАХ ТУСАМ ӨВЧИН БОЛНО

**1**  
АМСВАЛ  
**1000!**  
БАГАДНА

АМСАХ ТУСАМ ӨВЧИН БОЛНО  
АМСАХ ТУСАМ ӨВЧИН БОЛНО  
АМСАХ ТУСАМ ӨВЧИН БОЛНО

**ГУРАВ:**

# ХЭТРҮҮЛЭЭД ХЭРЭГГҮЙ

**НӨЛӨӨЛЛИЙН АЯН**

# АМИНААС ҮНЭТЭЙ  
ХЭРЭГЛЭЭ ГЭЖ ҮГҮЙ

Эрүүл мэндийн сайдын 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/409 дугаар тоот “төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” тушаалын хавсралт Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 6 дугаар бүлэг “Соён гэгээрэл, нөлөөллийн арга хэмжээ”-ийн 6.10 дахь заалтад “Шинэ жилийн баярыг угтсан нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах” гэж заасны дагуу хүн амыг мэдээ, мэдээллээр хангах, түгээх, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хүрээнд “Хэтрүүлээд хэрэггүй” нөлөөллийн арга хэмжээг зохион байгууллаа.

“Хэтрүүлээд хэрэггүй” нөлөөллийн арга хэмжээний зорилго: Ард иргэд, аж ахуй нэгжийг шинэ жилийн баярыг тэмдэглэхтэй холбогдуулан гарч болзошгүй гэнэтийн осол, гэмтэл, осголт, эрүүл мэндийн асуудлаас урьдчилан сэргийлэх юм.

**ХЭТРҮҮЛЭЭД ХЭРЭГГҮЙ**

**АРХИ УУСНААРАА БАХАРХДАГ ЦАГ ӨНГӨРСӨН**

**ОРЧИН ҮЕД**  
УУДАГҮЙГЭЭРЭЭ БАХАРХАЖ

УУХҮГҮЙГЭЭР ХӨГЖИЛДӨЖ

ЦАГ ХУГАЦАА, САНХҮҮГЭЭ АЯЛАЛД ЗОРИУЛДАГ

**ШИНЭ СОЁЛ ДЭЛГЭРСЭН**

**ХЭТРҮҮЛЭЭД ХЭРЭГГҮЙ**

**БУСДЫГ АРХИАР ШАХАЖ ЭРСДЭЛД БҮҮ ОРУУЛААРЙ УУХ, УУХГҮЙ БАЙХ СОНГОЛТЫГ ӨӨРТ НЬ ҮРГЭЛЖ ҮЛДЭЭ.**

# АМИНААС ҮНЭТЭЙ ХЭРЭГЛЭЭ ГЭЖ ҮГҮЙ

**ХЭТРҮҮЛЭЭД ХЭРЭГГҮЙ**

**ДЭЛХИЙД АРХИНААС ҮҮДЭЛТЭЙ НАС БАРАЛТААР**

МОНГОЛ УЛСЫН ЭРЧҮҮД **ХОЁРДУГААРТ** ЭМЭГТЭЙЧҮҮД **ГУРАВДУГААРТ** ЖАГСАЖ БАЙНА.

# АМИНААС ҮНЭТЭЙ ХЭРЭГЛЭЭ ГЭЖ ҮГҮЙ

**ХЭТРҮҮЛЭЭД ХЭРЭГГҮЙ**

**ГАЦУУР МОДНЫ ГЭРЛЭН ЧИМЭГЛЭЛ НЬ 45 СЕКУНДЭД ШАТДАГ.**

ХОРМЫН ДОТОР ҮҮССЭН ГАЛ ХЭМЖЭЭГҮЙ ЗАЙНД ТАРХАНА.

# ГЭРЛЭН ЧИМЭГЛЭЛИЙГ УНТРААЖ ХЭВШЬЕ

**ХЭТРҮҮЛЭЭД ХЭРЭГГҮЙ**

**ГУДАМЖИНД СОГТУУ ХҮН ХЭВТЭЖ БАЙВАЛ ТА ДУУДЛАГА ӨГЧ БАЙГААРАЙ.**

**ТАНЫ ОРХИОД ЯВСАН ХҮН ӨӨРИЙГӨӨ УНТАЖ БАЙНА ГЭЖ БӨДСООР ОСГОЖ НАС БАРАХ ЭРСДЭЛТЭЙ.**

# ТАНЫ ДУУДЛАГА НЭГ АЙЛЫН АМЬДРАЛЫГ АВАРНА.

**ХЭТРҮҮЛЭЭД ХЭРЭГГҮЙ**

**ТАНЫ СОНГОЛТЫГ ХҮНДЭТГЭДЭГ ХҮМҮҮСЭЭР ӨӨРИЙГӨӨ ХҮРЭЭЛҮҮЛ **БИ УУХГҮЙ****

**ХЭТРҮҮЛЭЭД ХЭРЭГГҮЙ**

**ГАЛ ГҮЙМРИЙН 40 ХУВЬ НЬ ТОГ ЦАХИЛГААНААС ҮҮДЭЛТЭЙ**

ЗАЛГУУРЫН ХҮЧИН ЧАДЛЫН ХЯЗГААРЫГ ХЭТРҮҮЛЭН ЗАЛГАХГҮЙ, ТОГНЫ УТАСНЫ БҮРЭН БҮТЭН БАЙДЛЫГ ТОГТМОЛ ШАЛГАЖ ХЭВШЬЕ!

**ХЭТРҮҮЛЭЭД ХЭРЭГГҮЙ**

**СОГТУУРУУЛАХ УНДАА ХЭРЭГЛЭСЭН ТОХИОЛДОЛД **ДУУДЛАГЫН ЖОЛООЧ ДУУДАЖ ХЭВШЬЕ!****

ИНГЭСНЭЭР ТА ГЭР ЛҮҮГЭЭ **АЮУЛГҮЙГЭЭР ХАРИХ БОЛОМЖТОЙ.**

# УУСАН БОЛ БҮГ ЖОЛООД

# БАГУУД ХАМТРАН АЖИЛЛАЖ ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ 2025 ОНД УИХ-аар ХЭЛЭЛЦҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БАЙНА



Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг 2022 онд Эрүүл мэндийн яаманд байгуулагдаж хуульд оруулах нэмэлт болон дагалдах хуульд оруулах өөрчлөлтийг хийж ажилласан. ЕТГ-ын “Эрүүл Монгол хүн” төсөл, хөтөлбөр хариуцсан алба болон зөвлөхүүд холбогдох талуудтай хамтран Тамхины хяналтын тухай хуулийг шинэчлэх санал, тамхи болон тамхин бүтээгдэхүүнд ноогдох онцгой албан татварын тооцооллыг хийн цуврал хэлэлцүүлэг зохион байгуулсан. 2024 оноос УИХ-с Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, электрон тамхи, түүнтэй холбоотой асуудлаар холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг судлан, санал дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулсан байна. Иймээс тус хуулийн шинэчлэлийн чиглэлээр ажиллаж буй багууд хамтран ажиллаж 2025 онд УИХ-аар хэлэлцүүлэхээр төлөвлөж байна.



## Е-ТАМХИНЫ ХОРИГ



Дэлхийн **47 орон** е - тамхийг хориглоод байна

Дэлхийн **184** улсад электрон тамхинд онцгой албан татвар ногдуулж байна. Харин манай улсад өнөөдрийн байдлаар **онцгой албан татвар ч ногдуулдаггүй** байна.



1.3 ТЭРБУМ  
хүн тамхи татдаг

ТЭДГЭЭРИЙН  
**80%**

бага, дунд орлоготой улс, орнуудад хамаарч байна.

Тамхины **шууд ба шууд бус нөлөөний улмаас жил бүр 8 сая хүн амь насаа алддаг.**

Тамхи татдаг хүн, татдаггүй хүнтэй **ХАРЬЦУУЛАХАД 10-12 жил** богино насладаг



Тамхины эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөний улмаас эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн **3-5,3 хувийг тамхины шалтгаант эмгэгийн тусламжид зарцуулдаг** байна.

ЖИЛ БҮР ТАМХИНЫ НӨЛӨӨНӨӨС **4300** орчим хүн амь насаа алддаг

Тэдний **12%** дам тамхидалтаас үүдэж байна.

Тамхидалтын улмаас **801 тэрбум** төгрөгийн эдийн засгийн хохирол учирч байгаа нь ДНБ-ийн **2.1 хувьтай тэнцэж** байгаа бөгөөд (2020), энэ нь тамхинаас үүдэлтэй өвчин, эмгэгийг эмчлэхэд шууд зардал – **87 тэрбум**, тамхинаас үүдэлтэй нас баралт - **496 тэрбум**, хөдөлмөрийн чадвар алдалт - ажил таслах, ажлын бүтээмж буурсан – **219 тэрбум** төгрөгийн эдийн засгийн хохирол учирч байна. (ДЭМБ тооцоолол) Эдийн засгийн нийт алдагдлын **27 хувийг** тамхинаас үүдэлтэй алдагдал эзэлж байна.

ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН

**45%**




ТАМХИ  
ТАТДАГ

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН

**5%**

## НАСАНД ХҮРСЭН НИЙТ ИРГЭДИЙН



ХҮН АМЫН **15%-50%** дан тамхидалтад өртдөг байна

## ОЮУТНУУДЫН



## МОНГОЛ УЛС 2022 онд

**3.5 ТЭРБУМ** ширхэг янжуур тамхи

**90.3 ТОНН** электрон тамхийг импортлосон


электрон тамхийг импортлосон

**2023 оны эхний 8 сарын байдлаар 2.2 ТЭРБУМ** ширхэг янжуур тамхи

**71.8 ТОНН** электрон тамхийг импортлосон

электрон тамхийг импортлосон

## Манай улсад тамхины хэрэглээ жил бүр нэмэгдсээр



## ТАМХИНЫ ЭРҮҮЛ МЭНД, ЭДИЙН ЗАСГИЙН ХОР ХӨНӨӨЛ: ТАМХИДАЛТЫГ БУУРУУЛАХ MPOWER БОДЛОГО

M	P	O	W	E	R
<b>Monitoring</b> tobacco use	<b>Protecting</b> the public with smoke-free laws	<b>Offering</b> help to quit smoking	<b>Warning</b> about the dangers of tobacco through pack labels and public awareness	<b>Enforcing</b> advertising bans	<b>Raising</b> taxes on tobacco.

- Тамхины тахлын эсрэг тэмцэхийн тулд дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ) ын гишүүн орнууд **2003** онд Тамхины хяналтын тухай суурь конвенцыг баталсан. Одоогоор **182** орон энэхүү гэрээнд нэгдээд байна.
- Монгол Улсын хувьд **2003** онд тамхины хяналтын суурь конвенцид нэгдэж, **2005** онд Тамхины хяналтын тухай хууль баталж, **2012** онд шинэчлэн найруулсан байдаг.
- ДЭМБ-ын MPOWER арга хэмжээ нь Тамхины хяналтын суурь конвенцод нийцэж байгаа бөгөөд энэ бодлогын чухал бүрэлдэхүүн нь **тамхи, тамхин бүтээгдэхүүнд ногдуулах** Онцгой албан татварыг нэмэгдүүлэх явдал юм.
- Монгол улсад тамхины үнэ маш хямд, тухайлбал Австрали улстай харьцуулахад **24 дахин бага** байна. Тамхины үнэ **3400 төгрөг**, үүнд ногдуулах онцгой албан татвар нь **24.5%** байгаа нь (ДЭМБ-ын санал болгож буй хувь - **70%**)

**2.8 дахин бага** байна. Иймээс тамхи, тамхин бүтээгдэхүүнд ногдуулах онцгой албан татварыг үе шаттай нэмэгдүүлж ДЭМБ ын санал болгож буй хувьд ойртуулах нь тамхидалттай тэмцэх бодлого болох юм.

Урьдчилсан судалгаагаар электрон тамхи нь амны хөндийн халдварын эрсдэлийг нэмэгдүүлж, зүрхний титэм судасны өвчин, зүрхний шигдээс, цус харвалт үүсгэхээс гадна залуу хүмүүс болон никотин их хэмжээгээр амьсгалдаг хүмүүст таталт өгөх эрсдэлийг нэмэгдүүлдэг байна.

2019 онд тамхи татахтай холбоотой уушгины өвчлөл улс орнуудад эрс нэмэгдсэн нь электрон тамхи болон холбогдох төхөөрөмжүүдийн аюулгүй байдлын асуудал нь олон улсад санаа зовоосон асуултыг бий болгов. Электрон тамхины хэрэглээ нь хорт металлаар амьсгалснаас үүдэлтэй уушгины ховор өвчин болох хатуу металлын пневмокониозтой холбоотой болохыг 2019 онд нийтэлсэн судалгаа харуулжээ.



# ТАМХИДАЛТЫН

ЭРҮҮЛ МЭНД, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ



## Монгол Улсын хүн амын дунд тамхидалт хэр байна вэ?

Дэлхийн хүн амын 17 орчим хувь буюу 1.3 тэрбум хүн тамхи татдагийн 80 орчим хувь нь бага, дунд орлоготой орнуудад байгаа бөгөөд тамхи татагчдын дийлэнх хувийг эрэгтэйчүүд эзэлж байна. Монгол улсын хувьд эрэгтэйчүүдийн 45 хувь, эмэгтэйчүүдийн 5 орчим хувь нь тамхи татдаг (2019, НЭМҮТ) байсан бол сүүлийн үеийн судалгаагаар тамхи татах нас залуужиж мөн охид, эмэгтэйчүүдийн тамхидалт 2 дахин нэмэгдээд байна. Ялангуяа электрон тамхины хэрэглээ эрс нэмэгдэж 2023 онд оюутан залуусыг хамруулсан судалгаагаар тэдний 14 хувь нь утаат, 10.9 хувь нь электрон тамхи татдаг байна.

Электрон тамхийг анх 2003 онд БНХАУ-ын эм зүйч зохион бүтээсэн бөгөөд энэ нь никотин, никель, цагаан тугалга, хар тугалга зэрэг хүнд

металлууд, хорт хавдар үүсгэдэг олон төрлийн химийн бодисууд агуулдаг эрүүл мэндэд утаат тамхины адил хортой нөлөө үзүүлдэг.

Дэлхийн 50 орчим орон электрон тамхи худалдаалахыг бүр хориглосон бөгөөд Шинэ Зеланд улсын хувьд 2009 оны 1 сараас хойш төрсөн хүүхдэд, АНУ-ын Калифорни муж 2007 оны 1 сараас хойш төрсөн хүүхдэд, АНУ-ын Массачуссет муж 2000 оны 1 сарын 1с хойш төрсөн хүүхдэд, Австрали улс 2000 оноос хойш төрсөн хүүхдэд тамхи худалдаалахгүй байх шийдвэр гарсан байна.

Монгол улсын хувьд “Тамхины хяналтын тухай” хуульд электрон тамхины зохицуулалт тусгагдаагүй учраас нэн яаралтай өөрчлөлт хийх, уг хуулийг шинэчлэх чиглэлээр холбогдох талууд ажиллаж байна.





# ТАМХИНЫ сөрөг нөлөө

Тамхи нь хэрэглэгчдийнхээ тэн хагасынх нь амь насыг хөнөөж жил бүр 8 сая хүн нас бардаг. Тамхи татдаг хүн татдаггүйтэй харьцуулахад 10-12 жил богино насалдаг, хүн амын 15%-50% дан тамхидалтад өртдөг. Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн 3-5.3 хувийг тамхины шалтгаант эмгэгийн тусламжид зарцуулдаг

Монгол улсад жил бүр тамхины нөлөөнөөс 4300 орчим амь насаа алдаж, үүний 12 хувь нь дам тамхидалтаас үүдэж байна. ДЭМБ-ын 2020 оны судалгаагаар Монгол улсад тамхидалтын улмаас 801 тэрбум төгрөгийн эдийн засгийн хохирол учруулж байгаа нь ДНБ 2.1 хувьтай тэнцэж байна. Энэ нь тамхинаас үүдэлтэй өвчний эмчлэхэд шууд зардал 87 тэрбум, тамхинаас үүдэлтэй нас баралт 496 тэрбум, хөдөлмөрийн чадвар алдалт ажил таслах, ажлын бүтээмж буурснаас 219 тэрбум, эдийн засгийн нийт алдагдлын 27 хувийг тамхинаас үүдэлтэй алдагдал эзэлж байгааг тооцоолол байдаг.

## Тамхидалтыг бууруулах бодлого:

- Тамхины тахлын эсрэг тэмцэхийн тулд ДЭМБ-ын гишүүн орнууд 2003 онд Тамхины хяналтын тухай ДЭМБ-ын суурь конвенцыг (ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенц) баталсан. Одоогоор 182 орон энэхүү гэрээнд нэгдэж байна.
- ДЭМБ-ын MPOWER арга хэмжээ нь Тамхины хяналтын суурь конвенц нийцэж байгаа бөгөөд хүний амь насыг аварч, эрүүл мэндийн зардлаас урьдчилан сэргийлэх зардлыг бууруулдаг. Энэ бодлогын чухал бүрэлдэхүүн нь тамхи, тамхин бүтээгдэхүүнд ногдуулах Онцгой албан татварыг нэмэгдүүлэх юм.
- Монгол Улсын хувьд 2003 онд тамхины хяналтын суурь конвенцод нэгдэж, 2005 онд Тамхины хяналтын тухай хууль баталж, 2012 онд шинэчлэн найруулсан байна.
- Монгол улсад тамхины үнэ маш хямд, тухайлбал Австрали улстай харьцуулахад 24 дахин бага байна. Тамхины үнэ 3400, үүнд ногдуулах онцгой албан татвар нь 24.5% байгаа нь (ДЭМБ 70%) 2.8 дахин бага байна. Иймээс тамхи, тамхин бүтээгдэхүүнд ногдуулах онцгой албан татварыг үе шаттай нэмэгдүүлж ДЭМБ санал болгож буй хувьд ойртуулах, тамхигүй орчныг нэмэгдүүлэх зэргээр хуулийг бүхэлд нь шинэчлэх нь нэн чухал юм.

**ДӨРӨВ:**

# ИРЭЭДҮЙГЭЭ БҮҮ НӨЛӨӨЛЛИЙН АЯН **СОП**

"Анх 2005 онд тамхины хяналтын тухай хууль батлагдсанаас хойш таван удаа шинэчилсэн найруулга, хоёр удаа өөрчлөлт, нэг удаа нэмэлт өөрчлөлт орсон.

Монголд хоёр эрэгтэй хүн тутмын нэг нь тамхи татаж байна. Нийт хүн амын 1/4 нь тамхи татдаг судалгаа бий. Тэр дундаа электрон тамхины хэрэглээ өссөнтэй холбоотой өсвөр насныхан, эмэгтэйчүүд эрс нэмэгдэж байна.

Электрон тамхинд онцгой албан татварын заалт хомс байна. Тиймээс хуульд нэмэлт өөрчлөлт оруулж байж тамхины хэрэглээг багасгана. Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар УИХ-д Ажлын хэсэг гарсан. Гэвч энэ хуульд гар хүрэхгүй байх сонирхол зарим хүнд бий. Тиймээс хуулийг батлуулах явц удааширч байна" гэж ярилаа.

НЭМҮТ-ийн захирал С.Өнөрсайхан "Тамхины ургамал бол өөрөөсөө шавжийг зайлуулах зорилгоор никотин гэдэг бодис ялгаруулдаг. Никотин нь хавдар үүсгэдэг бодис гэдгийг 1920 онд баталсан.

Манайд хавдар төст эмгэгийн судалгаа хийдэг байгууллага. Хорт хавдар, зүрхний өвчлөл, амьсгалын

замын өвчин, чихрийн шижингийн гол шалтгаан нь архи, тамхины хэрэглээ, буруу хооллолт болон хөдөлгөөний дутагдал зэрэг байдаг.

Гэтэл тамхины хэрэглээ огт буурахгүй байна. Тухайлбал 15-69 насны хүн амын дунд хийсэн судалгаагаар 24.2 хувь буюу таван хүний нэг нь тамхи татдаг. Үүнээс эрчүүд нь хоёр хүний нэг нь тамхи хэрэглэдэг. Эрчүүдийн дунд тамхины хэрэглээ эсрэг хүйсийнхэнтэй харьцуулахад 8.7 дахин их байна. Тамхинд орж байгаа иргэдийн нас улам залуужиж байгаа нь судалгаагаар харагддаг. 13-17 насны сурагчдын дунд хийсэн судалгаагаар 19 хүүхэд тутмын нэг нь тамхи татдаг. Мөн 10 хүн тутмын гурав нь дам тамхидалтад өртдөг. Эмэгтэйчүүд нь гэртээ, эрчүүд нь ажлын байран дээрээ өртөж байна. Ерөнхий Боловсролын Сургууль (ЕБС) дээр эрүүл мэндийн зан үйлийн судалгааг өнгөрсөн онд хийсэн. Уг судалгаагаар 13-17 насны суралцагчдын 24.8 хувь буюу дөрвөн хүүхдийн нэг нь сүүлийн нэг сард электрон тамхи хэрэглэсэн. Цаашлаад 19 сурагчдын нэг нь байнга тамхи татдаг болох нь тогтоогдсон.

Тамхины хэрэглээ хүн амын дунд буурахгүй байгаа нь уг бүтээгдэхүүнийг оруулж ирдэг компаниудтай холбоотой. Шинжлэх ухаанаар аливаа өвчний эрсдэлийг шууд тамхинд өгч болдоггүй. Энэ байдлыг бизнес эрхлэгчид овжин ашиглаж иргэдэд буруу, ташаа ойлголт өгдөг. Тиймээс Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ)-аас тандах, сурталчлах, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ татварын бодлогоор тамхидалтыг бууруулах зөвлөгөөг өгдөг юм.

Тамхинд сайн юм огт байхгүй. Тамхины төрөл нь олширч утаат, усан, электрон гэх мэтээр өөр хэлбэрээр төрөлжүүлж байна. Өнгө, үнэр, амтыг нь өөрчлөөд залуучуудыг уруу татаж байна. Уг нь электрон тамхи нь утаат тамхинаас гаргах зорилгоор анх үйлдвэрлэгдэж байсан боловч энэ чиглэлээ өөрчилж, тамхинд орох зам нь болж хувирсан" гэж онцоллоо.

Иймээс тамхины хэрэглээг бууруулахаас гадна түүний хорт нөлөөг нийгэмд ойлгуулах зорилготой нөлөөллийн арга хэмжээг "Ирээдүйгээ бүү сор" аяны хүрээнд зохион байгуулав.



**ТАМХИДАЛТЫГ  
БУУРУУЛАХ  
НӨЛӨӨЛЛИЙН АЯН**



## ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН ҮНДЭСНИЙ

2022.4.5

Монгол Улсын  
Ерөнхийлөгч У.Хүрэлсүх  
43 тоот зарлиг гаргав



2023.5.12

“Бидний сувилагч Бидний  
ирээдүй” чуулган



2024.4-6 саруудад

Эрүүл Монгол хүн  
өдөрлөг /нийслэлийн  
6 дүүрэг/

2024.1.16

“Хүн амын эрүүл мэнд” сэдэвт  
олон улсын эрдэмтдийн  
зөвлөгөөн



01

02


03

04

05

06

07



2023.4.28

04.28 Эрүүл Монгол  
хүн Үндэсний чуулган



2023.5.31

Эрүүл Монгол хүн фестиваль  
/21 аймаг, 9 дүүрэг/



2024.3.16

Нийгмийн хөгжилд  
эрэгтэйчүүдийн  
оролцоо, манлайлал”  
үндэсний II чуулган

# ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА



**2024.5.13**

“Сувилагч танаараа бахархъя-2024” чуулган



**2024.9.22**

Эрүүл амьдралын экспо



**2024.11.7**

Эрүүл Монгол хүн өдөрлөг Сэлэнгэ аймагт зохион байгуулагдав



**2024.11.9**

Эрүүл Монгол хүн хөдөлгөөний хүрээнд бүх нийтийн спортын арга хэмжээ 21 аймаг, нийслэлийн 9 дүүрэгт зохион байгуулагдав



08

09

10

11

12

13

14

15

**2024.9.21**

9.21 Бүх нийтийн гүйлт арга хэмжээ



**2024.10.17**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор Монголын эмч нарын VII их хурал зохион байгуулагдав



**2024.11.7**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2024 оны 12-р сарын 16-ны өдрийн 47-р захирамжаар “Хавдар судлалын үндэсний хоёрдугаар төв” байгуулахад дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулав.



**2024.12.17**

“Нийгмийн сэтгэл зүйн тулгамдсан асуудлууд” үндэсний зөвлөгөөн зохион байгуулагдав



# ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД БҮХ НИЙТИЙН СПОРТЫН АРГА ХЭМЖЭЭ

## 21 АЙМАГ

### БАЯРХОНГОР АЙМАГТ

**82** АЛБАН  
БАЙГУУЛЛАГА

**5518** ИРГЭД

### БУЛГАН АЙМАГТ

**17** АЛБАН  
БАЙГУУЛЛАГА

**230** ИРГЭД

### ДОРНОД АЙМАГТ

**15** АЛБАН  
БАЙГУУЛЛАГА

**108** ИРГЭД

### ДАРХАН-УУЛ АЙМАГТ

**52** АЛБАН  
БАЙГУУЛЛАГА

**886** ИРГЭД

### ӨВӨРХАНГАЙ АЙМАГТ

**56** АЛБАН  
БАЙГУУЛЛАГА

**4519** ИРГЭД

### СЭЛЭНГЭ АЙМАГТ

**81** АЛБАН  
БАЙГУУЛЛАГА

**9708** ИРГЭД

### ХОВД АЙМАГТ

**80** АЛБАН  
БАЙГУУЛЛАГА

**28552** ИРГЭД

### АРХАЙНГАЙ АЙМАГТ

**70** АЛБАН  
БАЙГУУЛЛАГА

**821** ИРГЭД

### ГОВЬ-АЛТАЙ АЙМАГТ

**10** АЛБАН  
БАЙГУУЛЛАГА

**469** ИРГЭД

### ДУНДГОВЬ АЙМАГТ

**79** АЛБАН  
БАЙГУУЛЛАГА

**591** ИРГЭД

### ЗАВХАН АЙМАГТ

**5** АЛБАН  
БАЙГУУЛЛАГА

**201** ИРГЭД

### ӨМНӨГОВЬ АЙМАГТ

**4** АЛБАН  
БАЙГУУЛЛАГА

**75** ИРГЭД

### ТӨВ АЙМАГТ

**63** АЛБАН  
БАЙГУУЛЛАГА

**13093** ИРГЭД

### ХӨВСГӨЛ АЙМАГТ

**47** АЛБАН  
БАЙГУУЛЛАГА

**1212** ИРГЭД

### ГОВЬСҮМБЭР АЙМАГТ

**11** АЛБАН  
БАЙГУУЛЛАГА

**121** ИРГЭД

### БАЯН-ӨЛГИЙ АЙМАГТ

**27** АЛБАН  
БАЙГУУЛЛАГА

**503** ИРГЭД

### ДОРНОГОВЬ АЙМАГТ

**27** АЛБАН  
БАЙГУУЛЛАГА

**339** ИРГЭД

### ОРХОН АЙМАГТ

**43** АЛБАН  
БАЙГУУЛЛАГА

**567** ИРГЭД

### СҮХБААТАР АЙМАГТ

**55** АЛБАН  
БАЙГУУЛЛАГА

**1458** ИРГЭД

### УВС АЙМАГТ

**16** АЛБАН  
БАЙГУУЛЛАГА

**267** ИРГЭД

### ХЭНТИЙ АЙМАГТ

**45** АЛБАН  
БАЙГУУЛЛАГА

**620** ИРГЭД

НИЙСЛЭЛИЙН 9 ДҮҮРЭГТ

ЗОХИОН БАЙГУУЛАВ

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН А/460  
ДУГААР ЗАХИРАМЖААР МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН САНААЧИЛГААР  
ХЭРЭГЖИЖ БУЙ "ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН"  
ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙГ НИЙСЛЭЛ  
УЛААНБААТАР ХОТОД ЭРЧИМЖҮҮЛЭВ.



19,154  
ИРГЭН ОРОЛЦОВ












ҮРХ ДҮҮРГИЙН МЭНДИЙН ТӨВ  
 БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР  
 БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН БИГИЙН ТАМИР СПОРТЫН ХОРОО  
 БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ХАРЬАА ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВҮҮД  
 БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ХАРЬАА ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВҮҮД


**ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН** ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН








ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН

*Эерэг хандлага - Эрүүл*  
**Мая**  
**Тармаа**  
*Дасгал хөдөлгөө эрүүлээр ган*

*Нээлтийн арга хэмжээ*  
 Элхалт  
 Гүйлт  
 Цугаман бүржиг  
 Тийтийн бүржиг  
 Ажлын байрны дасгал" арга хэмжээ  
 "Өвөл цагийн гүйлт" арга хэмжээ  
 Хийн дасгал










# ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН Үндэсний хөдөлгөөн

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН  
“ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР ХАРИУЦСАН АЛБА



 11-26 29 91

 [www.eruulmongolhun.mn](http://www.eruulmongolhun.mn)

 Эрүүл Монгол хүн хөдөлгөөн